Улсын Их Хурлын
Тамгын Газар

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC

UN
DP

Empowered lives.
Resilient nations.

# НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ХАНДЛАГЫН СУУРЬ ТҮВШИН ТОГТООХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР
2015

DDC
*352.14*
*Н-844*

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ
ИРГЭДИЙН ХАНДЛАГЫН СУУРЬ ТҮВШИН ТОГТООХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Уг судалгааг УИХ-ын Тамгын газраас Швейцарийн хөгжлийн агентлаг,
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй "Нутгийн өөрөө удирдах
байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд
"MMCG" компани хийж гүйцэтгэлээ.
Судалгааг олон улсын судалгааны ёс зүйн ESOMAR-ын стандарт болон Маркетинг,
олон нийтийн санаа бодол, социологийн судалгааны үйлчилгээний (ISO 20252:2012)
стандартын дагуу Улаанбаатар хотын 7 дүүрэг, бүс нутгийн төлөөлөл болсон 5 аймагт
2015 оны 4 дүгээр сард хийж гүйцэтгэв.

Номыг эхийг "Адмон Принт" ХХК-д бэлтгэж хэвлэв.

| | |
|---|---|
| Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: | Н.Шинэжил |
| Хавтасны дизайн: | Н.Шинэжил |
| Хэвлэлийн хуудас: | 13,6 |
| Цаасны хэмжээ: | 172*245 |

ISBN 978-99973-0-620-3

## ГАРЧИГ


ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .... 5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .... 8
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .... 10
УДИРТГАЛ .... 11
ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ .... 12

**БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ** .... 14
1.1. Судалгааны хамрах хүрээ, түүвэр .... 14

**БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА** .... 20
2.1. Судалгааны асуулгыг боловсруулсан байдал .... 20
2.2. Туршилтын судалгаа .... 20
2.3. Сургалт .... 21
2.4. Мэдээлэл цуглуулах ажиллагаа болон чанарын хяналт .... 22
2.5. Фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага .... 22
2.6. Өгөгдөл оруулах, боловсруулах ажиллагаа .... 23

**БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН** .... 24
3.1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .... 24
Тоон судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .... 24
Чанарын судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .... 27

3.2. ИРГЭДИЙН СОНГУУЛИЙН ИДЭВХ БОЛОН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ САНАА БОДОЛ .... 30
3.2.1 Иргэдийн сонгуулийн идэвх .... 30
3.2.2 Сонгуулийн тогтолцооны талаарх ойлголт, хандлага .... 33

3.3. ИТХ-ЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА, ҮНЭЛГЭЭ .... 35
3.3.1 ИТХ-ын талаарх нийтлэг ойлголт .... 35
ИТХ-ын үндсэн чиг үүргийн талаарх иргэдийн ойлголт .... 36
ИТХ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл авдаг эх үүсвэр .... 39
3.3.2 Аймаг/нийслэлийн ИТХ-ын талаар .... 48
Иргэд аймаг/нийслэлийн ИТХ-ын тайлантай танилцсан байдал .... 48
Иргэд аймаг/нийслэлийн ИТХ-ын шийдвэрийн талаар мэддэг байдал .... 51
Иргэд аймаг/нийслэлийн ИТХ-ын шийдвэрийг нэрлэсэн байдал .... 53
Аймаг/нийслэлийн ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн үнэлгээ .... 56
3.3.3 Сум/дүүргийн ИТХ-ын талаар .... 58
Иргэд сум/дүүргийн ИТХ-ын тайлантай танилцсан байдал .... 58

Иргэд сум/дүүргийн ИТХ-ын шийдвэрийг мэддэг байдал .............................. 61
Иргэд сум/дүүргийн ИТХ-ын шийдвэрээс нэрлэсэн байдал .......................... 63
Сум/дүүргийн ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн үнэлгээ ...... 66

3.4. ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА, ҮНЭЛГЭЭ ........................................................................... 70
3.4.1 Аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийг мэддэг байдал ............................ 70
3.4.2 Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийг мэддэг байдал .................................. 73
Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон байдал ..............................79
Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд өгөх үнэлгээ ...................................... 84

3.5. БАГ, ХОРООНЫ ХУРЛЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ОРОЛЦОО ........................................................................... 88

3.6. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА .............................. 101

3.7. ДҮГНЭЛТ ........................................................................................105

**ХАВСРАЛТ**........................................................................................109
Судалгаанд хамрагдсан орон нутгийн талаарх мэдээлэл ............................ 109
Судалгааны асуулга, удирдамж ................................................................... 118
Фокус бүлгийн ярилцлагын удирдамж ...................................................... 128
Ганцаарчилсан ярилцлагын удирдамж ..................................................... 132

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


*Хүснэгт 1. Монгол Улсын сонгуулийн насны нийт хүн амын тоо, 2013 оны эцсийн байдлаар* ... 14
*Хүснэгт 2. Сумдын ангилал бүлэглэлт* ... 15
*Хүснэгт 3. Сонгогдсон сумд, тэдгээрийн ангилал* ... 16
*Хүснэгт 4. Хороодын ангилал бүлэглэлт* ... 16
*Хүснэгт 5. Сонгогдсон хороод, тэдгээрийн ангилал* ... 17
*Хүснэгт 6. Туршилтын судалгаанд оролцогчдын тоо* ... 21
*Хүснэгт 7. Сургалтын ерөнхий агуулга* ... 21
*Хүснэгт 8. Улаанбаатар хотын судалгааны оролцогчдын байршил, дүүргээр* ... 24
*Хүснэгт 9. Хөдөө орон нутгийн судалгаанд оролцогчдын байршил, аймгаар* ... 24
*Хүснэгт 10. Судалгаанд оролцогчдын насны бүтэц, хувиар* ... 25
*Хүснэгт 11. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, хувиар* ... 25
*Хүснэгт 12. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал, хувиар* ... 26
*Хүснэгт 13. Судалгаанд оролцогчдын сууцны төрөл* ... 26
*Хүснэгт 14. Судалгаанд оролцогчдын тухайн байршилдаа амьдарч буй хугацаа* ... 27
*Хүснэгт 15. Судалгаанд оролцогчдын орлогын түвшин* ... 27
*Хүснэгт 16. Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын мэдээлэл* ... 28
*Хүснэгт 17. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл, байршлаар, хувиар* ... 28
*Хүснэгт 18. 2012 оны УИХ-ын болон Орон нутгийн сонгуульд оролцсон байдал, байршлаар, хувиар* ... 30
*Хүснэгт 19. 2016 оны Орон нутгийн сонгуульд оролцох байдал, байршлаар, хувиар* ... 33
*Хүснэгт 20. Тойргоос болон жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид иргэдийг төлөөлөх талаарх иргэдийн санаа бодол, байршлаар, хувиар* ... 34
*Хүснэгт 21. Иргэдийн ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаг эх үүсвэр, байршлаар, хувиар* ... 40
*Хүснэгт 22. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хамгийн их авдаг 5 эх үүсвэр, аймгаар, хувиар* ... 41
*Хүснэгт 23. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хамгийн их авдаг 5 эх үүсвэр, хүйс/насаар, хувиар* ... 43
*Хүснэгт 24. Khural.mn цахим хуудасны талаар иргэд мэддэг эсэх, хувиар* ... 48
*Хүснэгт 25. Аймаг/нийслэлийн ИТХ иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг байдал, хувиар* ... 49
*Хүснэгт 26. Аймаг нийслэлийн ИТХ иргэддээ гаргасан шийдвэрээ мэдээлдэг байдал, хувиар* ... 52
*Хүснэгт 27. Аймаг/нийслэлийн ИТХ-аас гаргасан шийдвэрүүдийг иргэд нэрлэсэн байдал* ... 54

*Хүснэгт 28. НИТХ-ын үйл ажиллагааны талаарх Улаанбаатар хотын иргэдийн үнэлгээ ...... 56*
*Хүснэгт 29. Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ, аймгаар, хувиар ...... 57*
*Хүснэгт 30. Аймгийнхаа ИТХ-д өгсөн үнэлгээ, түүний шалтгаан, аймаг тус бүрээр ...... 57*
*Хүснэгт 31. Дүүргийн ИТХ иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг байдал, дүүргээр, хувиар ...... 59*
*Хүснэгт 32. Сумын ИТХ иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг байдал, сумаар, хувиар ...... 59*
*Хүснэгт 33. Дүүргийн ИТХ иргэддээ гаргасан шийдвэрээ мэдээлдэг байдал, хувиар ...... 62*
*Хүснэгт 34. Сумын ИТХ иргэддээ гаргасан шийдвэрээ мэдээлдэг байдал, сумаар, хувиар ...... 63*
*Хүснэгт 35. Дүүргийн ИТХ-ын үйл ажиллагаанд өгч буй иргэдийн үнэлгээ, дүүргээр, хувиар ...... 67*
*Хүснэгт 36. Дүүргийн ИТХ-ын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ, шалтгаан, дүүргээр ...... 69*
*Хүснэгт 37. Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд өгч буй иргэдийн үнэлгээ, сумаар, хувиар ...... 68*
*Хүснэгт 38. Аймаг/нийслэлийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийг нэрлэсэн байдал, байршлаар, хувиар ...... 70*
*Хүснэгт 39. Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, хугацаа, хувиар ...... 72*
*Хүснэгт 40. Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, байршлаар, хувиар ...... 73*
*Хүснэгт 41. Сум/дүүргийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийг нэрлэх байдал, байршлаар, хувиар ...... 74*
*Хүснэгт 42. Дүүргийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийг нэрлэсэн байдал, хороогоор, хувиар ...... 76*
*Хүснэгт 43. Сонгогдсон сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, байршлаар, хувиар ...... 78*
*Хүснэгт 44. ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон асуудал хэрхэн шийдэгддэг байдал, байршлаар, хувиар ...... 81*
*Хүснэгт 45. Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд өгөх үнэлгээ, байршлаар, хувиар ...... 84*
*Хүснэгт 46. Иргэдийн баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд оролцсон байдал, байршлаар, хувиар ...... 88*
*Хүснэгт 47. Иргэдийн ИНХ-д 2014 онд оролцсон байдал, байршлаар, хувиар ...... 90*
*Хүснэгт 48. Иргэдийн ИНХ-д оролцох цаашдын чиг хандлага, байршлаар, хувиар ...... 98*
*Хүснэгт 49. Иргэдийн ИНХ-д оролцох цаашдын чиг хандлага, иргэдийн 2014 онд хуралд оролцож байсан хандлага, байршлаар, хувиар ...... 100*

*Хүснэгт 50. Иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр гарах үр нөлөө, төлөвлөгчид болон нутгийн удирдлагын хандлага* ................................................ 102
*Хүснэгт 51. Иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр гарах үр нөлөө, иргэдийн хандлага* ................................................................................ 104
*Хүснэгт 52. Дархан-Уул аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн* .................... 109
*Хүснэгт 53. Өвөрхангай аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн* ..................... 111
*Хүснэгт 54. Хөвсгөл аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн* .......................... 113
*Хүснэгт 55. Хэнтий аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн* ........................... 114
*Хүснэгт 56. Ховд аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн* ............................... 116

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

*Зураг 1.* *Судалгаанд хамрагдсан орон нутаг, чиглэл* ............................................ 18
*Зураг 2.* *Бэлтгэсэн газрын зураг дээр судалгаанд хамрагдах өрхүүдийг тэмдэглэсэн байдал* ............................................ 19
*Зураг 3.* *Мэдээлэл цуглуулах ажиллагааны чанарын хяналтын үе шат* ................ 22
*Зураг 5.* *Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид* ............................................ 23
*Зураг 5.* *Ганцаарчилсан ярилцлагад оролцогч* ............................................ 23
*Зураг 6.* *Операторуудын сургалт* ............................................ 23
*Зураг 7.* *Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа, хувиар* ................................ 24
*Зураг 8.* *2012 оны УИХ-ын сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгаан, хувиар* ............................................ 31
*Зураг 9.* *2012 оны Орон нутгийн сонгуульд оролцож, саналаа өгөөгүй шалтгаан, хувиар* ............................................ 31
*Зураг 10.* *Одоогийн сонгуулийн тогтолцооны талаарх иргэдийн санаа бодол, хувиар* ............................................ 34
*Зураг 11.* *Нийслэлийн ИТХ-ын хурлын үйл явц* ............................................ 35
*Зураг 12.* *ИТХ-ын чиг үүргийн талаарх иргэдийн ойлголт, байршлаар, хувиар* ..... 38
*Зураг 13.* *Нутгийн удирдлагын байгууллагуудаас үйл ажиллагаагаа иргэдэд танилцуулдаг ажлын тайлангийн загварууд* ............................................ 44
*Зураг 14.* *ИТХ-ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэмэл материал ирсэн эсэх, хувиар* ............................................ 46
*Зураг 15.* *Иргэдийн хэвлэмэл тайлан, материалтай уншиж танилцсан байдал, хувиар* ............................................ 46
*Зураг 16.* *ИТХ-ын нэгдсэн цахим хуудас* ............................................ 47
*Зураг 17.* *Хөвсгөл аймаг Эрдэнэбулган сумын ИТХ болон ЗДТГ хөдөөгийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, иргэдтэй биечлэн уулзаж санал бодлыг нь сонсож байгаа нь* ............................................ 61
*Зураг 18.* *Иргэдийн нэрлэсэн шийдвэрүүд, жишээ зураг* ....................................... 64
*Зураг 19.* *Иргэдийн нэрлэсэн шийдвэрүүд, жишээ зураг* .......................................66
*Зураг 20.* *Хөвсгөл аймаг, Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын гаднах самбар* ................. 75
*Зураг 21.* *Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон байдал* ........................ 79
*Зураг 22.* *ИТХ-ын төлөөлөгчтэй уулздаг шалтгаан, байршлаар* .......................... 80
*Зураг 23.* *Орон нутгийнхаа ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон байдал, байршлаар* ............................................ 82
*Зураг 24.* *Орон нутгийнхаа ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдоход хүндрэлтэй байдал, байршлаар* ............................................ 82
*Зураг 25.* *Аливаа асуудал тулгарвал хамгийн түрүүнд хандах албан тушаалтан/байгууллага* ............................................ 83
*Зураг 26.* *Иргэдийн төлөөлөгчид тавих шалгуур, чухалчилж үзэж буй хүчин зүйлс* ............................................ 86

*Зураг 27.  Төлөөлөгч хүн хүйсийн хувьд аль нь байвал зохимжтой  талаарх хандлага*........................................................................................... 87
*Зураг 28.  Баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд оролцоогүй шалтгаан, байршлаар, хувиар* .................................. 90
*Зураг 29.  ИНХ-д оролцдоггүй шалтгаан байршилаар, хувиар* ................................ 92
*Зураг 30.  Баг/хорооны хурал хэзээ хаана болох талаарх мэдээллийг олж авдаг сувгууд байршилаар,  хувиар* ...................................................................... 94
*Зураг 31.   ИНХ-аар хэлэлцсэн асуудлууд, Улаанбаатар хот, хувиар* ...................... 96
*Зураг 32.  ИНХ-аар хэлэлцсэн асуудлууд, хөдөө  орон нутаг, хувиар* ......................... 97

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **АН** | Ардчилсан Нам |
| **БГД** | Баянгол дүүрэг |
| **БЗД** | Баянзүрх дүүрэг |
| **ГЯ** | Ганцаарчилсан ярилцлага |
| **ДНБ** | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| **ЗДТГ** | Засаг даргын Тамгын газар |
| **ИЗНН** | Иргэний Зориг Ногоон Нам |
| **ИНХ** | Иргэдийн Нийтийн Хурал |
| **ИТХ** | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| **МАН** | Монгол Ардын Нам |
| **МҮАН** | Монголын Үндэсний Ардчилсан Нам |
| **НД** | Налайх дүүрэг |
| **НИТХ** | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| **НӨУБ** | Нутгийн өөрөө удирдах байгууллага |
| **СБД** | Сүхбаатар дүүрэг |
| **СХД** | Сонгинохайрхан дүүрэг |
| **ТВ** | Телевиз |
| **УИХ** | Улсын Их Хурал |
| **ФБЯ** | Фокус бүлгийн ярилцлага |
| **ХУД** | Хан-Уул дүүрэг |
| **ЧД** | Чингэлтэй дүүрэг |

# УДИРТГАЛ

Монгол Улсын шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдсанаар ардчиллын бодит баталгааны нэг болох нутгийн өөрөө удирдах байгууллагын цоо шинэ тогтолцоо бий болсон билээ. Монгол Улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд нийслэл хот, 21 аймагт, нийслэл хот нь 9 дүүрэг, дүүргүүд нь 152 хороонд, 21 аймаг нь 330 сум, сумд нь 1592 багт хуваагдаж байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь томорч нэгжийн шат өсөх тусам сум, дүүрэг, аймаг, нийслэлийн эрхлэх асуудлыг иргэд нийтээр хуралдан шийдвэрлэх боломжгүй болдог. Ийм учраас иргэд сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан засаглалын үйл ажиллагаанд оролцох "төлөөлөх байгууллага" шаардлагатай байдаг бөгөөд үүнийг төлөөллийн ардчилал ч гэж нэрлэдэг. Үндсэн хуульд "*Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал,,*" хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д *"Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална"*, мөн зүйлийн 8.2-д "*Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн"* гэж тус тус заасан байдаг.

Нутгийн өөрөө удирдах ёс жинхэнэ утгаар хэрэгжихэд иргэдийг төлөөлөх үүрэгтэй Хурлын байгууллагын шийдвэр иргэдийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх, иргэдээс уг байгууллагад үзүүлэх итгэл, иргэд нь уг байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байж, сонгогдсон төлөөлөгчидтэй сонгуулиар дамжуулан болон бусад замаар хариуцлага тооцдог байх нь чухал юм.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн Хөгжлийн агентлаг, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төслийг 2013-2016 онд хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөллийн болон хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх үндсэн зорилготой юм.

Уг төслийг боловрсуулах явцад ИТХ-ын талаарх олон нийтийн санаа бодлын суурь түвшинг тогтоож, төслийн үр нөлөөг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгсэл болгохоор тодорхойлжээ. Үүний зэрэгцээ олон нийтийн төсөөллийн судалгаа нь ИТХ-ын үйл ажиллагааны талаар эмпирик нотолгоо бий болгох, орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд ба сонгогдсон төлөөлөгчдийн харилцааг сайжруулах арга замыг тодорхойлох чухал хэрэгсэл юм.

**"Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох"** судалгааг 2015 оны 2 дугаар сараас 4 дүгээр сарыг дуустал 3 сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ. НӨУБ-ын талаарх олон нийтийн хандлагыг тодорхойлох

энэ удаагийн судалгаа нь **үндэсний хэмжээний анхны судалгаа** байсан бөгөөд судалгаанд 5 аймгийн 15 сум, нийслэл Улаанбаатар хотоос 7 дүүргийн 20 хороог хамруулав. Уг судалгаанд тоон судалгаа болох асуулгын аргаар өрхөөс мэдээлэл цуглуулах, чанарын судалгаа болох иргэдтэй фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулахын зэрэгцээ ИТХ-ын төлөөлөгч, нутгийн удирдлагуудтай ганцаарчилсан ярилцлага хийх гэсэн 3 төрлийн судалгааны аргачлалыг ашиглав. Иргэдээс авсан мэдээллийг ИТХ-ын төлөөлөгчид, ИТХ-ын Ажлын албаны ажилтнууд, Засаг дарга, ЗДТГ-ын ажилтнуудаас авсан мэдээлэлтэй харьцуулан судалж үр дүнг нэгтгэн дэлгэрэнгүй тайланд багтаасан болно.

ИТХ нь бүх нийтийн сонгуулиар байгуулагддаг байгууллага учраас орон нутгийн сонгуульд оролцох иргэдийн идэвх сонирхол, сонгуулийн тогтолцоо нь тэдний төлөөллийг хэрхэн хангаж байгаа талаар иргэдийн санаа бодлыг тандан судалгаа хийлээ (Бүлэг 3.2). НӨУБ-ын талаарх иргэдийн ерөнхий ойлголт, түүний чиг үүрэг, ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг болохыг тодруулсны дараа шат шатны Хурлын байгууллага буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт, хандлага, үнэлгээг судалж (Бүлэг 3.3), ИТХ-ын Төлөөлөгчдийн талаарх иргэдийн ойлголт, хандлага, үнэлгээг хүн амын бүлгүүд, хот, хөдөөгөөр ялган харуулав (Бүлэг 3.3). Түүнчлэн баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд оролцох иргэдийн идэвх, оролцоо (Бүлэг 3.4) болон НӨУБ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцооны цаашдын хандлагыг тодорхойлж гаргалаа (Бүлэг 3.5). Бид судалгааны үр дүнд тулгуурлан НӨУБ-ын өнөөгийн төлөв байдал, цаашдын хандлага, ИТХ болон иргэдийн харилцааг сайжруулахад бодлого болон практикт анхаарах асуудлыг тус тайлангийн эцэст дүгнэлт болгон оруулав (Бүлэг 3.7).

Судалгааны багийн хамт олон Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, нутгийн удирдлагын байгууллагууд, хөгжлийн түншлэгч, иргэний ниймийн болон судалгааны байгууллагуудын цаашдын үйл ажиллагаанд шаардлагатай суурь мэдээллийг бий болгосон хэмээн найдаж байна.

## ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

| Гол үр дүнгүүд | Улаанбаатар хот | Орон нутаг | Дэлгэрэнгүй үр дүнг дараах бүлгээс харна уу. |
|---|---|---|---|
| 2012 оны УИХ-ын сонгуульд оролцож санал өгсөн | 86.6% | 90.7% | Бүлэг 3.2 |
| 2012 оны орон нутгийн сонгуульд оролцож санал өгсөн | 66.4% | 83.1% | Бүлэг 3.2 |
| 2016 оны орон нутгийн сонгуульд оролцож санал өгөх | 90.6% | 92.0% | Бүлэг 3.2 |
| Одоогийн сонгуулийн тогтолцоог оновчтой гэж үзэж буй | 24.5% | 23.6% | Бүлэг 3.2 |
| Тойргоос сонгогдсон төлөөлөгч ард иргэдийг төлөөлж чадна гэж үзэж буй | 33.6% | 46.0% | Бүлэг 3.2 |
| Намын жагсаалтаар сонгогдсон төлөөлөгч ард иргэдийг төлөөлж чадна гэж үзэж буй | 13.6% | 18.3% | Бүлэг 3.2 |
| ИТХ-ын талаар ерөнхий ойлголттой иргэд | 68.0% | 29.0% | Бүлэг 3.3 |

| | | | |
|---|---|---|---|
| ИТХ-ын талаар мэдээлэл авдаг суваг /орон даяар гардаг ТВ/ | 53.0% | 18.6% | Бүлэг 3.3 |
| ИТХ-ын талаар мэдээлэл авдаг суваг /орон нутгийн ТВ/ | 7.2% | 22.0% | Бүлэг 3.3 |
| ИТХ-ын талаар мэдээлэл авдаг суваг /сонин, бусад хэвлэмэл материал/ | 10.8% | 11.3% | Бүлэг 3.3 |
| www.khural.mn цахим хуудасны талаар сонссон | 23.2% | 26.6% | Бүлэг 3.3 |
| Аймаг/нийслэлийн ИТХ үйл ажиллагаагаа иргэдэд тайлагнадаг уу? | 40.8% | 45.3% | Бүлэг 3.3 |
| Аймаг/нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлдэг үү? | 48.4% | 45.5% | Бүлэг 3.3 |
| Аймаг/нийслэлийн ИТХ-аас гаргасан шийдвэрүүдийг нэрлэж чадаж байсан | 34.0% | 23.0% | Бүлэг 3.3 |
| Аймаг/нийслэлийн ИТХ-д “маш сайн” болон “зарим талаар сайн” гэсэн үнэлгээ өгсөн | 18.4% | 27.3% | Бүлэг 3.3 |
| Сум/дүүргийн ИТХ үйл ажиллагаагаа иргэдэд тайлагнадаг уу? | 45.6% | 57.6% | Бүлэг 3.3 |
| Сум/дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлдэг үү? | 36.0% | 54.6% | Бүлэг 3.3 |
| Сум/дүүргийн ИТХ-аас гаргасан шийдвэрүүдийг нэрлэж чадаж байсан | 19.0% | 34.6% | Бүлэг 3.3 |
| Сум/дүүргийн ИТХ-даа “маш сайн” болон “зарим талаар сайн” гэсэн үнэлгээ өгсөн | 18.8% | 34.2% | Бүлэг 3.3 |
| Өөрийн тойргоос сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч зөв нэрлэсэн | 4.8% | 23.7% | Бүлэг 3.4 |
| Өөрийн тойргоос сонгогдсон сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийг зөв нэрлэсэн | 6.4% | 26.3% | Бүлэг 3.4 |
| Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй ямар нэгэн зорилго/асуудлаар уулзаж байсан? | 14.0% | 5.0% | Бүлэг 3.4 |
| Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдож уулзахад хүндрэлтэй байсан | 20.8% | 2.0% | Бүлэг 3.4 |
| Иргэдийн илэрхийлсэн хүсэлт, асуудал, гомдол нь үр дүнтэй шийдэгдсэн байдал | 20.8% | 48.5% | Бүлэг 3.4 |
| Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөө “маш сайн” болон “зарим талаар сайн” гэсэн үнэлгээ өгсөн байдал | 15.0% | 32.7% | Бүлэг 3.4 |
| Баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд оролцсон | 29.8% | 69.4% | Бүлэг 3.5 |
| Өнгөрсөн жил баг/хорооны ИНХ-д оролцсон | 28.0% | 56.7% | Бүлэг 3.5 |
| Цаашид хурлын талаарх мэдээлэл ирвэл оролцох хандлага | 51.8% | 70.0% | Бүлэг 3.5 |

# БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаа нь ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт, тэдний идэвх оролцоог тодруулах үндсэн зорилготой.

Энэ бүлэгт бид судалгаанд ашигласан аргачлал, эхний шатны буюу судалгаанд хамрагдсан аймаг, сум, дүүргийг хэрхэн сонгосон, хоёр дахь шатны түүвэрлэлт болох өрхийн түүвэрлэлтийн талаар авч үзэх болно. Түүвэрлэлт зөв хийгдэж, нийт нутаг дэвсгэр хүн амыг төлөөлж чадахуйц байж, судалгааны аргыг зөв сонгох нь судалгааны үр дүн чанартай байх хамгийн эхний чухал алхам байдаг.

Дээр дурдсан зорилтын хүрээнд дараах тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан хийснээс гадна судалгааны үр дүнг олон талт эх сурвалжаас нягтлах үүднээс иргэд, ИТХ-ын төлөөлөгчид, Засаг дарга нараас зэрэг судалгаа авсан.

**Тоон судалгаа.** Нүүр тулсан ярилцлагын аргаар батлагдсан асуулгын дагуу мэдээлэл цуглуулж, мэдээллийг боловсруулсан.

- *Асуулгын аргаар авсан тоон судалгаа* - Түүврээр сонгогдсон аймаг, дүүрэгт оршин сууж байгаа өрхүүд хамрагдсан.

**Чанарын судалгаа.** Батлагдсан ярилцлагын удирдамжийн дагуу шүүлтүүрээр сонгогдсон иргэд болон албан хаагчдын төлөөлөлтэй цаг товлон ярилцлага явуулж, мэдээллийг цуглуулж боловсруулсан.

- *Ганцаарчилсан ярилцлага (ГЯ)* – Түүврээр сонгогдсон аймаг, дүүрэгт аймаг/нийслэл болон сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, сум/дүүрэг болон баг/хорооны Засаг дарга нар хамрагдсан.
- *Фокус бүлгийн ярилцлага (ФБЯ)* – Түүврээр сонгогдсон нутаг дэвсгэрийн иргэдээс шүүлтүүрээр тэнцсэн хүмүүс хамрагдсан.

## 1.1. Судалгааны хамрах хүрээ, түүвэр

### *Судалгааны түүврийн дизайн*

**Түүврийн хэмжээ.** Судалгааны зорилгоос шалтгаалаад судалгаанд хамрагдах зорилтот нэгжийг 18 ба түүнээс дээш насны буюу сонгуулийн насны Монгол Улсын иргэд байна гэж тодорхойлсон. Судалгаанд оролцогч бүр нь нэг өрхийг төлөөлсөн болно.

***Хүснэгт 1. Монгол Улсын сонгуулийн насны нийт хүн амын тоо, 2013 оны эцсийн байдлаар***

| Шалгуур үзүүлэлт | Нийт хүн ам (мянган хүнээр)[1] |
|---|---|
| Нийт хүн амын тоо | 2 930.3 |
| Үүнээс 18 ба түүнээс дээш насны хүн амын тоо | 1 981.2 |

Монгол Улсад 2013 оны эцсийн байдлаар 18 ба түүнээс дээш насны 1 981.2 мянган хүн ам оршин сууж байв. Энэ нь Монгол Улсын нийт хүн амын 67.7%-ийг эзэлж байгаа юм. Энэхүү статистик тоо мэдээлэлд үндэслэн судалгаанд оролцогчдын тоог дараах байдлаар тогтоосон. Судалгааны түүврийн хэмжээ нь (95%-ийг итгэх завсарт,

[1] Монгол Улсын Статистикийн эмхтгэл-2013

2.5%-ийн алдааны хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хийгдсэн):

$$n = \frac{Z^2 p(1-p)}{e^2} \qquad n = \frac{(1.96)^2 \text{ x } (0.68)(1-0.68)}{(0.025)^2}$$

Энд: n – түүврийн хэмжээ, Z – өгөгдсөн итгэх завсар дахь Z утга, p – тухайн үзэгдлийн илрэх магадлал, e – хүлээн зөвшөөрөгдөх алдааны түвшин

$$n = \frac{0.8417}{0.000625} \qquad n = 1347$$

Дээрх тооцоололд үндэслэн 95%-ийн итгэх завсарт, 2.5%-ийн алдааны хүлээн зөвшөөрөгдөх түвшинд нийт 1200 оролцогч (1200 өрхийг төлөөлсөн)-ийг судалгаанд хамруулав.

Нийт хүн амын тоонд хотын хүн амын эзлэх хувийн жинд үндэслэн түүврийн хэмжээг Улаанбаатар хот болон аймгуудад 500:700 гэсэн харьцаагаар хуваарилсан. Улаанбаатар хот болон аймгуудын түүвэрлэлтийг тус тусад нь 2 өөр аргаар хийсэн.

**Судалгаанд хамрагдах аймаг, сум, дүүргийг сонгох.** Судалгааны түүвэрлэлтийг Улаанбаатар хот ба аймгуудын хувьд ялгаатай байдлаар хийв.

Сумыг сонгохдоо дэд бүтцийн хөгжил, сумын хэмжээ (хүн амын тоо), алслагдсан байдал гэх мэт хүчин зүйлсийг харгалзаж үзсэн. Тиймээс эхний шатны түүвэрлэлтийг хийхдээ дараах шалгуурын дагуу нийт 330 сумыг бүлэглэн, бүлэглэсэн санамсаргүй түүврийн аргаар сумдыг сонгов.

*Хүснэгт 2. Сумдын ангилал бүлэглэлт*

| Шалгуур | Ангилал |
|---|---|
| Газар зүйн код | Газар зүйн код: 1-р төвийн бүс (1), 2-р төвийн бүс (2), зүүн бүс (3), баруун бүс (4) |
| Сумын төрөл | Сумын ангилал: Том хотууд (1), Бусад аймгийн төвүүд (2), Хүн ам төвлөрсөн сум суурин (3), Бусад жижиг хөдөөгийн сумд (4) |
| Сумдын хэмжээ, ангилал | Хүн амын тоо — Код<br>1-2999 — 1<br>3000-5999 — 2<br>6000-9999 — 3<br>10000-12999 — 4<br>13000 болон түүнээс их — 5 |

Эдгээр шалгуурын дагуу сум бүрийг (нийт 330 сум) харгалзах бүлгүүдэд хуваасан. Жишээлбэл, Өмнөговь аймгийн Даланзадгад сум “2/2/5” буюу (2-р төвийн бүс/ аймгийн төвийн сум/13000 болон түүнээс дээш хүн амтай) гэсэн ангилалд багтсан.

Ийнхүү бүх сумыг ангилаад, бүлэг тус бүрээс энгийн санамсаргүй түүврийн аргаар судалгаанд хамрагдах сумдыг сонгосон. Бүлэг тус бүрээс судалгаанд хамрагдах сумдын тоог тодорхойлохдоо Неймaны хуваарилалтын аргыг ашиглан хуваарилж, нийт 5 аймгийн 15 сумыг сонгосон.

*Хүснэгт 3. Сонгогдсон сумд, тэдгээрийн ангилал*

| Аймгийн нэр | Сумын нэр | Сумын код | Өрхийн тоо | Хүн амын тоо | 18-аас дээш насны хүн амын тоо | Стратум |
|---|---|---|---|---|---|---|
| Дархан-Уул | Дархан сум | 1901 | 21576 | 71784 | 49722 | 1/1/5 |
| Өвөрхангай | Арвайхээр сум | 1001 | 8284 | 26007 | 17485 | 1/2/5 |
| Дархан-Уул | Шарын гол сум | 1904 | 2150 | 8121 | 5433 | 1/3/3 |
| Дархан-Уул | Хархорин сум | 1018 | 3628 | 12601 | 8477 | 1/3/4 |
| Дархан-Уул | Гучин-Ус сум | 1008 | 601 | 2235 | 1433 | 1/4/1 |
| Дархан-Уул | Хонгор сум | 1903 | 1529 | 5693 | 3757 | 1/4/2 |
| Хөвсгөл | Мөрөн сум | 1701 | 10571 | 36077 | 25291 | 2/2/5 |
| Хөвсгөл | Эрдэнэбулган сум | 1723 | 765 | 2745 | 1843 | 2/4/1 |
| Хөвсгөл | Тариалан сум | 1711 | 1587 | 5965 | 4029 | 2/4/2 |
| Хэнтий | Хэрлэн сум | 1801 | 6327 | 19317 | 12770 | 3/2/5 |
| Хэнтий | Батноров сум | 1802 | 1778 | 5989 | 3807 | 3/3/2 |
| Хэнтий | Өмнөдэлгэр сум | 1816 | 1634 | 5227 | 3351 | 3/4/2 |
| Ховд | Жаргалант сум | 1601 | 6855 | 25279 | 16972 | 4/2/5 |
| Ховд | Булган сум | 1603 | 2169 | 9018 | 5583 | 4/3/3 |
| Ховд | Манхан сум | 1609 | 940 | 4001 | 2412 | 4/4/2 |

Олон төрлийн ялгаатай шинж чанар бүхий бүлэглэсэн томоохон эх олонлогийн бүлэг тус бүрээс сонгогдох нэгжийн тоог Нейманы хуваарилалтын аргаар тодорхойлох нь илүү ач холбогдолтой байдаг. Энэ аргын дагуу аймгуудаас нийт 700 өрхийг судалгаанд хамруулахаар тодорхойлсон. Иймд судалгаанд хамрагдсан нэг өрх дунджаар 505 өрхийг төлөөлж байгаа болно.

Хороог сонгохдоо хүн амын тоо, хорооны байршил, орон сууцны хэлбэр зэргээр дараах байдлаар ангилав.

*Хүснэгт 4. Хороодын ангилал бүлэглэлт*

| Шалгуур | Ангилал | |
|---|---|---|
| Хорооны төрөл | *Хорооны ангилал:* Төвийн дүүргийн орон сууцны хороод (1), Төвийн дүүргийн гэр хороололтой хороод (2), Төвийн дүүргийн орон сууц болон гэр хороололтой хороод (3), Захын дүүргийн орон сууцны хороод (4), Захын дүүргийн гэр хороололтой хороод (5), Захын дүүргийн орон сууц болон гэр хороололтой хороод (6) | |
| Хорооны хэмжээ, ангилал | Хүн амын тоо | Код |
| | 1-4999 | 1 |
| | 5000-7999 | 2 |
| | 8000-9999 | 3 |
| | 10000-12999 | 4 |
| | 13000 болон түүнээс их | 5 |

Дээрх ангиллын дагуу Улаанбаатар хотын нийт 152 хороог тодорхой бүлгүүдэд ангилсан. Жишээлбэл, Чингэлтэй дүүргийн 1-р хороог "1/1" буюу (төвийн дүүргийн орон сууцны хороо/1-4999 хүн амтай) гэсэн ангилалд багтаасан.

Бүх хороог бүлэглэсний дараа Нейманы хуваарилалтын аргын дагуу бүлэг тус бүрээс сонгогдох хорооны тоог тодорхойлон, үүний дагуу бүлэглэсэн санамсаргүй түүврийн аргаар Улаанбаатар хотын 7 дүүргийн 20 хороог судалгаанд хамруулахаар сонгосон.

*Хүснэгт 5. Сонгогдсон хороод, тэдгээрийн ангилал*

| Дүүрэг | Дүүргийн код | Баг/Хороо | Баг/ Хорооны код | Өрхийн тоо | Хүн амын тоо | 15-60 насны хүн ам | Стра-тум |
|---|---|---|---|---|---|---|---|
| Чингэлтэй | 2007 | 1-р хороо | 200701 | 918 | 3213 | 2191 | 1/1 |
| Чингэлтэй | 2007 | 4-р хороо | 200704 | 1497 | 5334 | 3638 | 1/2 |
| Сонгино-хайрхан | 2009 | 14-р хороо | 200914 | 1402 | 5290 | 3608 | 1/2 |
| Баянзүрх | 2003 | 7-р хороо | 200307 | 1714 | 7191 | 4904 | 1/2 |
| Сүхбаатар | 2006 | 10-р хороо | 200610 | 2060 | 8340 | 5688 | 1/3 |
| Хан-Уул | 2001 | 3-р хороо | 200103 | 2820 | 10938 | 7460 | 1/4 |
| Баянгол | 2005 | 6-р хороо | 200506 | 4252 | 14846 | 10125 | 1/5 |
| Сүхбаатар | 2006 | 20-р хороо | 200620 | 1020 | 2900 | 1978 | 2/1 |
| Баянгол | 2005 | 11-р хороо | 200511 | 1613 | 6427 | 4383 | 2/2 |
| Сүхбаатар | 2006 | 15-р хороо | 200615 | 1628 | 6588 | 4493 | 2/2 |
| Сүхбаатар | 2006 | 14-р хороо | 200614 | 1490 | 6033 | 4115 | 2/2 |
| Сүхбаатар | 2007 | 19-р хороо | 200719 | 2641 | 9906 | 6756 | 2/3 |
| Сонгино-хайрхан | 2009 | 24-р хороо | 200924 | 2668 | 9934 | 6775 | 2/3 |

Улаанбаатар хотоос нийт 500 өрхийг судалгаанд хамруулахаар тодорхойлсон нь судалгаанд хамрагдсан нэг өрх дунджаар 634 өрхийг төлөөлж байгаа юм.

### *Судалгааны хамрах хүрээ*

Судалгааны үндсэн түүвэрлэлтийн аргын дагуу сонгогдсон нутаг дэвсгэрийн тархалтыг дараах газрын зургаас харж болно. Өөр хоорондоо ялгаатай шинж чанар бүхий аймаг, хөдөөгийн сумд болон нийслэл хотын хороодыг ангилал тус бүрт нь хуваарилж, ангилал тус бүрээс төлөөллийг санамсаргүйгээр сонгосон. Ийнхүү олон шаттай түүвэрлэлтийн аргачлалын дагуу судалгааг Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, захын 1 дүүргийн нийт 20 хороо, бүс нутгийн төлөөлөл болсон 5 аймгийн 15 сумыг хамруулан гүйцэтгэв.

### *Зураг 1. Судалгаанд хамрагдсан орон нутаг, чиглэл*




Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын хороод болон хөдөө орон нутгийн сумд ямар бүлгийг төлөөлж байгаа болохыг *(Хавсралт 5.1.1)*-ээс харж болно. *Жишээлбэл:*

- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо - (1/5) – (1) Төвийн дүүргийн орон сууцны хороо, (5) 13000 ба түүнээс дээш хүн амтай
- Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 1-р хороо – (5/2) – (5) Захын дүүргийн орон сууц болон гэр хороолoлтой хороо, (2) 5000-7999 хүн амтай
- Өвөрхангай аймаг, Хархорин сум – (1/3/4) – (1) 1-төвийн бүс, (3) Хүн ам төвлөрсөн сум суурин, (4) 10000-12999 хүн амтай сум
- Хөвгөл аймаг, Мөрөн сум – (2/2/5) – (2) 2-р төвийн бүс, (2) Бусад аймгийн төвүүд, (5) 13000 ба түүнээс дээш хүн амтай

### *Өрхийн түүвэрлэлт*

Судалгааны түүвэрлэлтийн эхний шатанд судалгаанд хамрагдах нутаг дэвсгэрийг бүхлээр нь сонгосон бол түүвэрлэлтийн хоёр дахь шатанд судалгаанд хамрагдах өрхийг сонгосон. Ингэхдээ эхлээд түүврээр сонгогдсон нутаг дэвсгэр бүрийн газрын зургийг бэлтгэсэн. Газрын зургийг тухайн байршилд оршин сууж байгаа өрхийн суурьшлын нягтралаас хамааран 2.00-2.10 км-ийн өндөр дээрээс татсан сансрын зургийг ашигласан. Ингэснээр Улаанбаатар хотын хороод том жижгээс нь хамааруулан газрын зургийг хамгийн багадаа 1 зураг, хамгийн ихдээ 16 зурагт хуваaж бэлтгэсэн. Харин сумдын хувьд багуудыг хамруулан мөн адил том жижгээс нь хамаарч 1-5 тусдаа зураг бэлтгэсэн.

Ийнхүү судалгаанд хамрагдах өрхийг сонгохдоо судалгаа авахаар сонгогдсон байршлын газрын зургийг ашиглан талбарт суурилсан түүврийн хүрээг бэлтгэж, нэгж өрхийг төлөөлөх дөрвөлжин нүднүүдэд хуваан, нүд тус бүрийг дугаарлаж, дугаарлагдсан нүд буюу өрхийн жагсаалтаас энгийн санамсаргүй түүврийн аргаар

MS-Excel программын RANDBETWEEN функцыг ашиглан өрх бүрт санамсаргүй тоо өгч, өгөгдсөн санамсаргүй тоогоор нь эрэмбэлэн судалгаанд хамрагдах өрхийг санамсаргүй байдлаар сонгосон.

***Зураг 2. Бэлтгэсэн газрын зураг дээр судалгаанд хамрагдах өрхүүдийг тэмдэглэсэн байдал***




Ийнхүү талбарт суурилсан түүврийн хүрээг судалгааны мэдээлэл цуглуулалтын үед ашиглах нь дараах давуу талыг агуулдаг. Үүнд:

- Мэдээлэл цуглуулах цаг хугацааг хэмнэдэг;
- Сонгогдсон нэгж нь тухайн байршилд байхгүй байх, шилжээд явсан байх зэрэг хүндрэл гарахгүй;
- Мэдээлэл цуглуулах ажиллагааны чанарын хяналтыг сайжруулдаг;
- Өрхийн судалгаанд тохиромжтой;
- Түүврийн хүрээг боловсруулахад хялбар.

Сонгогдсон өрхийг төлөөлөн судалгаанд оролцох оролцогчийг сонгохдоо Киш гридийн аргыг ашигласан. Сонгогдсон өрхөд зочилсны дараа 18 ба түүнээс дээш настай өрхийн гишүүдийг насны дараалаар нь эрэмбэлж, Киш гридийн хүснэгтийн дагуу хэд дэх хүнээс нь судалгаа авахыг тодорхойлдог арга юм. Ингэснээр өрхийн гишүүдээс судалгаанд оролцогчийг санамсаргүй түүврийн аргаар сонгох боломжтой болдог. Энэ нь гэртээ суудаг, ажилгүй хүмүүс эсвэл гэрийн эзэгтэй голлон хамрагдах сул талыг арилгаж байгаа юм.

# БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.1. Судалгааны асуулгыг боловсруулсан байдал

Тоон судалгааны асуулга болон фокус бүлгийн ярилцлагын удирдамж, ганцаарчилсан ярилцлагын удирдамжийг боловсруулахад дараах материалыг ашигласан бөгөөд судалгааны асуулга, удирдамжийг туршилт судалгааны явцад тухай бүр засч сайжруулсан болно. Үүнд:

- *Монгол Улсын Үндсэн хууль*
- *Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, 2012*
- *Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2011*
- *Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, /шинэчилсэн найруулга/, 2006*
- *Үндсэн хуулийн мэдлэг, Б.Чимид, 2008.*
- *Салбарын шинжилгээ: Монгол Улсын нутгийн өөрөө удирдах байгууллага – НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, 2013*
- *Орон нутгийн иргэдийн оролцоог үнэлэх өөрийн үнэлгээний аргачлал, Европын холбоо, 2008*
- www.khural.mn *цахим хуудсанд тавигдсан холбогдох нийтлэлүүд*
- *Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: Төлөөлөгчдөд зориулсан сургалтын гарын авлага,УИХ-ын Тамгын газар, НҮБХХ, Удирдлагын академи, Швейцарийн хөгжлийн агентлаг, 2014, Улаанбаатар хот*
- *"Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог дэмжих нь" хөтөлбөрийн суурь судалгааны тайлан, 2013, Швейцарийн хөгжлийн агентлаг, Азийн Сан, IRIM*

НҮБХХ-ийн Засаглалын баг тоон судалгааны асуулга, фокус бүлгийн ярилцлагын удирдамжийг боловсруулахад үнэтэй зөвлөгөө, чиглэл өгсөн бөгөөд судалгааны асуулга, удирдамжийг сайжруулах, холбогдох талуудын саналыг тусгах зорилготой уулзалтыг 2015 оны 3 дугаар сарын 11-нд зохион байгуулсан. Уулзалтад: MMCG ХХК, НҮБХХ-ийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төслийн баг, УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, Нутгийн удирдлагын холбоо, IRIM ХХК зэрэг байгууллагын төлөөлөл оролцож санал, зөвлөмж өгсөн нь судалгааны асуулгыг сайжруулахад маш ач холбогдолтой болсон юм.

Тоон судалгааны асуулга, фокус бүлгийн ярилцлагын удирдамж, ганцаарчилсан ярилцлагын удирдамжийг Хавсралтаас харна уу.

## 2.2. Туршилтын судалгаа

Тоон болон чанарын судалгааны асуулга, удирдамж, мэдээлэл цуглуулах аргыг турших судалгааг 2015 оны 2 дугаар сарын 25-28-нд Улаанбаатар хот, Төв аймгийн Зуунмод, Эрдэнэ суманд тус тус зохион байгуулав.

Туршилтын судалгаанд нийт 19 өрх, ИТХ-ын төлөөлөгч, аймгийн Засаг дарга болон баг/хорооны Засаг дарга зэрэг 8 албан тушаалтан хамрагдсанаас гадна 6 үндсэн оролцогчтой 1 удаагийн фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан.

*Хүснэгт 6. Туршилтын судалгаанд оролцогчдын тоо*

| | Асуулгын төрөл | Зорилтот бүлэг | Улаанбаатар хот | Төв аймгийн Зуунмод сум | Төв аймгийн Эрдэнэ сум | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоон судалгааны асуулга | Өрх | 10 | 5 | 3 | 18 |
| 2 | Ганцаарчилсан ярилцлагын удирдамж | ИТХ-ын төлөөлөгч | 2 | 1 | 1 | 4 |
| | | Баг/хорооны Засаг дарга | 1 | 1 | 1 | 3 |
| 3 | Фокус бүлгийн ярилцлагын удирдамж | Иргэд | 1 бүлгийн ярилцлага */6 оролцогчтой/* | | | 1 |

Ийнхүү судалгааны асуулгатай холбоотой гарсан асуудлуудыг нэг бүрчлэн тодруулах, асуулгаа дахин сайжруулахад туршилтын судалгаа чухал ач холбогдолтой болсон юм.

## 2.3. Сургалт

Судалгааны ярилцлага авагч нарыг бэлтгэх сургалтыг 2015 оны 3 дугаар сарын 13-16-нд зохион байгуулав. Танхимын сургалтад нийт 27 хүн хамрагдсанаас танхимын туршилтын гүйцэтгэл, ур чадвараар нь 24 ярилцлага авагчийг шалгаруулан, дараагийн шатны сургалтад хамруулсан болно. 2015 оны 3 дугаар сарын 16-нд практик сургалт хийж, бүх ярилцлага авагчдыг 3 багт хуваан багийн ахлагчдын хамт БЗД-ийн 12, 13 дугаар хороонд ажиллуулсан. Нэг ярилцлага авагч 2-3 өрхөд багийн ахлагчийн хамт зочилж ярилцлага авсан болно.

Танхимын болон дадлагажуулах сургалтыг дараах хөтөлбөрийн дагуу зохион байгуулав.

*Хүснэгт 7. Сургалтын ерөнхий агуулга*

| Танхимын сургалт | Дадлагажих сургалт |
|---|---|
| - Судалгааны зорилго, ажлын зохион байгуулалт<br>- Судалгааны багийн гишүүдийн ажил, үүрэг<br>- Судалгааны мэдээлэл цуглуулах шат дараалал<br>- Судалгааны асуулгыг хэрхэн бөглөх заавар<br>- Танхимын дадлага<br>- Гэрт дадлага хийх | - Гэрт хийсэн дадлагын үр дүнгийн талаар ярилцах<br>- Зорилтот газарт очиж судалгаа авах<br>- Үр дүн, тулгарсан асуудал, ойлгомжгүй зүйлсийн талаар хэлэлцэх<br>- Шалгалт авах |

Ижил төстэй судалгаанд ярилцлага авагчаар ажиллаж байсан туршлага, газрын зурагтай ажиллах чадвар, судалгааны зорилго, агуулгатай холбоотой зүйлсийг ойлгосон байдал, ярилцлага хийх ур чадвар зэргийг харгалзан үзэж, 18 ярилцлага авагчийг судалгааны үндсэн ярилцлага авагчаар сонгон ажиллуулсан.

## 2.4. Мэдээлэл цуглуулах ажиллагаа болон чанарын хяналт

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Улаанбаатар хотод 2015 оны 3 дугаар сарын 18-25-нд түүвэрт сонгогдсон аймгуудад 3 дугаар сарын 25-наас 4 дүгээр сарын 4-нд тус тус зохион байгуулав. Мэдээлэл цуглуулах ажил нийт 18 хоног үргэлжилсэн болно. Чанарын хяналтыг мэдээлэл цуглуулах ажиллагаатай зэрэг хийж гүйцэтгэлээ.

***Зураг 3. Мэдээлэл цуглуулах ажиллагааны чанарын хяналтын үе шат***

1. Багийн ахлагч судалгааны асуулгыг бөглөсөн байдал болон логик алдааг шалгах.
2. Логик болон бөглөлтийн алдааг тэмдэглэсэн асуулгуудыг утсаар шалгах хяналтад шилжүүлэх.
3. Утас нь холбогдох боломжгүй, утсаа аваагүй, дугаар ашиглалтанд байхгүй зэрэг асуудалтай асуулгуудыг хяналтад оруулах.

Чанарын хяналтыг 90% утсаар эргэн холбогдож, 10% гэрээр эргэн зочлох, 100% ярилцлагын аудио бичлэгийг сонсох байдлаар зохион байгуулж, бөглөгдсөн асуулга тус бүрт хяналтын хуудсыг хавсаргасан болно.

- Утсаар шалгах (100%). Офис дээр ажиллаж буй хянагч нь асуулгын хуудсаас тодорхой асуултуудыг дахин асууж ярилцлага авагчийн хариулттай тулгах замаар шалгасан.
- Гэрээр зочлох (Зөвхөн Улаанбаатарт). Судалгаанд оролцогчийн хаягаар зочилж бөглөгдсөн асуулгын хуудсаас тодорхой асуултуудыг дахин асууж ярилцлага авагчийн хариулттай тулгах замаар шалгасан.
- Гэнэтийн шалгалт. Мэдээлэл цуглуулах хугацаанд мэдээлэл цуглуулагчдыг талбар дээрээ ажиллаж байгаа, өрхүүдийг зөв олж судалгаа авч байгаа, судалгаанд оролцогчийг зөв сонгож байгаа эсэхийг хянах зорилготой гэнэтийн шалгалт 2 удаа хийв.

Утсаар болон гэрээр шалгахдаа дараах тогтсон асуултуудаас гадна тодруулах шаардлагатай, эргэлзээтэй гэсэн асуултыг дахин асууж, хяналтын хуудсыг бөглөн судалгааны асуулгад хавсаргасан бөгөөд хяналтын хуудас хавсаргасан асуулгуудыг шивэлтэд оруулсан болно.

## 2.5. Фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага

Иргэдийг оролцуулсан фокус бүлгийн ярилцлагыг 6 үндсэн оролцогчтойгоор нийт 11 удаа зохион байгуулав. ФБЯ-ын оролцогчдыг сонгохын тулд эхлээд 900 гаруй иргэдтэй уулзаж, шүүлтүүр асуулгыг авсан. Нэг ФБЯ-д оролцогчдыг сонгохдоо нас хүйсийн харьцаа, сууцны төрөл, тухайн газарт амьдарч байгаа хугацаа, ИНХ-д оролцох идэвх, сонгуульд оролцсон байдал, ИТХ болон төлөөлөгчдийн талаарх мэдлэг, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал зэрэг үндсэн үзүүлэлтийг харгалзан, шинж чанаруудыг хангасан хүмүүсийг тэнцвэртэйгээр сонгож ярилцлагад

урьж оролцуулсан.

*Зураг 5: Ганцаарчилсан ярилцлагад оролцогч*



*Зураг 5: Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид*



Судалгааны явцад нийт 19 ганцаарчилсан ярилцлага хийсэн. Судалгааны түүврийн эхний шатанд сонгогдсон нутаг дэвсгэрийн ИТХ-ын төлөөлөгчид, сум/дүүргийн Засаг дарга нар болон баг/хорооны Засаг дарга нарыг сонгож ярилцлагыг хийсэн. Ингэснээр тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн санал бодол болон төлөөлөгчдийн санал бодлын ижил болон ялгаатай талыг харьцуулан харах боломжтой болж байгаа юм.

## 2.6. Өгөгдөл оруулах, боловсруулах ажиллагаа

Программд мэдээллийг шивж оруулахын өмнө операторуудад судалгааны асуулгыг танилцуулж, хэрхэн шивэх, программ ямар бүтэцтэй байгаа, анкетний аль хэсэгт анхааралтай ажиллах болон анкет дээр асуудал гарсан тохиолдолд ямар арга хэмжээ авах зэргийг тайлбарлаж мэргэшсэн операторуудад сургалт хийсэн.

Мэдээллийн системд мэдээллийг CSPro-5.03 программ дээр хийж гүйцэтгэсэн бөгөөд өгөгдлийн сан руу мэдээллийг шивж оруулахдаа давхар шивэлт хийсэн болно. Давхар шивэлтийн дараа үүссэн 2 багц дата программын “Compare data” модулиудыг ашиглан шивэлтийн алдааг шалгаж алдаагүй мэдээллийн санг үүсгэсэн болно. Судалгааны мэдээллийг IMB SPSS-20.0 программ ашиглан боловсруулсан.

Чанарын судалгааны хувьд фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын бүх аудио бичлэгийг шивж, файл болгон бэлтгэсэн.

*Зураг 6. Операторуудын сургалт*



# БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ бүлэгт судалгааны НЭГДСЭН ҮР ДҮНГ бүлэг тус бүрийн дагуу харуулав. Нэгдсэн үр дүнг гаргахдаа тоон судалгааны үр дүнг хүснэгт болон графикаар, чанарын судалгааны үр дүнг ишлэл хэлбэрээр оруулав.

## 3.1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### *Тоон судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл*

Судалгаанд Улаанбаатар хотын нийт 500 өрх, сонгогдсон аймгуудын 700 өрх хамрагдсан. Улаанбаатар хотын хувьд Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргээс тус бүр 4 хороог сонгосон. Харин алслагдсан дүүргүүдийн төлөөлөл болгон Налайх дүүргийн 3 хороог хамруулсав.

*Хүснэгт 8. Улаанбаатар хотын судалгааны оролцогчдын байршил, дүүргээр*

| Дүүрэг | Тоо | Хувь |
|---|---|---|
| Баянгол дүүрэг | 51 | 10.2 |
| Баянзүрх дүүрэг | 81 | 16.2 |
| Чингэлтэй дүүрэг | 76 | 15.2 |
| Сонгинохайрхан дүүрэг | 113 | 22.6 |
| Сүхбаатар дүүрэг | 101 | 20.2 |
| Хан-Уул дүүрэг | 32 | 6.4 |
| Налайх дүүрэг | 46 | 9.2 |
| **Нийт** | 500 | 100 |




Түүврийн эхний шатанд сонгогдсон бүс нутгийн төлөөлөл болсон 5 аймгийн 15 сумаас тоон судалгааны мэдээллийг цуглуулсан. Сонгогдсон аймаг тус бүрээс дараах тооны өрхөөс судалгаа авав.

*Хүснэгт 9. Орон нутгийн судалгаанд оролцогчдын байршил, аймгаар*

| Аймаг | Тоо | Хувь |
|---|---|---|
| Дархан-Уул аймаг | 143 | 20.4 |
| Өвөрхангай аймаг | 164 | 23.4 |
| Хөвсгөл аймаг | 116 | 16.6 |
| Хэнтий аймаг | 171 | 24.4 |
| Ховд аймаг | 106 | 15.1 |
| **Нийт** | 700 | 100 |

*Зураг 7 Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа, хувиар*



Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл Монгол Улсын нийт хүн амын ерөнхий үзүүлэлтүүдтэй ойролцоо байгааг доорх үр дүнгээс харж болно. Энэ нь судалгааны түүврийн төлөөлөх чадвар сайн байгааг харуулж байгаа хэрэг юм.

Монгол Улсад 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар оршин суугаа хүн амын хүйсийн харьцаа эрэгтэй 48.7%, эмэгтэй 51.3% байжээ. Энэ удаагийн судалгааны хувьд Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын 48% нь эрэгтэй, 52% нь эмэгтэй байна. Харин хөдөө орон нутгийн судалгаанд оролцогчдын 46% нь эрэгтэй, 54% нь эмэгтэй байна.

Насны хувьд 18 ба түүнээс дээш насны (өөрөөр хэлбэл, сонгуулийн насны) иргэдийг сонгож судалгаанд хамруулсан. Судалгаанд оролцогчдын дундаж нас 43.5 байна. Судалгаанд оролцогчдын насны бүтэц Монгол Улсын нийт хүн амын насны бүтэцтэй ерөнхийдөө таарч байна.

*Хүснэгт 10. Судалгаанд оролцогчдын насны бүтэц, хувиар*

| Насны бүлэг | Нийт | | Улаанбаатар хот (хувь) | Орон нутаг (хувь) |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | | |
| 18-24 | 95 | 7.9 | 11.4 | 5.4 |
| 25-29 | 165 | 13.8 | 12.2 | 14.9 |
| 30-34 | 128 | 10.7 | 10.8 | 10.6 |
| 35-39 | 138 | 11.5 | 12.0 | 11.1 |
| 40-44 | 135 | 11.3 | 10.2 | 12.0 |
| 45-49 | 139 | 11.6 | 9.4 | 13.1 |
| 50-54 | 134 | 11.2 | 8.0 | 13.4 |
| 55-59 | 86 | 7.2 | 8.8 | 6.0 |
| 60 ба түүнээс дээш | 180 | 15.0 | 17.2 | 13.4 |
| **Нийт** | 1200 | 100 | 100 | 100 |

Оролцогчдын боловсролын түвшний хувьд бүрэн дунд боловсрол эзэмшсэн оролцогчид хамгийн өндөр буюу 46%-ийг эзэлж байна. Улаанбаатар хотын хувьд бакалавр болон түүнээс дээш боловсролтой оролцогчид 33%-ийг эзэлж байгаа бол орон нутгийн оролцогчдын 20% нь бакалавр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Монгол Улсын Хүн ам, орон сууцны нэгдсэн тооллогын 2010 оны судалгааны дүнгээс харахад 18 ба түүнээс дээш насны Монгол Улсын хүн амын 92.5% нь боловсролтой, 7.5% нь огт боловсрол эзэмшээгүй гэжээ. Энэхүү судалгаанд оролцогчдын 98.8% нь боловсролтой, 1.2% нь огт боловсрол эзэмшээгүй хүн байв.

*Хүснэгт 11. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, хувиар*

| Боловсролын түвшин | Нийт | | Улаанбаатар хот (хувь) | Орон нутаг (хувь) |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | | |
| Магистр/доктор болон түүнээс дээш | 27 | 2.3 | 4.6 | 0.6 |
| Бакалаврын болон дипломын дээд боловсролтой | 283 | 23.6 | 29.0 | 19.7 |
| Бүрэн дунд боловсролтой | 555 | 46.3 | 45.8 | 46.6 |
| Тусгай дунд боловсролтой | 114 | 9.5 | 8.8 | 10.0 |
| Бүрэн бус дунд боловсролтой | 164 | 13.7 | 10.0 | 16.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бага боловсролтой | 42 | 3.5 | 1.2 | 5.1 |
| Боловсрол эзэмшээгүй | 14 | 1.2 | 0.6 | 1.6 |
| Хариулахаас татгалзсан | 1 | 0.1 | 0.0 | 0.1 |
| **Нийт** | 1200 | 100 | 100 | 100 |

Харин судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдлыг харахад 18% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 14% нь төрийн болон төсвийн байгууллагад, 15% нь хувийн байгууллагад ажиллаж байна. Нийт судалгаанд оролцогчдын 9% буюу 112 нь малчин өрх байв.

*Хүснэгт 12. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал, хувиар*

| Ажил эрхлэлт | Нийт | | Улаанбаатар хот (хувь) | Орон нутаг (хувь) |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | | |
| Төрийн болон төсвийн байгууллага | 172 | 14.3 | 9.4 | 17.9 |
| Төрийн бус байгууллага/ОУБ | 8 | 0.7 | 1.2 | 0.3 |
| Хувийн байгууллага | 174 | 14.5 | 19.6 | 10.9 |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 213 | 17.8 | 20.0 | 16.1 |
| Малчин | 112 | 9.3 | 0.0 | 16.0 |
| Оюутан | 48 | 4.0 | 8.2 | 1.0 |
| Тэтгэвэрт | 229 | 19.1 | 23.2 | 16.1 |
| Группт | 33 | 2.8 | 3.2 | 2.4 |
| Ажил эрхлэхгүй байгаа | 202 | 16.8 | 14.6 | 18.4 |
| Бусад | 7 | 0.6 | 0.4 | 0.7 |
| Хариулахаас татгазлзсан | 2 | 0.2 | 0.2 | 0.1 |
| **Нийт** | 1200 | 100 | 100 | 100 |

Судалгаанд оролцогчдын сууцны төрлийг харахад гэрт амьдардаг өрх хамгийн өндөр хувь буюу 41%-ийг эзэлж байна. Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр улсын нийт өрхийн 45% нь гэрт, 54% нь байшин болон орон сууцанд амьдарч байжээ. Сууцны төрлийн байршлын хувьд Улаанбаатар хотын оролцогчдын 30% нь  гэрт, 32% нь хашаа байшинд, 36% нь орон сууцанд амьдарч байна. Харин хөдөө орон нутгийн оролцогчдын 49% нь гэрт, 40% нь хашаа байшинд, 10% нь орон сууцанд амьдарч байна.

*Хүснэгт 13. Судалгаанд оролцогчдын сууцны төрөл*

| Сууцны төрөл | Нийт | | Улаанбаатар хот (хувь) | Орон нутаг (хувь) |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | | |
| Монгол гэр | 493 | 41.1 | 30.0 | 49.0 |
| Хашаа байшин | 442 | 36.8 | 32.4 | 40.0 |
| Орон сууц | 253 | 21.1 | 36.4 | 10.1 |
| Нийтийн байр | 6 | 0.5 | 0.6 | 0.4 |
| Хувийн хаус | 1 | 0.1 | 0.2 | 0.0 |
| Бусад | 5 | 0.4 | 0.4 | 0.4 |
| **Нийт** | 1200 | 100 | 100 | 100 |

Одоогийн байршилдаа хэр удаан амьдарч байгааг нь харахад тухайн байршилдаа удаан хугацаагаар амьдарч байгаа өрх дийлэнх хувийг эзэлж байна.

Амьдарч буй хугацааг байршлаар харахад, Улаанбаатар хотын оролцогчдын тухайн байршилдаа амьдарч буй жил хөдөө орон нутгийн оролцогчдыхтой харьцуулахад

харьцангуй бага байна. Өөрөөр хэлбэл, нэг жил хүртэлх хугацаанд тухайн байршилдаа амьдарч байгаа өрх 13%, 1-2 жил амьдарч байгаа өрх 11%, 3-5 жил амьдарч байгаа өрх 17%, 6-10 жил амьдарч байгаа өрх 20%, 11 болон түүнээс дээш жил амьдарч байгаа өрх 38% байна. Харин хөдөө орон нутгийн оролцогчдын хувьд тухайн байршилдаа 1 жил хүртэлх хугацаагаар амьдарч байгаа өрх 5%, 1-2 жил амьдарч байгаа 7%, 3-5 жил амьдарч байгаа 14%, 6-10 жил амьдарч байгаа 14% байгаа бол 11 болон түүнээс дээш жил амьдарч байгаа өрх 60%-ийг эзэлж байна.

*Хүснэгт 14. Судалгаанд оролцогчдын тухайн байршилдаа амьдарч буй хугацаа*

| Амьдарсан хугацаа | Нийт | | Улаанбаатар хот (хувь) | Орон нутаг (хувь) |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | | |
| 6 сараас 1 жил хүртэл | 97 | 8.1 | 13.0 | 4.6 |
| 1-2 жил | 109 | 9.1 | 11.4 | 7.4 |
| 3-5 жил | 181 | 15.1 | 16.8 | 13.9 |
| 6-10 жил | 202 | 16.8 | 20.4 | 14.3 |
| 11 ба түүнээс дээш жил | 611 | 50.9 | 38.4 | 59.9 |
| **Нийт** | 1200 | 100 | 100 | 100 |

Судалгаанд оролцогчдын өрхийн орлогын түвшинг тодруулахад 200.000-500.000 хүртэлх төгрөгийн сарын орлоготой өрх 452 буюу 38% нь байна. Харин Улаанбаатар хотын хувьд 500.000 төгрөг, түүнээс дээш өрхийн орлоготой өрх 56%-ийг эзэлж байна.

*Хүснэгт 15. Судалгаанд оролцогчдын орлогын түвшин*

| Орлогын түвшин | Нийт | | Улаанбаатар хот (хувь) | Орон нутаг (хувь) |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | | |
| 200.000 төгрөг хүртэл | 233 | 19.4 | 10.0 | 26.1 |
| 200.001-500.000 төгрөг | 452 | 37.7 | 32.4 | 41.4 |
| 500.001-1.000.000 төгрөг | 345 | 28.8 | 37.8 | 22.3 |
| 1.000.001-1.500.000 төгрөг | 79 | 6.6 | 10.4 | 3.9 |
| 1.500.001-2.000.000 төгрөг | 36 | 3.0 | 5.4 | 1.3 |
| 2.000.001 төгрөг, түүнээс дээш | 17 | 1.4 | 2.6 | 0.6 |
| Хариулахаас татгалзсан | 38 | 3.2 | 1.4 | 4.4 |
| **Нийт** | 1200 | 100 | 100 | 100 |

### *Чанарын судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл*

Ганцаарчилсан ярилцлагад оролцогчид ярилцлага хийхдээ эхлээд утсаар эсвэл ажлын албанаас нь зөвшөөрөл авсны дараа цаг товлон ярилцлагыг явуулсан. Төлөөлөгчид болон Засаг дарга нарын хувьд судалгаанд оролцох хандлага, идэвх сайн байсан. Ялангуяа орон нутгийн төлөөлөгчид болон Засаг дарга нар төвөг чирэгдэл үүсгэлгүйгээр хүлээж авч уулзсан.

Ганцаарчилсан ярилцлагад нийт 19 албан тушаалтан оролцов. Нийт оролцогчдын 6 нь дүүргийн ИТХ, 14 нь ороннутгийн ИТХ-ыг төлөөлөн оролцсон. Мөн нийт оролцогчдын 3 нь баг/хорооны Засаг дарга болон сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийн үүргийг давхар хашиж байна.

Хүйсийн хувьд нийт оролцогчдын 22% нь эмэгтэй, 78% нь эрэгтэй байв.

***Хүснэгт 16. Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын мэдээлэл***

| Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгч | Сум/дүүргийн Засаг дарга | Баг хорооны Засаг дарга |
|---|---|---|
| **14 Төлөөлөгч** | 2 Засаг дарга | 4 Засаг дарга |
| **Эрэгтэй-11<br>Эмэгтэй-3** | Эрэгтэй-2 | Эрэгтэй-2<br>Эмэгтэй-1 |
| **Дунджаар 2 дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа** | Дунджаар 1.5 дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа | Дунджаар 2 дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа |
| **Улаанбаатар хот-5<br>Орон нутаг-9** | Улаанбаатар хот-1<br>Орон нутаг-1 | Орон нутаг-3 |

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид уг судалгааны хүрээнд 11 удаагийн фокус бүлгийн ярилцлагыг иргэдийг оролцуулан зохион байгуулсан. Нэг бүлгийн ярилцлагад үндсэн 6 оролцогчоос гадна эрсдэлээс сэргийлэх үүднээс нөөц 3 оролцогчийг сонгов.

Нийт 11 бүлгийн ярилцлагаас нийслэлийн төвийн 2 дүүрэг, захын 1 дүүрэг тус бүрээс Улаанбаатар хотод 3 ФБЯ, харин орон нутгаас сонгогдсон аймаг тус бүрт 1-2 удаагийн фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан.

*Үндсэн болон нөөц оролцогчдыг сонгохын тулд эхлээд иргэдтэй уулзан, товч ярилцлага хийсний үндсэн дээр тодорхой шалгуур, шаардлагыг хангасан оролцогчдыг сонгож оролцуулав.*

***Хүснэгт 17. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл, байршлаар, хувиар***

| Мэдээлэл | Улаанбаатар хот | Орон нутаг |
|---|---|---|
| Хүйс | Эрэгтэй-44%<br>Эмэгтэй-56% | Эрэгтэй-50%<br>Эмэгтэй-50% |
| Дундаж нас | 20-35 насны – 28%<br>36-45 насны – 39%<br>46-60 насны – 33% | 20-31 насны – 21%<br>31-40 насны – 21%<br>41-50 насны – 27%<br>51-60 насны – 31% |
| Сууцны төрөл | Гэр хороолол – 56%<br>Орон сууц – 44% | Гэр хороолол – 67%<br>Орон сууц – 33% |
| Тухайн байршилд амьдарсан жил | 6 сараас 1 жил – 6%<br>3-6 жил – 17%<br>7-9 жил – 17%<br>10 ба түүнээс дээш – 61% | 6 сараас 1 жил – 4%<br>1-2 жил – 4%<br>3-6 жил – 17%<br>7-9 жил – 10%<br>10 ба түүнээс дээш – 65% |
| Боловсролын түвшин | Дунд – 11%<br>Бүрэн бус дунд – 6%<br>Бүрэн дунд – 39%<br>Тусгай дунд – 11%<br>Дээд – 33% | Дунд – 17%<br>Бүрэн бус дунд – 8%<br>Бүрэн дунд – 40%<br>Тусгай дунд – 13%<br>Дээд – 23% |

| | | |
|---|---|---|
| Ажил эрхлэлтийн байдал | Хувийн байгуулага – 28%<br>Хувиараа – 22%<br>Төрийн болон төсвийн – 11%<br>Тэтгэвэрт – 17%<br>Ажилгүй – 22% | Хувийн байгуулага – 21%<br>Хувиараа – 23%<br>Төрийн болон төсвийн – 17%<br>Тэтгэвэрт – 21%<br>Ажилгүй – 19% |
| Баг/хорооны ИНХ-д оролцох байдал | Огт оролцдоггүй – 39%<br>Хааяа оролцдог - 22%<br>Байнга оролцдог – 39% | Огт оролцдоггүй – 27%<br>Хааяа оролцдог - 33%<br>Байнга оролцдог – 39% |
| ИТХ-ын мэдээлэл авсан байдал | Тийм, авч байсан – 61%<br>Үгүй, авч байгаагүй – 39% | Тийм, авч байсан – 56%<br>Үгүй, авч байгаагүй – 44% |
| ИТХ, нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан хэвлэмэл материалтай танилцсан байдал | Тийм, танилцаж байсан – 61%<br>Үгүй, танилцаж байгаагүй - 39% | Тийм, танилцаж байсан – 54%<br>Үгүй, танилцаж байгаагүй - 46% |

## 3.2 ИРГЭДИЙН СОНГУУЛИЙН ИДЭВХ БОЛОН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ САНАА БОДОЛ

Энэ бүлэгт судалгаанд оролцогчдын шат шатны сонгуулийн идэвх, сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгаан, орон нутгийн сонгуулийн тогтолцооны талаарх ойлголт зэргийг тодорхойлсон болно.

### 3.2.1. Иргэдийн сонгуулийн идэвх

Судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 9 нь 2012 оны УИХ-ын сонгуульд оролцож саналаа өгсөн бол орон нутгийн сонгуульд 10 хүн тутмын 8 нь саналаа өгсөн байна. УИХ-ын сонгуульд оролцсон байдлыг байршлаар харвал хөдөө орон нутгийн иргэдийн сонгуулийн идэвх Улаанбаатар хотын иргэдийнхээс 4.1%-иар өндөр байна. Орон нутгийн сонгуулийн хувьд нийслэлийн иргэдийн сонгуулийн идэвх хөдөө орон нутгийнхаас 16.7%-иар бага байна.

2012 оны Улсын Их Хурлын сонгуульд сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдоос 67.3% нь сонгуульд оролцжээ.[2]

*Хүснэгт 18. 2012 оны УИХ-ын болон Орон нутгийн сонгуульд оролцсон байдал, байршлаар, хувиар*

| Байршил | УИХ-ын 2012 оны сонгууль | | | Орон нутгийн 2012 оны сонгууль | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Санал өгсөн | Санал өгөөгүй | Хариулахаас татгалзсан | Санал өгсөн | Санал өгөөгүй | Санахгүй байна |
| **Нийт** | **89.0** | **10.8** | **0.2** | **76.2** | **22.5** | **1.3** |
| **Улаанбаатар** | 86.6 | 13.4 | 0 | 66.4 | 31.4 | 2.2 |
| **Хөдөө орон нутаг** | 90.7 | 9.0 | 0.3 | 83.1 | 16.1 | 0.7 |
| **Дүүргээр** | | | | | | |
| **БГД** | 80.4 | 19.6 | 0.0 | 54.9 | 43.1 | 2.0 |
| **БЗД** | 86.4 | 13.6 | 0.0 | 55.6 | 40.7 | 3.7 |
| **ЧД** | 96.1 | 3.7 | 0.0 | 73.7 | 26.3 | - |
| **СХД** | 81.4 | 18.6 | 0.0 | 61.1 | 37.2 | 1.8 |
| **СБД** | 87.1 | 12.9 | 0.0 | 74.3 | 24.8 | 1.0 |
| **ХУД** | 84.4 | 15.6 | 0.0 | 78.1 | 18.8 | 3.1 |
| **НД** | 91.3 | 8.7 | 0.0 | 73.9 | 19.6 | 6.5 |
| **Аймгаар** | | | | | | |
| **Дархан-Уул** | 89.5 | 10.5 | 0.0 | 76.9 | 22.4 | 0.7 |
| **Өвөрхангай** | 92.7 | 13.4 | 6.7 | 86.6 | 13.4 | - |
| **Хөвсгөл** | 86.2 | 12.9 | 11.2 | 80.2 | 18.1 | 1.7 |
| **Хэнтий** | 91.2 | 14 | 8.8 | 84.2 | 15.2 | 0.6 |
| **Ховд** | 93.4 | 25.5 | 4.7 | 87.7 | 11.3 | 0.9 |

УИХ-ын сонгуульд оролцож, саналаа өгөөгүй шалтгааныг харвал Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын хувьд сонгуульд санал өгөх насанд хүрээгүй байсан (30.9%), тухайн үед өөр орон нутагт ажиллаж байсны улмаас саналаа өгч чадаагүй

[2] Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2013

(33.8%) байна. Харин орон нутгийн иргэдийн хувьд сонгууль болох үед бичиг баримтын асуудалтай (27.0%), өөр орон нутагт ажиллаж, амьдарч, сурч байсан (20.6%), сонгуульд санал өгөх насанд хүрээгүй байсан (20.6%) зэрэг шалтгаан голлож байна.

Орон нутгийн сонгуулийн хувьд нийслэлийн иргэд сонгуулийн талаарх мэдээлэл хангалттай байгаагүй гэсэн шалтгаан хөдөө орон нутгийн иргэдээс харьцангуй их байна.

***Зураг 8. 2012 оны УИХ-ын сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгаан, хувиар***




***Зураг 9. 2012 оны Орон нутгийн сонгуульд оролцож, саналаа өгөөгүй шалтгаан, хувиар***




Хөдөө орон нутаг, нийслэл аль алинд Ерөнхийлөгч, УИХ-ын сонгуулийн ирц харьцангуй сайн байдаг ч орон нутгийн сонгуулийн ирц жил ирэх тусам буурсаар байна хэмээн ганцаарчилсан ярилцлагад оролцсон ИТХ-ын төлөөлөгчид, Засаг дарга нар дурьдаж байлаа. Иргэд УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд идэвх сайтай оролцдог нь эдгээр сонгуульд зарцуулах төсөв орон нутгийн сонгуулийнхаас илүү байдаг, нэр дэвшиж байгаа хүн мөрийн хөтөлбөрөө танилцуулж, олон нийтэд хандсан сурталчилгаа явуулж, иргэдэд мэдээллийг сайн хүргэж чаддагтай холбоотой

байна. Мөн сонгууль болох хугацаа нь сонгуулийн идэвх сайн байхад ихээхэн нөлөөлдөг ажээ. Орон нутгийн сонгуулийн ирц бусад сонгуулиас бага байгаагийн шалтгааныг дараах байдлаар нэгтгэн тайлбарлалаа. Үүнд:

- Иргэдийн төрд итгэх итгэл буурсан;
- Орон нутгийн сонгууль өгөхийн ач тусыг иргэд сайн мэдэхгүй байгаа;
- Орон нутгийн сонгуулийн төсөв бага учраас иргэдэд сонгуулийн талаарх сурталчилгаа бага хүрдэг;
- Сонгууль дөхөхөөр хэт улс төржсөн байдал нэмэгддэг;
- Ялагдах магадлалтай аль нэг улс төрийн нам сонгуулийн ирцийг бүрдүүлэхгүй, дахин сонгууль явуулах тактик хэрэглэх (ингэснээр дахин сонгуульд иргэд бүр ч ирэхгүй);
- Орон нутгийн сонгууль хүйтний улирал эхэлж байхад буюу 10 дугаар сард болдог зэрэг шалтгаан багтаж байна.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс*:

Нэгдүгээрт, ИТХ-ын төлөөлөгч нарыг сонгосноор ямар давуу талтай, иргэдэд ямар ач холбогдолтой вэ гэдгийг иргэд мэдэхгүй байна. Урьд нь ажиллаж байсан төлөөлөгчид энэ талаар ямар ч ойлголт өгөөгүй байна. Хоёрдугаарт, намын орон нутгийн сонгуулийн ирцийг хангалттай түвшинд хүргэхгүй байх тактик маш сайн үйлчилж байна. Тэгээд дахин сонгууль болоход намыг дэмждэг намын гишүүд нь ирээд өгчихдөг. Өөр бусад хүмүүс дахин ирж санал бараг өгөхгүй шүү дээ.

***Улаанбаатар хот, ЧД-ийн ИТХ-ын төлөөлөгч***

Ерөнхийлөгч, УИХ болон орон нутгийн сонгуулиудын аль алинд нь манай сумын иргэд идэвхтэй оролцдог. Гэхдээ хавар, намар ажлын их үеэр сонгууль явагдахаар иргэдийн оролцоо буурах хандлагатай байдаг. Учир нь мал төллөх, тариа будаагаа хураах зэрэг ажил ихтэй байдаг үед иргэд өөрсдийн ажлаа л бодно.

***Дархан-Уул аймаг, Хонгор сумын ИТХ-ын тэргүүлэгч***

Иргэд Ерөнхийлөгч болон УИХ-ын сонгуульд идэвхтэй оролцдог. Эдгээр сонгуулийн төсвийн хэмжээ нь хэдэн тэрбум байдаг болохоор иргэдэд хүргэх мэдээлэл, PR-ийн ажил сайн хийгддэг. Энэ хэмжээгээрээ сонгуулийн ирц сайн байдаг. Орон нутгийн сонгуулийн хувьд 11 сард хүйтний эрч нэмэгдчихсэн байхад эхэлдэг, төсвийн хэмжээ ч иргэдэд хангалттай мэдээлэл өгөхөд хүрдэггүй, өмнө нь сонгууль болчихсон болохоор залхсан байдаг учраас сонгогчдын идэвх маш сул байдаг.

***Улаанбаатар хот, БЗД-ийн Засаг дарга***

2016 оны Орон нутгийн сонгуульд оролцох хандлагыг харахад нийслэл, хөдөө орон нутгийн хувьд ялгаагүй дийлэнх хувь нь оролцож саналаа өгнө гэжээ.

*Хүснэгт 19. 2016 оны Орон нутгийн сонгуульд оролцох байдал, байршлаар, хувиар*

| Байршил | Санал өгнө | Санал өгөхгүй | Одоогоор мэдэхгүй байна | Хариулахаас татгалзсан | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **Нийт** | **91.4** | **2.2** | **6.3** | **0.2** | **100** |
| **Улаанбаатар** | 90.6 | 2.8 | 6.2 | 0.4 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | 92.0 | 1.7 | 6.3 | - | 100 |
| **Дүүргээр** | | | | | |
| **БГД** | 90.2 | 2.0 | 7.8 | - | 100 |
| **БЗД** | 90.1 | 2.5 | 7.4 | - | 100 |
| **ЧД** | 90.8 | - | 7.9 | 1.3 | 100 |
| **СХД** | 88.5 | 4.4 | 6.2 | 0.9 | 100 |
| **СБД** | 91.1 | 4.0 | 5.0 | - | 100 |
| **ХУД** | 90.6 | 6.3 | 3.1 | - | 100 |
| **НД** | 95.7 | - | 4.3 | - | 100 |
| **Аймгаар** | | | | | |
| **Дархан-Уул** | 88.8 | 4.9 | 6.3 | - | 100 |
| **Өвөрхангай** | 91.5 | 1.8 | 6.7 | - | 100 |
| **Хөвсгөл** | 94.0 | 0.9 | 5.2 | - | 100 |
| **Хэнтий** | 94.2 | - | 5.8 | - | 100 |
| **Ховд** | 91.5 | 0.9 | 7.5 | - | 100 |

### 3.2.2. Сонгуулийн тогтолцооны талаарх ойлголт, хандлага

Сонгуулийн системийн мажоритар, пропорциональ, холимог гэсэн гурван хувилбарыг өнөөдөр дэлхийн улс орнууд хэрэглэдэг. Манай улсын хувьд 1992 оноос 2012 оны сонгууль хүртэл парламентын сонгуульд мажоритар тогтолцоог ашиглаж ирсэн. Сонгууль бүрийн өмнө мажоритар тогтолцооны сул талыг тойрсон шүүмжлэл өрнөдөг ч тус системийг сонгосоор иржээ. Түүний гол сул тал нь сонгогчдын санал гээгдэх явдал юм.

Харин 2012 оны сонгуулийг мажоритар, пропорциональ тогтолцооны аль алины элементийг багтаасан холимог байдлаар зохион байгуулсан. УИХ-ын 76 гишүүний 48-ыг 26 тойргоос мажоритараар, үлдсэн 28 суудлыг пропорционалиар сонгосон. 2012 оны ИТХ-ын сонгуулийг мөн үүнтэй төстэй холимог тогтолцоогоор явуулсан.

**Сонгуулийн тогтолцооны талаар иргэдийн ойлголт, уг тогтолцоог хэр оновчтой гэж үзэж байгааг тодруулахад, нийт иргэдийн 50% нь буюу тал нь оновчтой бус гэж үзэж байна. Харин иргэдийн 17.9% нь энэ талаар мэдэхгүй байгаагаа илэрхийлсэн бол 23.6% нь оновчтой гэж үзэж байна.** Дээрх дүнг хот, хөдөөгөөр авч үзэхэд төдийлөн ялгаа харагдахгүй байна.

**Нийт иргэдийн 57% нь тойргоос сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчид тэднийг дунд зэрэг буюу түүнээс дээш төлөөлж чадна гэж үзэж байгаа** бол 27% нь жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид тэднийг төлөөлж чадна гэж үзэж байна. Энэ дүнг хот, хөдөөгөөр ялган авч үзвэл УБ хотын иргэдийн 48.8%, хөдөөгийн иргэдийн 62.6% тойргоос сонгогдсон төлөөлөгчдөд итгэл үзүүлж байна.

### *Зураг 10. Одоогийн сонгуулийн тогтолцооны талаарх иргэдийн санаа бодол, хувиар*




Харин нийт иргэдийн 22% нь тойргоос сонгогдсон төлөөлөгчид тэднийг төлөөлж чадахгүй гэж байгаа бол 51% нь жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид тэднийг төлөөлж чадахгүй гэж дүгнэж байна. Энэ дүнг хот, хөдөөгөөр ялгаатай авч үзвэл, Улаанбаатар хотын иргэдийн 58.4%, хөдөөгийн иргэдийн 45.4% жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчдөд итгэл үзүүлэхгүй байна. **Нийт иргэдийн 40% жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид иргэдийн эрх ашгийг огт төлөөлж чадахгүй гэжээ.**

### *Хүснэгт 20. Тойргоос болон жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид иргэдийг төлөөлөх талаарх иргэдийн санаа бодол, байршлаар, хувиар*

| | Маш сайн төлөөлж чадна | Зарим талаар төлөөлж чадна | Дунд зэрэг төлөөлж чадна | Зарим талаар төлөөлж чадахгүй | Огт төлөөлж чадахгүй | Мэдэх-гүй | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Тойргоос сонгогдсон төлөөлөгчид** | | | | | | | |
| **Нийт** | **18.3** | **22.6** | **16.0** | **12.2** | **12.0** | **19.0** | **100** |
| **Улаанбаатар** | 14.6 | 19.0 | 15.2 | 17.2 | 16.8 | 17.2 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | 20.9 | 25.1 | 16.6 | 8.6 | 8.6 | 20.3 | 100 |
| **Жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид** | | | | | | | |
| **Нийт** | **5.9** | **10.4** | **10.8** | **11.1** | **39.8** | **22.1** | **100** |
| **Улаанбаатар** | 4.6 | 9.0 | 9.4 | 12.6 | 45.8 | 18.6 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | 6.9 | 11.4 | 11.7 | 10.0 | 35.4 | 24.6 | 100 |

## 3.3. ИТХ-ЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА, ҮНЭЛГЭЭ

Энэ бүлэгт нутгийн өөрөө удирдах байгууллага болох ИТХ, түүний чиг үүргийн талаарх иргэдийн ойлголт, үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой мэдээллийг авдаг эх үүсвэрүүд, хэвлэмэл тайлан материалтай танилцсан эсэх, аймаг/нийслэл болон сум/дүүргийн ИТХ-ын талаарх үнэлгээ, шалтгаан зэргийг тоон болон чанарын судалгааны хосолмол үр дүнгээр гарган харуулсан юм.

*Зураг 11. Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлын үйл явц*



### 3.3.1. ИТХ-ын талаарх нийтлэг ойлголт

Судалгаанд оролцогчидтой хийсэн ярилцлагын эхэнд ИТХ-ын талаар юу гэж боддог, ямар үндсэн чиг үүргийн дагуу ажилладаг болохыг тодруулсан юм. Ингэхдээ ИТХ-ын талаар ямар нэгэн мэдээлэл, ойлголт, сэдэл өгөлгүй, өөрөөр хэлбэл тэдэнд нөлөөлөлгүйгээр ойлголтыг нь тодруулсан юм.

Мэдээлэл цуглуулах явцад иргэд “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэсэн нэрийг сонсоод шууд ямар байгууллага болохыг хэлж чадахгүй байгаа нь ажиглагдсан. Судлаачдын зүгээс асуултыг дахин уншиж өгөх, асуултын утгыг тайлбарлах зэргээр оролцогчдын хариултад тусалсан боловч төдийлөн үр дүн өгөөгүй болно.

**Нийт судалгаанд оролцогчдын 55% нь ИТХ-ын талаар “Огт мэдэхгүй” гэсэн хариулт өгчээ.** Харин Улаанбаатар хотын иргэдийн 32% нь, орон нутгийн иргэдийн 71% нь ИТХ гэдэг байгууллагын талаар ямар ч ойлголт байхгүй, зарим иргэд бүр ийм байгууллага байдгийг ч мэдэхгүй гэж хариулсан байна.

Огт мэдлэг, мэдээлэлгүй байгаа хүмүүс нь нас, хүйс, ажил эрхлэлт болон сууцны нөхцөлийн хувьд онц ялгарах зүйлгүй, өөрөөр хэлбэл, хүн ам зүйн хувьд тодорхой бүлэг хүмүүс хомс мэдлэгтэй хэмээн дүгнэх үндэсгүй байна. **Энэ нь иргэд нийтээрээ нутгийн өөрөө удирдах байгууллага, төлөөллийн ардчиллын талаарх мэдлэг мэдээлэл, ойлголт маш муу байгааг харуулж байна.**

ИТХ-ын талаар мэдэхгүй байгаа эдгээр иргэд баг/хорооны ИНХ-даа оролцдог эсэхийг тодруулахад 73% нь өнгөрсөн онд (2014 он) ИНХ-д огт оролцоогүй, 63% нь баг/хорооны Засаг даргыг сонгох ИНХ-д оролцож байгаагүй иргэд байлаа. Энэ дүн нь нийт судалгаанд оролцогчдын ИНХ-д оролцож буй байдлаас даруй 20 орчим хувиар илүү байгаа юм (*Баг/хорооны ИНХ-ын оролцоотой холбоотой дүнг* ***бүлэг 3.5-*** *аас харах боломжтой).* Өөрөөр хэлбэл иргэд баг/хорооныхоо ИНХ-д оролцсоноор нутгийн удирдлагын байгууллагын талаарх мэдээллийг олж авах хандлага өндөр байна.

ИТХ-ын талаарх ойлголтоо ямар нэг байдлаар тайлбарласан иргэдийн тайлбарыг хамгийн их давтагдсан дарааллаар жагсаавал:

**ИТХ-ын талаарх Улаанбаатар хотын иргэдийн ойлголт**

- Ард иргэдийн дундаас сонгогдон ажиллаж байгаа иргэдийн төлөөллийн байгууллага;
- Ард иргэдийн санал хүсэлтийг авч, холбогдох газарт уламжлан, шийдвэрлэж өгдөг үйлчилгээний байгууллага;
- Ард иргэдийн дуу хоолойг төрд хүргэх, төр иргэдийн хооронд гүүр болох байгууллага;
- Иргэдийн амьжиргаа, нутаг орны хөгжлийг сайжруулах байгууллага;
- Өрх бүр, иргэн бүртэй хамгийн ойр тулж ажиллах байгууллага;
- Хороотой хамтарч ажилладаг байгууллага;
- Орон нутагт төрийн үйлчилгээг үзүүлэгч хамгийн дээд байгууллага;
- Иргэдийг мэдээллээр хангадаг, иргэдийг зохион байгуулдаг байгууллага;
- Ард түмний эрх ашгийг хамгаалдаг байгууллага;
- Орон нутагт хуваарилагдсан санхүүг хуваарилж, зарцуулалтыг батлах эрх бүхий байгууллага;
- Хууль баталдаг байгууллага;
- Мөнгө иддэг л байгууллага;
- Засаг дарга болон дүүргийн бусад албан хаагчдыг хянадаг байгууллага;
- Цалин авдаггүй сайн дурын хүмүүсийн нэгдсэн байгууллага.

**ИТХ-ын талаарх хөдөө орон нутгийн иргэдийн ойлголт**

- Ард иргэдийн дундаас сонгогдон ажиллаж байгаа иргэдийн төлөөллийн байгууллага;
- Ард иргэдийн санал хүсэлтийг авч, холбогдох газарт уламжлан, шийдвэрлэж өгдөг үйлчилгээний байгууллага;
- Орон нутаг дахь төрийн үйлчилгээг үзүүлэгч хамгийн дээд байгууллага;
- Иргэдийн амьжиргаа, нутаг орны хөгжлийг сайжруулах байгууллага;
- Ард иргэдийн дуу хоолойг төрд хүргэх, төр иргэдийн хооронд гүүр болох байгууллага;
- Өрх бүр, иргэн бүртэй хамгийн ойр тулж ажиллах байгууллага;
- Орон нутагт хуваарилагдсан санхүүг хуваарилж, зарцуулалтыг батлах эрх бүхий байгууллага;
- Ард түмний эрх ашгийг хамгаалдаг байгууллага;
- Иргэдийг мэдээллээр хангадаг, иргэдийг зохион байгуулдаг байгууллага;
- Засаг даргатай хамтарч ажиллах, ажлыг нь хянаж, чиглүүлдэг байгууллага;
- Орон нутагт хийгдэж байгаа ажилд хяналт тавьдаг байгууллага;
- Ард иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах үүрэг бүхий байгууллага;
- Ажил хийдэггүй байгууллага;
- Ард түмний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх ёстой байгууллага.

Тоон судалгааны дээрх үр дүнгээс гадна иргэдийн төлөөллийг оролцуулсан ФБЯ-ын үеэр цөөн оролцогч ИТХ-ын талаар дараах оновчтой хариултыг өгч байсан юм.

### ИТХ-ын үндсэн чиг үүргийн талаарх иргэдийн ойлголт

ИТХ нь сонгогдсон нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, хөгжлийн бодлогын асуудлыг ИТХ болон чөлөөт цагт Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхийн хамт НӨУБ-ын хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, иргэдийн эрх ашгийг хамгаалж, тэдэнтэй тогтмол холбоотой ажиллан, санал гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэн, Засаг даргыг нэр дэвшүүлэх, түүнийг чөлөөлөх, огцруулах болон Засаг дарга, тухайн нутаг дэвсгэрт төрийн үйлчилгээг үзүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахаар заагдсан байна.[3]

Иргэд ИТХ-ын үндсэн чиг үүргийн талаар ямар ойлголттой болохыг тодруулан асуухад орон нутгийн иргэдийн "Мэдэхгүй" гэсэн хариултын эзлэх хувь буурсан байна. Харин Улаанбаатар хотын иргэдийн 32% нь "Мэдэхгүй" буюу энэ талаарх мэдлэг, мэдээлэл огт байхгүй гэжээ.

**Иргэдийн хувьд ИТХ-ын хамгийн гол чиг үүргийг "Иргэдтэй тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх эрх бүхий байгууллага" гэж 2 хүн тутмын 1 нь буюу 49% нь үзэж байна.**

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Ард түмнийг төлөөлж орон нутагт ажиллаж байгаа хамгийн том байгууллага гэж ойлгодог. Сумын болон аймгийн Хурал нь иргэдээс сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулж сум орныхоо асуудлыг шийдвэрлэх зорилготой ажилладаг гэж ойлгодог. НӨУБ гэдэг нь ард түмэн өөрсдийн төлөөллөөрөө дамжуулаад удирдана гэсэн утгатай.

***Хэнтий аймаг, Батноров сум, эрэгтэй***

Ер нь нутаг орныхоо хөгжил, иргэдийн амьжиргаа, амьдралын түвшинг дээшлүүлэхийн төлөө ажилладаг. Бас УИХ-аас гаргасан шийдвэрийг иргэдэд танилцуулж, мэдээлэл өгдөг гэж боддог. Ер нь төрийг иргэдтэй холбодог гүүр юм болов уу?

***Дархан-Уул аймаг, Дархан сум, эмэгтэй***

Миний хувьд ИТХ гэдэг хамгийн дээд шатны байгууллага. Аймгийн Засаг даргыг томилно. Бүх хэлтэс газруудад хяналт тавьж ажилладаг байх гэж бодож байна. Мөн орон нутгийн дэг журам, хураамж гэх мэт томоохон шийдвэрүүдийг баталдаг байгууллага.

***Хэнтий аймаг, Хэрлэн сум, эрэгтэй***

Сумын ИТХ гэдэг бол ерөөсөө сумынхаа иргэдээс сонгогдсон, сумын иргэдийн эрх ашгийн төлөө ажиллах ёстой хүмүүс гэж боддог.

***Ховд аймаг, Жаргалант сум, эмэгтэй***

[3] Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

*Зураг 12. ИТХ-ын чиг үүргийн талаарх иргэдийн ойлголт, байршлаар, хувиар*




**ИТХ-ын чиг үүргийн талаар огт мэдлэг, мэдээлэл байхгүй иргэд нийт иргэдийн 25%-ийг эзэлж байна.** Өөрөөр хэлбэл, 4 хүн тутмын 1 нь дээрх 2 төрлийн үр дүнд хоёуланд нь “Мэдэхгүй, энэ талаарх мэдлэг огт байхгүй” гэж хариулсан байна. Байршлын хувьд Улаанбаатар хотын иргэд ороннутгийн иргэдээс ИТХ-ын талаарх ойлголт бага зэрэг илүү байна.

Харин ИТХ-ын төлөөлөгчид болон бусад нутгийн удирдлагын хувьд иргэдэд НӨУБ-ын талаар мэдлэг, мэдээллийг дараах аргаар өгдөг гэжээ.

> *Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*
>
> Иргэдийн явуулын индэр гэж STAREX машиныг тохижуулаад гадуур явуулж байгаа.
>
> ***Хөвсгөл аймаг, Мөрөн сумын ИТХ-ын дарга***

НӨУБ-ын билигдлийн шинж чанарыг арилгаж, иргэд рүү чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавин ажиллаж байна. Хотын дүрэм журам гарган ажиллаж байгаа. Төлөөлөгчдийн нэрэмжит гудамж гэх мэт үйл ажиллагаа явуулж байна. Олон улсын байгууллагуудтай хамтран өрхүүдээр сургалт, төслүүдийг хэрэгжүүлж байна.

***Хөвсгөл аймаг, Тариалан сумын ИТХ-ын дарга***

Жил бүр Иргэдийн Төлөөлөгчдийн өдөрлөг гэж хийдэг. Тойрог тойргтоо хамтраад хийдэг. Янз бүрийн тэмцээн уралдаан зохиогоод иргэдийг оролцуулдаг. Ер нь иргэдийн ойлголт харьцангуй нэмэгдэнэ гэж үзэж байгаа.

***Өвөрхангай аймаг, Гучин-Ус сумын багийн Засаг дарга***

Иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна. Энэ нь иргэдэд энэ талын ойлголтыг өгөхөд нилээн тус дөхөм болж байгаа гэж бодож байна.

***Дархан-Уул аймаг, Хонгор сумын ИТХ-ын тэргүүлэгч***

Мэдээлэл авдаггүй иргэдтэй ахмадууд, хорооны идэвхтнүүд, хэсгийн ахлагч нар, нийгмийн ажилтан гэрт нь очиж уулзан хийх ажлынхаа талаар мэдээлэл өгдөг.

***Улаанбаатар хот, ЧД-ийн ИТХ-ын төлөөлөгч***

Ямар учраас иргэдийн идэвх, оролцоо, НӨУБ-ын талаар мэдлэг мэдээлэл муу байгааг иргэд өөрсдөө тайлбарлахдаа:

***Нэгдүгээрт,*** улс төрд итгэх итгэл муудсан буюу төрийн ажил хийхээр хэн ч сонгогдсон бай иргэдийн амьдралд сайн нөлөө гарахгүй гэх бодол зонхилох болсон;

***Хоёрдугаарт,*** хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, зав чөлөөгүй болсноор нутгийн удирдлагын байгууллагуудын талаарх мэдлэг бага болсон;

***Гуравдугаарт,*** оновчтой сувгаар мэдээлэл авч чадахгүй байгаа, өөрөөр хэлбэл, мэдээллийн хэрэгсэл олширсноор иргэд маш олон төрлийн мэдээллийг нэгэн зэрэг авах болсон нь тэдэнд хүссэн мэдээллээ л шүүж авахаас аргагүйд хүргэж байгаа зэрэг шалтгааныг нэрлэжээ.

НӨУБ-ын талаар иргэдийн ойлголт ийнхүү дутмаг байгаа нь тулгамдсан асуудал гарсан үед хаана хандахаа мэдэхгүй байх, төрийн үйлчилгээ иргэдээсээ холдох, иргэдийн сонгуулийн болон бусад идэвх буурах, улмаар энэхүү үндсэн хуулийн институцийн нэр хүнд буурах сөрөг үр дагавартай байна.

### *ИТХ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл авдаг эх үүсвэр*

Иргэдээс нутгийн удирдлагын байгууллагын талаар мэдээлэл авдаг гол эх үүсвэрийг тодруулахад Улаанбаатар хотын иргэдийн хувьд орон даяар цацагддаг телевизийн

сувгуудаас мэдээлэл авах хандлага хамгийн өндөр буюу 53%-тай, харин орон нутгийн иргэдийн хувьд тухайн орон нутгийнхаа телевизийн сувгуудаас мэдээлэл авах нь хамгийн өндөр буюу 22%-тай байна. Хурал уулзалтын үеэр мэдээлэл авах байдал орон нутагт 20% байхад Улаанбаатар хотод 4%, хөрш айл эсвэл ойр дотны хэн нэгэн хүнээс мэдээлэл авах байдал орон нутагт 14% байхад Улаанбаатар хотод 4% байгаа юм. Улаанбаатар хотын иргэдийн хувьд Хорооноосоо мэдээлэл авах байдал орон нутгийн иргэдээс харьцангуй өндөр байгаа онцлог харагдаж байна. Харин энэ талаарх мэдээллийг огт авч чаддаггүй гэж нийт иргэдийн 17% нь хариулсан нь Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт ойролцоо байна.

Энэ дүнг "Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд 2013 онд хийгдсэн судалгааны[4] дүнтэй харьцуулахад телевизээс мэдээлэл авах байдал харьцангуй өссөн, хурал цуглаан уулзалтын үеэр мэдээлэл авах хандлага багассан байна. Өөрөөр хэлбэл, өмнө нь хийгдэж байсан судалгааны дүнгээр телевизээс мэдээлэл авдаг гэж 44%, хурал цуглаан уулзалтын үеэр мэдээлэл авдаг гэж 23% нь хариулж байжээ. Харин энэ талаарх мэдээллийг огт авч чаддаггүй гэсэн хариултын хувьд маш ойролцоо дүнтэй байна.

***Хүснэгт 21. Иргэдийн ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаг эх үүсвэр, байршлаар, хувиар***

| Мэдээлэл авдаг эх үүсвэр | Нийт | Улаанбаатар хот | Орон нутаг |
|---|---|---|---|
| Телевиз (орон даяар цацагддаг) | 32.9 | 53.0 | 18.6 |
| Огт мэдээлэл авдаггүй | 17.1 | 17.4 | 16.9 |
| Телевиз (орон нутгийн) | 15.8 | 7.2 | 22.0 |
| Хурал, уулзалтын үеэр | 13.5 | 4.0 | 20.3 |
| Хөрш айл эсвэл ойр дотны хэн нэгнээс | 10.2 | 4.2 | 14.4 |
| Сонин | 7.3 | 6.8 | 7.6 |
| Мэдэхгүй/санахгүй байна | 5.7 | 8.0 | 4.0 |
| Баг/хорооноос | 4.7 | 8.8 | 1.7 |
| Нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн самбараас | 4.6 | 2.2 | 6.3 |
| Хурлын төлөөлөгчдөөс шууд | 4.1 | 1.4 | 6.0 |
| Хэвлэмэл тараах материал. сурталчилгааны хуудас | 3.8 | 4.0 | 3.7 |
| Сум/дүүргийн ИТХ-ын Ажлын албанаас | 3.4 | 1.8 | 4.6 |
| Радио | 3.4 | 2.8 | 3.9 |
| Нутгийн захиргааны байгууллагын цахим хуудас, бусад цахим хуудаснаас | 3.3 | 5.2 | 1.9 |
| Баг/хорооны Засаг дарга | 2.8 | 0.2 | 4.6 |
| Бусад | 1.3 | 2.0 | 0.9 |
| Мэссэж | 1.0 | 0.2 | 1.6 |
| Сум/дүүргийн ИТХ-ын Даргаас | 0.7 | 0.2 | 1.0 |
| И-мэйл | 0.7 | 1.6 | 0.0 |
| Хэсгийн ахлагч, хорооны идэвхтэн | 0.7 | 1.2 | 0.3 |
| Нутгийн захиргааны байгууллагын цахим хуудас, бусад цахим хуудаснаас | 0.5 | 0.8 | 0.3 |
| Улс төрийн намын ажилтнаас | 0.4 | 0.2 | 0.6 |
| Иргэний танхим | 0.4 | 0.4 | 0.4 |

[4] "Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог дэмжих нь" хөтөлбөрийн суурь судалгааны тайлан /2013/-IRIMongolia

| | | | |
|---|---|---|---|
| Аймаг/нийслэлийн ИТХ-ын Ажлын албанаас | 0.3 | 0.0 | 0.6 |
| Аймаг/нийслэлийн ИТХ-ын Даргаас | 0.1 | 0.0 | 0.1 |

Судалгаанд хамрагдсан аймаг тус бүрийн хувьд мэдээлэл авдаг эх үүсвэр нь харилцан адилгүй байна. Өөрөөр хэлбэл, аймаг тус бүрийн НӨУБ-ын иргэддээ мэдээллээ түгээж буй хэлбэр өөр байна.

Дархан-Уул аймгийн хувьд орон нутгийн телевизийн сувгуудаар мэдээллийг хамгийн их хүргэдэг буюу иргэдийн 56% нь мэдээлэл авдаг гэжээ. Харин Ховд аймгийн иргэдийн 26%, Хөвсгөл аймгийн иргэдийн 28% нь хурал уулзалтын үеэр мэдээлэл авч чаддаг гэжээ. Өвөрхангай аймгийн иргэдийн 13% нь баг/хорооны Засаг даргаас, 10% нь сонингоос энэ талаарх мэдээллийг авч чадаж байгаа нь бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй өндөр дүнтэй байгаа юм.

***Хүснэгт 22. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хамгийн их авдаг 5 эх үүсвэр, аймгаар, хувиар***

| Мэдээлэл авдаг эх үүсвэр | Хувь |
|---|---|
| **Дархан-Уул аймаг** | |
| Телевиз /орон нутгийн/ | 55.9 |
| Телевиз /орон даяар цацагддаг/ | 22.4 |
| Хөрш айл эсвэл ойр дотны хэн нэгнээс | 16.8 |
| Огт мэдээлэл авдаггүй | 10.5 |
| Хурал. уулзалтын үеэр | 10.5 |
| **Өвөрхангай аймаг** | |
| Огт мэдээлэл авдаггүй | 21.3 |
| Телевиз /орон нутгийн/ | 18.3 |
| Хурал. уулзалтын үеэр | 13.4 |
| Баг/хорооны Засаг дарга | 12.8 |
| Сонин | 10.4 |
| **Хөвсгөл аймаг** | |
| Хурал, уулзалтын үеэр | 28.4 |
| Огт мэдээлэл авдаггүй | 29.8 |
| Телевиз /орон нутгийн/ | 19.0 |
| Хөрш айл эсвэл ойр дотны хэн нэгнээс | 9.5 |
| Баг/хорооны Засаг дарга | 5.2 |
| **Хэнтий аймаг** | |
| Телевиз /орон даяар цацагддаг/ | 34.5 |
| Хурал, уулзалтын үеэр | 25.7 |
| Огт мэдээлэл авдаггүй | 21.6 |
| Хөрш айл эсвэл ойр дотны хэн нэгнээс | 15.2 |
| Телевиз /орон нутгийн/ | 10.5 |
| **Ховд аймаг** | |
| Хурал, уулзалтын үеэр | 26.4 |
| Хөрш айл эсвэл ойр дотны хэн нэгнээс | 26.4 |
| Телевиз /орон даяар цацагддаг/ | 17.9 |
| Хурлын төлөөлөгчдөөс шууд | 15.1 |
| Нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн самбараас | 9.4 |

Дээрх үр дүнгийн шалтгааныг чанарын судалгаанд оролцогчидтой хийсэн ярилцлагаар илүү нарийвчлан тодруулсан юм. Ярилцлагад орсон мэдээлэл сайтай иргэдийн хувьд сонгогдсон орон нутгийн удирдах байгууллагууд иргэддээ хэрхэн мэдээлэл хүргэдэг, ямар байдлаар үйл ажиллагаагаа танилцуулдаг талаар иргэд дараах байдлаар ярьжээ.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Манай орон нутагт телевизээр байнга мэдээлэл өгдөг. Соёмбо, Арвайхээр гээд 2 телевизээр байнга гаргадаг. Саяхан, оноос өмнө аймгийн ИТХ-ын дарга Ганболд 3 цагийн турш би ийм юм хийсэн гээд тайлангаа танилцуулсан. Мөн Арвайхээр сумын ИТХ-ын дарга Ганбат бас тайлангаа танилцуулсан. Соёмбо ТВ дээр 70321111, 99321111 гээд дугаар дээр иргэд өөрсөддөө тулгамдаж байгаа асуудлуудыг хэлж болдог. Залуу хүүхдүүд бол огт үздэггүй. Би гарч байхаар нь албаар тавьчихдаг юм.

***Өвөрхангай аймаг, Арвайхээр сумын иргэн, эмэгтэй***

Бид хурлын талаарх мэдээллийг зурагтаас хардаг. Хөдөөний иргэд бидний хувьд мэдээлэл маш тааруу байдаг. Багийн Хурлыг жилд 2 удаа хийдэг ч тэр болгонд очиж сууж чаддаггүй.

***Хөвсгөл аймаг, Эрдэнэбулган сумын иргэн, эрэгтэй***

Дүүргийн телевизээр гардаг. Манай дүүрэг Налайх, Буян гэсэн 2 сувагтай, эдгээр сувгаар ажлаа тайлагнадаг. Бас Налайхын амьдрал гээд сонин гардаг, хороон дээр байдаг тэр сонингоо хэсгийн ахлагч нар нь өрхүүдээр тараадаг. Уг нь 4000 төгрөгийн үнэтэй сонин юм билээ, гэхдээ тухайн нөхцөл байдлаас шалтгаалж онцгой мэдээлэлтэй байвал үнэгүй тараадаг.

***Улаанбаатар хот, НД-ийн иргэн, эмэгтэй***

ИТХ-аас гарсан шийдвэрүүдийн талаарх мэдээллийг олж авах эх үүсвэр тун хомс. Өөрөө асууж сураглаж байж ам дамжсан ярианаас л олж сонсдог.

***Ховд аймаг, Булган сумын иргэн, эмэгтэй***

Орон нутгийн телевизээр л авдаг. Гэхдээ бас хэвлэсэн, тараах материалууд өгдөг. Зузаан, үнэтэй материалаар хийсэн байдаг болохоор галд хийсэн ч шаттаггүй. Тэгээд 2 жилийн өмнө өгсөн материал одоо хүртэл байж л байна. Би бол уншчихаж байгаа юм. Харин хүүхдүүдээ уншиг гээд галын өрөөны ширээн дээр нүдэнд нь харагдах газар тавьсан ч авч сонирхдоггүй.

***Дархан-Уул аймаг, Дархан сумын иргэн, эрэгтэй***

ФБЯ-д оролцсон бусдаас илүү идэвхтэй, мэдээлэл цахимай оролцогчдын хувьд тухайн орон нутгийнхаа хэвлэл мэдээллийн хэрэгслээс илүү их мэдээллийг авч чаддаг байна. Гэвч энэ нь дунд болон түүнээс дээш насныхны хувьд илүү ажиглагдаж байгаа юм. Залуучуудын хувьд энэ талаар мэдээлэл гарч байсан ч тоолгүй өнгөрөөдөг, сувгаа сольдог, тайлан материал нүдэн дээр нь харагдах газар байсан ч авч уншдаггүй гэж иргэд үзэж байна. Мөн залуучууд баг/хорооны ИНХ-даа суудаггүй тул энэ талаарх мэдээллээс бүр ч илүү хоцорч, мэдлэггүй болж байна.

Иргэдийн энэ талаарх мэдээллийг хамгийн их авдаг сувгийг нас, хүйсээр ялган дараах хүснэгтэд харууллаа.

***Хүснэгт 23. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хамгийн их авдаг 5 эх үүсвэр, хүйс/насаар, хувиар***

| Мэдээлэл авдаг эх үүсвэр | Телевиз /орон даяар цацагддаг/ | Телевиз /орон нутгийн/ | Хурал уулзалтын үеэр | Хөрш эсвэл танил | Огт мэдээлэл авдаггүй |
|---|---|---|---|---|---|
| **Хүйс** | | | | | |
| Эрэгтэй | 31.1 | 13.3 | 13.6 | 8.7 | 19.3 |
| Эмэгтэй | 34.5 | 18.0 | 13.4 | 11.4 | 15.2 |
| **Нас** | | | | | |
| 18-24 | 46.3 | 11.6 | 3.2 | 11.6 | 16.8 |
| 25-29 | 31.5 | 13.3 | 12.7 | 15.8 | 14.5 |
| 30-34 | 26.6 | 10.9 | 8.6 | 12.5 | 22.7 |
| 35-39 | 32.6 | 12.3 | 13.8 | 10.1 | 21.0 |
| 40-44 | 34.8 | 19.3 | 16.3 | 10.4 | 11.9 |
| 45-49 | 32.4 | 18.7 | 12.9 | 9.4 | 15.1 |
| 50-54 | 24.6 | 22.4 | 18.7 | 9.7 | 17.9 |
| 55-59 | 39.5 | 16.3 | 15.1 | 7.0 | 19.8 |
| 60- ба түүнээс дээш | 33.9 | 16.7 | 16.7 | 5.0 | 16.1 |

ИТХ-ын төлөөлөгчид, Засаг дарга нар ард иргэдэд өөрсдийгөө таниулах, үйл ажиллагаагаа тайлагнах зорилгоор хэвлэмэл материалыг өрхөөр тараадаг. Төсөв хөрөнгөнөөс шалтгаалан цөөн тоогоор хэвлэх, бүх өрхөөр тарааж чадахгүй байх гэх мэт хүндрэл гардаг ажээ. Ялангуяа Улаанбаатар хотын хувьд дүүргүүд зузаан, олон хуудастай тайлан хэвлүүлдэг ч бүх өрхөд хүрдэггүй байхад ороннутгийн хувьд харьцангуй цөөн хуудастай мэдээллийг олон өрхөд тараадаг нь ИТХ-ын төлөөлөгчдийн ярилцлагаас харагдсан.

**Зураг 13. Нутгийн удирдлагын байгууллагуудаас үйл ажиллагаагаа иргэдэд танилцуулдаг ажлын тайлангийн загварууд**




Хэвлэмэл материалыг ном, сонин, сэтгүүл хэлбэрээр хэвлэж, хэсгийн ахлагч идэвхтэй иргэдээр дамжуулан өрхүүдэд тараадаг байна.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

БЗД-ийн үйл ажиллагааны чиглэл болон 2014 онд хийсэн ажлын талаар тайлан болгож ном гаргасан. Мөн ЗДТГ-ын үйл ажиллагааны тайлан, 1111 лавлах утас, цахим цахимуудаар өргөдөл гомдол хүлээж авах гэх мэт мэдээлэл багтсан. Энэ номыг жил бүр гаргадаг бөгөөд айл өрх бүрт тараадаг. Гэр хорооллын интернэтгүй иргэдэд мэдээлэл хүргэхэд энэ нь хамгийн тохиромжтой арга юм.

***Улаанбаатар хот, БЗД-ийн Засаг дарга***

Сум, аймгийн хувьд бол хэвлэл мэдээллээр иргэдэд мэдээлэл хүргэдэг. Сум жилд дээд тал нь 3-4 удаа сонин гаргадаг. Тэр сонины нэг нүүрэнд ИТХ-ын талаар, үлдсэн хэсэгт нь бусад үйл ажиллагааны талаар нийтэлдэг. Тэгж сонин тараахаар яг үнэхээр ойлгоод уншсан хүн бол байж л байдаг. Аймгийн хувьд бол хуралдаанаа телевизээр цацдаг. Нээлттэй явуулдаг.

***Өвөрхангай аймаг, Гучин-Ус сумын багийн Засаг дарга***

Бид бүхэн ЗДТГ-тай хамтраад “Тариалангийн жавхаа” гэдэг сонингоор дамжуулан иргэдэд мэдээлэл өгдөг. Бид Tarialan.Khuvsgul.khural.mn гээд цахим хуудастай болсон. Мөн хүмүүст фэйсбүүкээр мэдээлэл өгдөг.

***Хөвсгөл аймаг, Тариалан сумын ИТХ-ын дарга***

Багийн ИНХ дээр, багийн өдөрлөг, нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг. Мөн “иргэдээ сонсъё” өдөрлөг, уулзалт зохиож, улирал тутмын сонин хэвлэл, жилдээ нэг удаа тухайн жилийн ажлын тайлангаа орон нутгийн телевизээр танилцуулдаг. (Шарын гол сум нь өөртөө орон нутгийн “Од” телевизтэй ганц хөдөөгийн сум юм)

***Дархан-Уул аймаг, Шарын гол сумын Засаг дарга***

Судалгаанд оролцсон ИТХ-ын Төлөөлөгчид, Засаг дарга нарын хувьд үйл ажиллагаа, гаргасан шийдвэрүүдтэй холбоотой мэдээлэл болон холбогдох утасны дугаар, өөрсдийн танилцуулга, зураг зэрэг мэдээллийг багтаасан хэвлэмэл материалыг өрх бүрт тараадаг бөгөөд үүнийг иргэдэд өөрсдийгөө таниулах, иргэдтэйгээ харилцах харилцааны гол аргын нэг гэж үзэж байна.

*Зураг 14. ИТХ-ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэмэл материал ирсэн эсэх, хувиар*




Иргэдээс ИТХ-ын үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн тайлан, хэвлэмэл материал хүлээн авсан эсэхийг тодруулахад Улаанбаатар хотын иргэдийн 24%, орон нутгийн иргэдийн 28% нь тийм тайлан, материал ирсэн гэжээ. Харин нийт судалгаанд оролцогчдын хувьд 26% нь ямар нэгэн хэвлэмэл материал ирсэн гэж хариулсан байна. Гэтэл төлөөлөгчид болон нутгийн удирдлагуудын зүгээс нийт өрхийн хамгийн багадаа 60%-д хэвлэмэл материал тараасан хэмээн мэдээлсэн.

Гэрт нь хэвлэмэл материал ирсэн гэсэн иргэдээс тухайн материалтай уншиж танилцсан эсэхийг тодруулахад Улаанбаатар хотын иргэдийн 64%, ороннутгийн иргэдийн 79% нь уншиж танилцсан байгааг дараах зургаас харж болно. Харин тухайн хэвлэмэл материалтай  уншиж танилцсан хүмүүсийн хамгийн өндөр хувь буюу 23%-ийг 60 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. Мөн хүйсийн хувьд нийт уг материалыг уншиж танилцсан хүмүүсийн 61% нь эмэгтэй хүмүүс байна. Эндээс харахад өндөр настай хүмүүс эдгээр тайлан материалыг уншиж танилцах хандлага өндөр байна.

*Зураг 15. Иргэдийн хэвлэмэл тайлан, материалтай уншиж танилцсан байдал, хувиар*




Хөдөө орон нутгийн иргэд хэвлэмэл материал гэрт нь очсон тохиолдолд уншиж танилцах хандлага хотын иргэдтэй харьцуулахад илүү өндөр байна.

Уншиж танилцдаггүй хүмүүсийн шалтгааныг тодруулахад *сонгуулийн сурталчилгааны материал л гэж боддог, хэн хийсэн нь мэдэгдэхгүй бүгд л би хийсэн гэсэн байдаг, унших сонирхол төрдөггүй, иймэрхүү зүйлээс залхсан учраас уншдаггүй* гэсэн байна.

www.*khural.mn* ***цахим хуудасны талаарх иргэдийн мэдлэг***

Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх ойлголт, мэдлэгийг иргэдэд олгох, ИТХ-ын үйл ажиллагаа, шийдвэрийн талаар иргэдэд таниулах, иргэдийн оролцоог сайжруулах, ил тод байдлыг хангах үүднээс www.*khural.mn* ИТХ-ын нэгдсэн цахим хуудсыг "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд 2014 оны 9 дүгээр сараас эхлэн нээн ажиллуулж байна. Тус цахим хуудсанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумын ИТХ-ын тухай мэдээлэл, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төлөөлөгчдийн тухай танилцуулга, ИТХ-ын тэргүүн туршлага зэрэг мэдээлэл нийтлэгддэг.

*Зураг 16. ИТХ-ын нэгдсэн цахим хуудас*




Захиалагч байгууллагуудын хүсэлтээр  уг цахим хуудасны талаар иргэд сонссон эсэх, зочилж ордог эсэхийг тодруулахад 4 хүн тутмын 3 нь буюу 75% нь огт сонсоогүй байна. Тус цахим хуудасны талаар сонссон хүмүүсийн 1% нь л тийшээ байнга нэвтэрч мэдээлэл авдаг бол 11% нь урьд өмнө нь нэвтэрч орж байсан гэж хариулжээ. Уг цахим хуудасны талаар мэддэг хэдий ч огт нэвтэрч байгаагүй хүмүүс 88% нь байна.

Дараах хүснэгтэд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн иргэдийн www.*khural.mn* цахим хуудасны талаарх мэдээллийг харьцуулан харууллаа.

***Хүснэгт 24. Khural.mn цахим хуудасны талаар иргэд мэддэг эсэх, хувиар***

| | Сонссон, уг цахим руу байнга нэвтэрдэг | Сонссон, уг цахим руу нэвтэрч байсан | Сонссон, уг цахим руу нэвтэрч үзээгүй | Огт сонсоогүй |
|---|---|---|---|---|
| **Улаанбаатар** | **0.4** | **2.6** | **20.2** | **76.8** |
| БГД | 0.0 | 3.9 | 11.8 | 84.3 |
| БЗД | 1.2 | 0.0 | 25.9 | 72.8 |
| ЧД | 1.3 | 2.6 | 27.6 | 68.4 |
| СХД | 0.0 | 2.7 | 20.4 | 77.0 |
| СБД | 0.0 | 3.0 | 13.9 | 83.2 |
| ХУД | 0.0 | 6.3 | 15.6 | 78.1 |
| НД | 0.0 | 2.2 | 23.9 | 73.9 |
| **Аймгаар** | **0.1** | **2.7** | **23.7** | **73.4** |
| Дархан-Уул | 0.0 | 5.6 | 25.9 | 68.5 |
| Өвөрхангай | 0.0 | 1.2 | 21.3 | 77.4 |
| Хөвсгөл | 0.0 | 4.3 | 18.1 | 77.6 |
| Хэнтий | 0.0 | 1.8 | 33.3 | 64.9 |
| Ховд | 0.9 | 0.9 | 15.1 | 83.0 |

**Одоогийн байдлаар уг цахим хуудасны талаар сонссон хүн Улаанбаатар хотын иргэдийн 23.2%, ороннутгийн иргэдийн 26.5% нь байна. Харин энэ цахимаар байнга зочилж мэдээлэл авдаг хүн Улаанбаатар хотын иргэдийн 0.4%, ороннутгийн иргэдийн 0.1%-ийг л эзэлж байна.**

**Интернетийн хэрэглээ улам нэмэгдэж байгаатай уялдуулан ИТХ-ын байгууллагууд болон төлөөлөгчид цахим хуудсаараа болон олон нийтийн мэдээллийн сүлжээгээр мэдээллийг маш идэвхтэй хүргэж байгаа ч түүнийг хүлээж авч байгаа хүн тун цөөн байна.**

Харин энэ цахим хуудсанд ямар нэгэн байдлаар зочилдог хүмүүсийн 60% нь бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, 60% нь 18-44 насны иргэд байна.

*www.khural.mn* цахим хуудаснаас иргэд ИТХ-ын төлөөлөгчидтэйгээ танилцахаас гадна нутаг орондоо ИТХ-аас гарсан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг авах боломж маш өндөр байна. Гэтэл одоогийн байдлаар Улаанбаатар хотын иргэдийн 3%, ороннутгийн иргэдийн 2.8% нь л тус цахим хуудсанд хандаж мэдээлэл авчээ. Харин мэдээлэл авдаг эх үүсвэрийн хувьд цахим хэлбэрээр (имейл, нутгийн захиргааны болон бусад цахим хуудас) мэдээлэл авдаг гэж нийт иргэдийн 4.5% нь хариулсан байна.

### 3.3.2. Аймаг/нийслэлийн ИТХ-ын талаар

Иргэдээс аймаг/нийслэлийн ИТХ болон сум/дүүргийн ИТХ нь тус бүртээ иргэдтэй хэрхэн ажилладаг, үйл ажиллагаагаа тайлагнадаг эсэх, гаргасан шийдвэрийг нь иргэд мэддэг эсэхийг тодруулж, шат шатны ИТХ тус бүрийг иргэдээр үнэлүүлсэн юм.

**Мэдээлэл цуглуулах явцад ажиглахад нутгийн удирдлагын байгууллагын талаар, ялангуяа ИТХ-ын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл маш муу байв.**

**ИТХ-ын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар ерөнхий ойлголт муу байсны зэрэгцээ уг байгууллага нь аймаг/нийслэл, сум/дүүргийн гэсэн хоёр түвшинд ажилладаг талаар ойлголт бүр ч дутмаг байв.** Учир нь ихэнх оролцогчдын хувьд мэдэхгүй/санахгүй байна гэх байдлаар хариулт өгч байснаас гадна ярилцлагын явцад судалгаанд оролцогчдод аймаг/нийслэлийн ИТХ-ын талаар асуух гэж байна, сум/дүүргийн ИТХ-ын талаар асуух гэж байна гэх мэт тайлбарыг эхлээд маш сайн тайлбарлаж ярилцлагыг үргэлжлүүлж байсан юм.

Харин энэ дэд бүлгээс аймаг/нийслэлийн ИТХ-ын талаарх иргэдийн үнэлэлт, ойлголтын талаарх үр дүнг харж болох юм.

### *Иргэд аймаг/нийслэлийн ИТХ-ын тайлантай танилцсан байдал*

Тухайн аймаг/нийслэлийн ИТХ иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг эсэхийг иргэдээс асуухад Улаанбаатар хотын иргэдийн 41%, хөдөө орон нутгийн иргэдийн 46% нь их бага ямар нэгэн байдлаар иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж үзжээ. Харин бүгдийг нь тайлагнадаг гэж Налайх дүүрэг, Ховд аймгийн иргэд хамгийн өндөр хувьтай хариулав.

*Хүснэгт 25. Аймаг/нийслэлийн ИТХ иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг байдал, хувиар*

| | Бүгдийг тайлаг-надаг | Дийлэнхийг тайлаг-надаг | Тал хувийг тайлаг-надаг | Цөөн хувийг тайлаг-надаг | Огт тайлаг-надаггүй | Мэдэхгүй санахгүй байна |
|---|---|---|---|---|---|---|
| **Улаанбаатар** | **4.2** | **8.0** | **14.4** | **14.2** | **20.2** | **39.0** |
| БГД | 3.9 | 9.8 | 9.8 | 7.8 | 13.7 | 54.9 |
| БЗД | 2.5 | 7.4 | 18.5 | 19.8 | 17.3 | 34.6 |
| ЧД | 0.0 | 9.2 | 9.2 | 19.7 | 21.1 | 40.8 |
| СХД | 7.1 | 8.0 | 14.2 | 15.9 | 19.5 | 35.4 |
| СБД | 4.0 | 7.9 | 10.9 | 8.9 | 24.8 | 43.6 |
| ХУД | 0.0 | 3.1 | 9.4 | 9.4 | 34.4 | 43.8 |
| НД | 10.9 | 8.7 | 32.6 | 13.0 | 13.0 | 21.7 |
| **Хөдөө орон нутаг** | **7.1** | **14.1** | **13.4** | **10.6** | **14.3** | **40.4** |
| Дархан-Уул | 6.3 | 21.0 | 18.9 | 15.4 | 8.4 | 30.1 |
| Өвөрхангай | 4.3 | 11.6 | 16.5 | 11.0 | 21.3 | 35.4 |
| Хөвсгөл | 5.2 | 12.1 | 11.2 | 11.2 | 15.5 | 44.8 |
| Хэнтий | 9.4 | 18.7 | 7.0 | 6.4 | 4.1 | 54.4 |
| Ховд | 11.3 | 3.8 | 14.2 | 9.4 | 26.4 | 34.9 |

Улаанбаатар хотын Налайх дүүргийн иргэдийн НӨУБ-ын талаарх мэдлэг харьцангуй өндөр байгаа нь чанарын судалгааны явцад ажиглагдав.Үйл ажиллагаагаа ямар нэгэн байдлаар тайлагнадаг гэж боддог иргэдийн хувьд ямар бодолтой байдгийг доорх чанарын судалгааны дүнгээс дэлгэрүүлж харна уу.

> *Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*
>
> Ер нь орон нутагт гардаг сонин дээр үйл ажиллагаагаа тайлагнадаг байх. Гэхдээ тэр сонины 1-р нүүр эсвэл 2-р нүүрэн дээр нь ИТХ-ын талаар мэдээлэл гардаг боловч яг гаргасан шийдвэр, үйл ажиллагаа гэхээсээ илүү Хурлын даргын мэндчилгээ байх жишээтэй л байдаг даа.
>
> ***Хэнтий аймаг, Хэрлэн сумын иргэн, эрэгтэй***
>
> Одоо бол нэг хүүхэд хаалга тогшоод “май ахаа” гээд л нэг юм өгчихөөд явна. Нэг бол хаалганы завсраар сэтгүүл хавчуулаад л явчихна. Ямар ч нэгдсэн тогтолцоо, ард иргэддээ мэдээлэл өгөх үйл ажиллагаагаа тайлагнах тогтсон дүрэм гэж байхгүй. Дээр үед биднийг хүүхэд байхад 5 дахь өдөр болгон лекц сонсголтой байлаа. Бүгд оролцох ёстой. Тэндээс бүгд мэдээлэл авчихдаг, хаана ямар шийдвэр гарсан, ямар шаттай хэрэгжиж байгааг бүгд мэддэг байлаа.
>
> ***Дархан-Уул аймаг, Дархан сумын иргэн, эрэгтэй***
>
> Брошур материалаар ирээд л ТВ-ээр ганц нэг яриад л байх шиг байдаг юм. Гэхдээ бидэнтэй яг нүүр тулж хэзээ ч ярилцдаггүй. Төлөөлөгч нар нь хүмүүс томилоод ч болов хүмүүстэй нүүр тулж ярилцаад санал хүсэлтийг нь сонсоод, санал аваад явах хэрэгтэй. Амьд брошур илүү дээр шүү дээ. Тэр нь цаашаа ам дамжсан яриагаар тараад л явна.
>
> ***Ховд аймаг, Жаргалант сумын иргэн, эрэгтэй***

Судалгаанд хамрагдсан сум тус бүрээр иргэдийн энэ талаарх ойлголт ямар байгааг харахад Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын иргэдийн 70% нь ИТХ ямар нэгэн байдлаар иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж үзсэн нь хамгийн өндөр хувь юм. Мөн Дархан-Уул аймгийн Дархан сумын иргэдийн 66%, Шарын гол сумын иргэдийн 61% нь мөн адил тайлагнадаг гэж үзсэн байна. Харин огт тайлагнадаггүй гэж үзсэн хувь хамгийн өндөр байгаа нь Ховд аймгийн Булган сум байна. Учир нь Булган сумын судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 51% нь тухайн аймгийн ИТХ үйл ажиллагаагаа огт тайлагнадаггүй гэж үзсэн байна.

Иргэдийн хувьд ийм бодол, ойлголттой байдаг бол ИТХ-ын Төлөөлөгчдийн хувьд иргэддээ үйл ажиллагаагаа бүхий л аргыг ашиглан тайлагнадаг гэж ярьж байв.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

ИНХ дээрээ уулздаг, иргэдийг хүлээн авах өрөө, албан өрөөндөө хүлээж авч уулздаг, утсаар нээлттэй харилцдаг, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулдаг. Гудамж талбайд, гэр орноор нь явж уулздаг.

***Дархан-Уул аймаг, Дархан сумын Засаг дарга***

ИНХ дээрээ уулздаг, иргэдийг хүлээн авах өрөө, албан өрөөндөө хүлээж авч уулздаг, утсаар нээлттэй харилцдаг, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулдаг. Гудамж талбайд, гэр орноор нь явж уулздаг.

***Дархан-Уул аймаг, Дархан сумын Засаг дарга***

Багийн ИНХ дээр мэдээлэл өгдөг, зорилтот бүлгүүдийг цуглуулаад нүүр тулж уулзаад мэдээлэл өгдөг. Хэсгийн ахлагч нар иргэдтэй уулзаж мэдээлэл өгдөг.

***Өвөрхангай аймаг, Арвайхээр сумын багийн Засаг дарга***

Багийн ИНХ-ыг жилд 4-5 удаа зохион байгуулахдаа очиж уулздаг. Багийн иргэд ирээд нээлттэй уулзчихдаг. Малын тооноор яваад малчидтайгаа уулздаг. Хөтөл хорооллоор бол тог цахилгаан тавих, худаг ус гаргах, хаягжилт хийх, зам талбай янзлах тухай бүрт нь очоод уулздаг.

***Дархан-Уул аймаг, Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгч***

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж мэдээлэл өгч байгаа нь тодорхой зорилтот түвшний иргэдэд хүрч чаддаг нь харагдаж байна. Гэвч ямар нэгэн байдлаар ажлаа тайлагнадаг гэсэн хувь хамгийн өндөр гарсан орон нутгийн Төлөөлөгчид иргэдтэйгээ хэрхэн харилцдагаас харахад ихэнхдээ тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахаас гадна өөрсдөө боломжтой нөхцөл, тохиолдолд иргэдтэйгээ нээлттэй уулзалт хийж, санал бодлыг нь сонсдог болох нь харагдаж байна.

### *Иргэд аймаг/нийслэлийн ИТХ-ын шийдвэрийн талаар мэддэг байдал*

Аймаг/нийслэлийн ИТХ-аас гаргасан шийдвэрээ иргэддээ мэдээлдэг эсэхийг иргэдээс тодруулахад Улаанбаатар хотын иргэдийн 48% нь ямар нэг хэмжээгээр гарсан шийдвэртэй холбоотой мэдээлэл өгдөг гэжээ. Өмнөх хэсэгт нийслэлийн ИТХ нь үйл ажиллагаагаа тайлагнадаг эсэхийг асуухад ямар нэг хэмжээгээр тайлагнадаг гэж 41% нь хариулсан.

Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд Дархан-Уул аймгийн иргэдийн 55% нь аймгийн ИТХ нь гаргасан шийдвэрүүдтэй холбоотой мэдээллээ иргэдэд ямар нэг хэмжээгээр өгдөг гэжээ. Энэ нь бусад аймагтай харьцуулахад 10 гаруй хувиар өндөр үзүүлэлт юм.

*Хүснэгт 26. Аймаг/нийслэлийн ИТХ иргэддээ гаргасан шийдвэрээ мэдээлдэг байдал, хувиар*

| | Бүгдийг мэдээлдэг | Дийлэн-хийг мэдээлдэг | Тал хувийг мэдээлдэг | Цөөн хувийг мэдээлдэг | Огт мэдээл-дэггүй | Мэдэхгүй санахгүй байна |
|---|---|---|---|---|---|---|
| **Улаанбаатар** | **1.8** | **10.2** | **16.4** | **20.0** | **21.4** | **30.2** |
| БГД | 3.9 | 7.8 | 21.6 | 13.7 | 15.7 | 37.3 |
| БЗД | 1.2 | 8.6 | 22.2 | 17.3 | 21.0 | 29.6 |
| ЧД | 1.3 | 7.9 | 13.2 | 28.9 | 17.1 | 31.6 |
| СХД | 0.9 | 13.3 | 15.0 | 23.9 | 23.0 | 23.9 |
| СБД | 2.0 | 11.9 | 10.9 | 11.9 | 24.8 | 38.6 |
| ХУД | 0.0 | 9.4 | 6.3 | 28.1 | 31.3 | 25.0 |
| НД | 4.3 | 8.7 | 28.3 | 19.6 | 17.4 | 21.7 |
| **Хөдөө орон нутаг** | **5.6** | **15.0** | **13.3** | **11.7** | **16.6** | **37.9** |
| Дархан-Уул аймаг | 6.3 | 16.1 | 15.4 | 17.5 | 9.8 | 35.0 |
| Өвөрхангай аймаг | 4.9 | 15.2 | 15.9 | 11.0 | 20.7 | 32.3 |
| Хөвсгөл аймаг | 5.2 | 17.2 | 15.5 | 9.5 | 12.9 | 39.7 |
| Хэнтий аймаг | 5.8 | 14.0 | 8.2 | 9.4 | 8.8 | 53.8 |
| Ховд аймаг | 5.7 | 12.3 | 12.3 | 11.3 | 35.8 | 22.6 |

Дархан-Уул аймгийн Дархан сумын иргэдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагад оролцсон иргэдийн хувьд ч нутаг орондоо ИТХ-ын гаргасан шийдвэрүүдийг маш сайн мэдэж байв.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

8 нэрийн бүх дэлгүүр архи зардаг байсан. Тэрийг баг болгоноос 2 л дэлгүүр зардаг болгосон. Хогийн савын цэгийг бас байршуулсан. Хоёр байрны дунд нэг байхаар зохицуулсан. Олон нийтийн цагдаа бас гаргасан. Энэ нь гэмт хэргээс урьдчилсан сэргийлсэн чухал ажил болсон. Сум, баг дээрээ цагдаа ирэхээс түрүүлж зөрчил илрүүлдэг, цагдаад мэдээлдэг. Ер нь ИНХ-д байнга суудаг хүмүүст мэдээлэл хангалттай очдог гэж боддог. Хийсэн ажлууд нь ч нүдэнд харагдаад л ирдэг.

***Дархан-Уул аймаг, Дархан сумын иргэн, эмэгтэй***

> Хуучин шинэ 2 Дарханыг холбосон гурав дахь нөөцийн зам болох хар зам тавигдаж байгаа. 2014 онд ажил нь эхэлчихсэн явагдаж байна. Мөн 12-р сургуулийн чиглэлд 7-р багийн нутаг дэвсгэр дээр 1.8 км нэг их хэл амтай зам тавигдсан. Олон жил сайжруулж өгөөч гэж иргэд бид саналаа өгсөний үндсэн дээр засч өгсөн. Иргэдийн саналыг бичгээр авдаг, ИНХ дээр гар өргүүлдэг.
>
> ***Дархан-Уул аймаг, Дархан сумын иргэн, эрэгтэй***

Харин ямар нэгэн байдлаар (*бүгдийг нь, дийлэнхийг нь, тал хувийг нь, цөөн хувийг нь тайлагнадаг болон мэдээлдэг гэж хариулсан)* аймаг/нийслэлийн ИТХ нь иргэддээ үйл ажиллагаа тайлагнадаг, гаргасан шийдвэрээ иргэддээ мэдээлдэг гэж үзсэн иргэдийн хувьд баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд оролцож байсан, өнгөрсөн жил ИНХ-д оролцсон байна. Учир нь үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж үзсэн иргэдийн 59% нь баг хорооны ИНХ-д оролцсон хүмүүс байгаа юм. *(ИНХ-ын оролцоотой холбоотой бүлгийг бүлэг 3.5-аас харна уу)*

Баг/хороондыхоо ИНХ-д оролцдог иргэдийн хувьд ИТХ-ын үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой мэдээллийг олж авч байгаа байдал бусад иргэдээс өндөр байна.

***Иргэд аймаг/нийслэлийн ИТХ-ын шийдвэрийг нэрлэсэн байдал***

Иргэдээс аймаг/нийслэлийн ИТХ-аас ямар ямар шийдвэр гарсаныг нэрлүүлэхэд Улаанбаатар хотын иргэдийн 66% огт нэрлэж мэдэхгүй байв. Харин хөдөө орон нутгийн иргэдийн хувьд Хөвсгөл аймгийн иргэдийн 87%, Ховд аймгийн иргэдийн 83%, Өвөрхангай аймгийн иргэдийн 82%, Хэнтий аймгийн иргэдийн 71%, Дархан-Уул аймгийн иргэдийн 63% нь аймгийнхаа ИТХ-аас гарсан шийдвэрээс огт нэрлэж чадахгүй байна.

Иргэд дараах шийдвэрийг аймаг/нийслэлийн ИТХ-ын шийдвэр гэж нэрлэжээ. (*Хамгийн их давтагдсан дараалаар эрэмбэлэн жагсаав.)*

### *Хүснэгт 27. Аймаг/нийслэлийн ИТХ-аас гаргасан шийдвэрүүдийг иргэд нэрлэсэн байдал*

| *Аймаг/нийслэлийн ИТХ-аас гаргасан шийдвэрүүд – Иргэдийн нэрлэснээр* | |
|---|---|
| ***Улаанбаатар хот*** | • Машины дугаарын хязгаарлалт тогтоосон<br>• Хогны уут айл бүрт тараасан<br>• Хотын дахин төлөвлөлтийг хийж байгаа<br>• Газар өмчлөлийг явуулсан<br>• Авто зам болон явган хүний зам засвар хийсэн<br>• Цаг урагшлуулах шийдвэр гаргасан<br>• Сургууль цэцэрлэгийг нэмж байгуулсан<br>• Төрийн албан хаагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр байр олгох<br>• Хотын төвийн ногоон байгууламж хийсэн<br>• Гэрэлтүүлэг хийсэн<br>• Авто замын зохицуулалт (Автобус 1-р эгнээгээр явах)<br>• Зөвшөөрөлгүй барилгыг нураасан<br>• Орон сууцны 8%-ийн зээлийг гаргасан<br>• Худаг сайжруулсан<br>• Машины татварыг сар сараар өөрчилсөн<br>• Гэр хорооллын гудамжийг тохижуулсан<br>• Нийтийн тээврийг цахим картаар үйлчилдэг болгосон<br>• Гүүрний засварын ажил хийсэн |
| ***Дархан-Уул аймгийн иргэд*** | • Авто зам болон явган хүний зам засвар хийсэн<br>• Цэцэрлэг нэмж барьсан<br>• Хүүхдийн тоглоомын талбай барьсан<br>• Ажилгүйдлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн<br>• Гэр хорооллыг устай болгох ажил хийсэн<br>• Гүүр барьсан<br>• Газар төлөвлөлт хийсэн<br>• Жижиг хороолол байгуулах шийдвэр гаргасан<br>• Малын бэлчээр ашиглалт, хуваарилалт, хамгаалалтын журам гаргасан<br>• Гэрэлтүүлэг сайжруулсан<br>• Хогийн савнууд шинээр тавьсан<br>• Хуучин орон сууцнуудыг шинэчлэх, засварт оруулахаар шийдсэн |

| | |
|---|---|
| ***Өвөрхангай аймгийн иргэд*** | • Эрүүл мэндийг дэмжих жил зарласан<br>• Архи тамхигүй хөтөлбөр зарласан<br>• Зам хөтөлбөр зарласан<br>• Сум хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан<br>• Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих жил зарласан<br>• Бэлчээрийн цөлжилтийг бууруулах ажил хийгдэж байгаа<br>• Үндны усыг цэвэршүүлэх ажил хийгдэж байгаа<br>• Занабазар бүтээл хөшөө, цэцэрлэгт хүрээлэн байгуулах шийдвэр гаргасан<br>• Спорт урлагаа хөгжүүлэх ажил хийгдэж байгаа |
| ***Хөвсгөл аймгийн иргэд*** | • Авто зам болон явган хүний зам зассан<br>• Өрхийн амьжиргааг дээшлүүлэх төсөл хэрэгжүүлсэн<br>• Залуучуудыг дэмжих жил зарласан<br>• Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ<br>• Гүний худаг гаргах ажил хийгдсэн<br>• Өлийн давааг зассан<br>• Ой хамгаалах ажил хийгдсэн<br>• Сум хөгжүүлэх төсөл боловсруулсан<br>• Гэрэлтүүлэг сайжруулсан<br>• Гүүр зассан (сумдад)<br>• Цэцэрлэг байгуулсан (сумдад)<br>• Биеийн тамирын талбайтай болгосон |
| ***Хэнтий аймгийн иргэд*** | • Архигүй Хэнтий хөтөлбөр хэрэгжүүлсэн<br>• Орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжиж байгаа<br>• Эмнэлгийн тоног төхөөрөмж шинэчилсэн<br>• Хоггүй орчин хөтөлбөр хэрэгжүүлсэн<br>• Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажил хийгдсэн<br>• Авто зам болон явган хүний зам засварын ажил хийгдсэн<br>• Мал сүрэг онд мэнд оруулах ажлууд хийсэн<br>• Төсөв баталсан<br>• Хүүхэд залуучууд болон ахмадыг дэмжих жил болгон зарласан<br>• Газар зохион байгуулалтын ажил хийсэн<br>• Байгаль орчин хамгаалах шийдвэр гаргасан<br>• Баяжуулах үйлдвэртэй холбоотой шийдвэр гарсан<br>• Цэцэрлэг барьсан<br>• Онцгой байдлын барилга барьж байгаа<br>• Нохой устгалын ажил хийгдсэн |

| | |
|---|---|
| ***Ховд аймгийн иргэд*** | • Сум хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан<br>• Авто зам болон явган хүний зам засварын ажил хийгдсэн<br>• Амьжиргааны түвшинг сайжруулах ажил хийгдсэн<br>• Гэрэлтүүлгийг сайжруулсан<br>• Орон сууцны барилгуудыг барьж байгаа<br>• Гудамж талбайг цэвэрлэх ажлууд хийгдсэн<br>• Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарласан<br>• Спорт цогцолбор баригдах шийдвэр гаргасан<br>• Тог цахилгааны асуудлыг шийдэх тал дээр ажил хийгдсэн<br>• Цэцэрлэг барих шийдвэр гаргасан<br>• Ногоон байгууламж хийсэн |

Харин ганцаарчилсан ярилцлагын үеэр тухайн орон нутагт хийгдсэн том ажлууд, гарсан гол шийдвэрүүдийн талаар асуусан юм. Тэгэхэд Төлөөлөгчид дараах ажлыг нийтлэг дурдсан байна.

- ОНХС-гийн хуваарийг баталсан;
- Орон нутгийн төсөв баталсан;
- Холбогдох бодлогын баримт бичгүүдийг баталсан;
- Төсвийн гүйцэтгэлд хяналт тавьсан;
- Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг баталсан;
- Орон нутгийн хөгжилтэй холбоотой бусад асуудлууд,

Дээрхээс харахад тухайн орон нутгийн төсөв төлөвлөгөөг батлах, ОНХС-гийн хөрөнгийн хуваарилалтыг батлах ажил маш чухал ч иргэдийн хувьд эдгээр шийдвэрийг ИТХ гаргадагийг мэдэхгүй байна. Харин иргэдийн хувьд нүдэн дээр нь өөрчлөгдөж буй бүтээн байгуулалт, амьдралд нь нөлөөлж буй тогтоол, шийдвэр хамгийн түрүүнд санаанд нь буудаг байна.

### *Аймаг/нийслэлийн ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн үнэлгээ*

Улаанбаатар хотын иргэдийн хувьд НИТХ-д хамгийн өндөр буюу 41% нь дунд зэрэг гэсэн үнэлгээ өгчээ. Харин эерэг үнэлгээ өгсөн нийлбэр дүн нь 18%, сөрөг үнэлгээ өгсөн нийлбэр дүн нь 16% байна.

*Хүснэгт 28. НИТХ-ын үйл ажиллагааны талаарх Улаанбаатар хотын иргэдийн үнэлгээ*

| Үнэлгээ | Тоо | Хувь |
|---|---|---|
| Маш сайн | 19 | 3.8 |
| Зарим талаар сайн | 73 | 14.6 |
| Дунд | 206 | 41.2 |
| Зарим талаар муу | 20 | 4.0 |
| Маш муу | 62 | 12.4 |
| Мэдэхгүй | 116 | 23.2 |
| Хариулахаас татгалзсан | 4 | 0.8 |
| **Нийт** | 500 | 100 |

"Маш сайн" гэж үнэлсэн иргэдээс шалтгааныг тодруулахад, *1) ил тод, нээлттэй болсон, 2) хийсэн ажил нь нүдэн дээр хэрэгжиж, амьдралд нөлөөлдөг болсон, 3) олон нийтэд мэдээлэл сайн өгдөг* болсон гэсэн 3 шалтгаанаар энэхүү үнэлгээг өгсөн байна.

Харин "Зарим талаараа сайн" гэж үнэлсэн иргэдийн ингэж үнэлсэн шалтгаан нь *зарим шийдвэрийн хэрэгжилт муу байдаг, зарим шийдвэр нь сэтгэлд хүрдэггүй, мэдээлэл хангалттай биш, нарийн асуудлыг сайн мэдэхгүй байна зэрэг*

*байв*. Мөн үүнээс гадна *хот өмнөхөөсөө илүү гоё болж байгаа, хөгжил нүдэн дээр харагдаж байна, өмнө нь мэдрэгддэггүй байсан одоо хийсэн ажлууд нь мэдрэгддэг болсон* гэх мэт шалтгааныг дурджээ.

“Маш муу” болон “Зарим талаараа муу” гэсэн үнэлгээ өгсөн иргэдээс шалтгааныг нь тодруулахад *1) иргэдтэйгээ уулздаггүй, мэдээллээ өгч чаддаггүй, 2) хийж байгаа юм байхгүй, 3) иргэдийн амьдралыг бодитоор сайжруулах ажил хийдэггүй* зэргийг нэрлэсэн байна.

Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд *“Маш сайн”* болон *“Зарим талаар сайн”* гэсэн үнэлгээний нийлбэр хувь хамгийн өндөр байгаа нь Дархан-Уул аймаг байна. Харин Хэнтий аймгийн хувьд сайн үнэлгээ өгсөн нийлбэр хувь 30.4%, Хөвсгөл аймаг 25%, Ховд аймаг 24.5%, Өвөрхангай аймаг 23.2% байна.

***Хүснэгт 29. Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ, аймгаар, хувиар***

| | Маш сайн | Зарим талаар сайн | Дунд | Зарим талаар муу | Маш муу | Мэдэхгүй санахгүй байна | Хариулахаас татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хөдөө орон нутаг | **5.3** | **22.0** | **34.4** | **3.6** | **5.6** | **28.6** | **0.6** |
| **Аймгаар** | | | | | | | |
| Дархан-Уул | 0.0 | 32.2 | 37.1 | 7.0 | 4.2 | 18.9 | 0.7 |
| Өвөрхангай | 6.1 | 17.1 | 33.5 | 2.4 | 2.4 | 38.4 | 0.0 |
| Хөвсгөл | 6.9 | 18.1 | 44.0 | 2.6 | 4.3 | 23.3 | 0.9 |
| Хэнтий | 8.2 | 22.2 | 26.3 | 2.9 | 6.4 | 33.3 | 0.6 |
| Ховд | 4.7 | 19.8 | 34.9 | 2.8 | 12.3 | 24.5 | 0.9 |

Аймгийн ИТХ-д ямар учраас ийм үнэлгээ өгч байгааг аймаг тус бүрээр дор харуулав.

***Хүснэгт 30. Аймгийнхаа ИТХ-д өгсөн үнэлгээ, түүний шалтгаан, аймаг тус бүрээр***

| | *“Маш сайн”* болон *“Зарим талаараа сайн”* гэсэн үнэлгээ өгсөн шалтгаан | *“Маш муу”* болон *“Зарим талаараа муу”* гэсэн үнэлгээ өгсөн шалтгаан |
|---|---|---|
| ***Дархан-Уул аймгийн иргэд*** | *Сайн үнэлгээ өгсөн* – 32.2%<br>• Хийж байгаа ажил нь нүдэнд харагддаг<br>• Нээлттэй ил тод мэдээлдэг, үйл ажиллагаагаа тайлагнадаг<br>• Иргэддээ чиглэсэн, хэрэгцээнд нийцсэн шийдвэрүүд гаргадаг | *Муу үнэлгээ өгсөн* – 11.2%<br>• Иргэддээ мэдээлэл маш муу өгдөг<br>• Иргэдийн амьжиргаа дээшлэхгүй байна<br>• Хийж байгаа ажил байхгүй, иргэдэд мэдрэгдэхгүй байна |
| ***Өвөрхангай аймгийн иргэд*** | *Сайн үнэлгээ өгсөн* – 23.2%<br>• Иргэдийн төлөө сайн ажиллаж чадаж байна<br>• Орон нутагтаа ажил боломжийн хийж байгаа | *Муу үнэлгээ өгсөн* – 4.8%<br>• Мэдээлэл өгдөггүй<br>• Ард иргэдтэйгээ харьцдаггүй, уулздаггүй |

| | | |
|---|---|---|
| ***Хөвсгөл аймгийн иргэд*** | *Сайн үнэлгээ өгсөн* – 25.0 %<br>• Амлалтууд нь биеллээ олж чаддаг<br>• Иргэдтэйгээ уулзалтууд зохион байгуулдаг<br>• Нээлттэй ил тод ажиллаж чадаж байна | *Муу үнэлгээ өгсөн* – 6.9%<br>• Ард түмнээсээ санал хүсэлтийг нь сонсдоггүй<br>• Ард түмэндээ тайлан тавьдаггүй<br>• Хийж байгаа ажил байхгүй |
| ***Хэнтий аймгийн иргэд*** | *Сайн үнэлгээ өгсөн* – 30.4%<br>• Аймагт бүтээн байгуулалт сайн хийгдэж байна<br>• Гаргасан шийдвэрээ хэрэгжүүлж чаддаг, иргэдээрээ мөрдүүлж чадаж байна<br>• Мэдээлэл цахимай байдаг | *Муу үнэлгээ өгсөн* – 9.3%<br>• Иргэддээ мэдээлэл маш муу өгдөг<br>• Иргэдийн төлөө огт үйлчлэхгүй байна<br>• Хоорондоо хэл амтай ажил нь урагштай явдаггүй |
| ***Ховд аймгийн иргэд*** | *Сайн үнэлгээ өгсөн* – 2.5%<br>• Аймгийн гадаад орчны тохижилт гайгүй сайн болж байна<br>• Зарим нэг бүтээн байгуулалт хийгдэж байна | *Муу үнэлгээ өгсөн* – 15.7%<br>• Мэдээлэл огт байхгүй<br>• Хүнд сурталтай<br>• Ард түмэнтэйгээ ойр ажилладаггүй |

Нийслэл хотын иргэдтэй харьцуулахад орон нутгийн иргэдийн хувьд сайн үнэлгээ өгч байгаа шалтгааныг харахад яг тийм ажил хийсэн гэж хэлэхээсээ илүү ИТХ нь ерөнхий байдлаараа иргэддээ мэдээлэл өгч чаддаг болсон, хийж байгаа ажил нь нүдэнд харагддаг болсон гэх мэт шалтгааныг дурдсан байна. Харин тааруу үнэлгээ өгсөн иргэдийн хувьд ихэнх тохиолдолд мэдээлэл байхгүй гэсэн шалтгааныг дурдсан байна.

### 3.3.3. Сум/дүүргийн ИТХ-ын талаар

Өмнөх дэд бүлэгт аймаг/нийслэлийн ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт, хандлага, үнэлгээ түүний шалтгаантай холбоотой үр дүнг танилцуулсан бол энэ бүлэгт дүүрэг, сумдын ИТХ-ын иргэдтэй хэрхэн хамтран ажиллаж байгаа, ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн өгч буй үнэлгээ, түүний шалтгааныг авч үзэх болно.

#### *Иргэд Сум/дүүргийн ИТХ-ын тайлантай танилцсан байдал*

Нийслэл хотын хувьд Налайх дүүргийн иргэд хамгийн өндөр хувьтай буюу 63% нь иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг гэжээ. Харин ИТХ үйл ажиллагаагаа ямар нэг байдлаар тайлагнадаг гэж үзсэн хувь хамгийн бага байгаа нь Хан-Уул, Баянгол дүүрэг байна. Энэ 2 дүүргийн 4 иргэн тутмын 3 нь огт тайлагнадаггүй болон мэдэхгүй гэж хариулжээ. Огт тайлагнадаггүй гэж Хан-Уул дүүргийн иргэдийн 47% үзсэн нь бусад дүүрэгтэй харьцуулахад бараг 2 дахин өндөр хувьтай юм. Хан-Уул дүүргийн хувьд орон сууцны хороолол ихтэй, шинээр суурьшсан айл их байдагтай холбоотой байх талтай.

Улаанбаатар хотын хувьд дүүргийн ИТХ нь үйл ажиллагаагаа тайлагнадаг тухай огт мэдэхгүй гэж 40% нь хариулжээ.

*Хүснэгт 31. Дүүргийн ИТХ иргэддээ үйл ажиллагаа тайлагнадаг байдал, дүүргээр, хувиар*

| | Бүгдийг тайлаг-надаг | Дийлэн-хийг тайлаг-надаг | Тал хувийг тайлаг-надаг | Цөөн хувийг тайлаг-надаг | Огт тайлагна даггүй | Мэдэхгүй санахгүй байна |
|---|---|---|---|---|---|---|
| **Улаанбаатар** | **5.6** | **8.4** | **12.6** | **9.0** | **24.0** | **40.4** |
| БГД | 3.9 | 15.7 | 2.0 | 7.8 | 23.5 | 47.1 |
| БЗД | 1.2 | 6.2 | 13.6 | 12.3 | 25.9 | 40.7 |
| ЧД | 6.6 | 9.2 | 11.8 | 10.5 | 22.4 | 39.5 |
| СХД | 8.0 | 7.1 | 14.2 | 8.0 | 18.6 | 44.2 |
| СБД | 5.9 | 9.9 | 10.9 | 2.0 | 25.7 | 45.5 |
| ХУД | 0.0 | 3.1 | 3.1 | 15.6 | 46.9 | 31.3 |
| НД | 10.9 | 6.5 | 30.4 | 15.2 | 17.4 | 19.6 |

Харин хөдөө орон нутгийн иргэдээс хувьд сумын ИТХ үйл ажиллагаагаа иргэддээ хэр тайлагнадаг гэж үзсэнийг дор сум тус бүрээр харуууллаа.

*Хүснэгт 32. Сумын ИТХ иргэддээ үйл ажиллагаа тайлагнадаг байдал, сумдаар, хувиар*

| | Бүгдийг тайлаг-надаг | Дийлэн-хийг тайлаг-надаг | Тал хувийг тайлаг-надаг | Цөөн хувийг тайлаг-надаг | Огт тайлагна даггүй | Мэдэхгүй санахгүй байна |
|---|---|---|---|---|---|---|
| **Хөдөө орон нутаг** | **11.4** | **21.0** | **15.6** | **9.6** | **12.0** | **30.4** |
| **Дархан-Уул** | 7.7 | 29.4 | 16.1 | 14.0 | 8.4 | 24.5 |
| Дархан сум | 2.9 | 34.3 | 10.0 | 11.4 | 5.7 | 35.7 |
| Шарын гол сум | 23.7 | 34.2 | 13.2 | 15.8 | 0.0 | 13.2 |
| Хонгор сум | 0.0 | 14.3 | 31.4 | 17.1 | 22.9 | 14.3 |
| **Өвөрхангай** | 9.1 | 17.1 | 19.5 | 8.5 | 14.6 | 31.1 |
| Арвайхээр | 8.5 | 17.0 | 14.9 | 8.5 | 14.9 | 36.2 |
| Хархорин | 11.8 | 9.8 | 5.9 | 13.7 | 21.6 | 37.3 |
| Гучин-Ус | 7.6 | 22.7 | 33.3 | 4.5 | 9.1 | 22.7 |
| **Хөвсгөл** | 14.7 | 21.6 | 15.5 | 7.8 | 6.9 | 33.6 |
| Мөрөн | 4.7 | 9.3 | 16.3 | 2.3 | 11.6 | 55.8 |
| Эрдэнэбулган | 25.6 | 27.9 | 14.0 | 16.3 | 7.0 | 9.3 |
| Тариалан | 13.3 | 30.0 | 16.7 | 3.3 | 0.0 | 36.7 |
| **Хэнтий** | 15.8 | 24.0 | 12.3 | 5.3 | 9.9 | 32.7 |
| Хэрлэн | 6.0 | 10.0 | 14.0 | 8.0 | 12.0 | 50.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Батноров | 16.0 | 37.3 | 12.0 | 5.3 | 9.3 | 20.0 |
| Өмнөдэлгэр | 26.1 | 17.4 | 10.9 | 2.2 | 8.7 | 34.8 |
| | | | | | | |
| **Ховд** | 9.4 | 10.4 | 14.2 | 14.2 | 21.7 | 30.2 |
| Жаргалант | 0.0 | 3.2 | 9.7 | 9.7 | 19.4 | 58.1 |
| Булган | 0.0 | 2.6 | 17.9 | 17.9 | 38.5 | 23.1 |
| Манхан | 27.8 | 25.0 | 13.9 | 13.9 | 5.6 | 13.9 |

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэдийн 56%, Ховд аймгийн Жаргалант сумын иргэдийн 58% нь сумын ИТХ иргэддээ үйл ажиллагаагаа тайлагнадаг эсэхийг огт мэдэхгүй хэмээн хариулжээ. Ховд аймгийн Булган сумын иргэдийн 39% нь сумын ИТХ үйл ажиллагаагаа огт тайлагнадаггүй гэж үзсэн нь бусад сумтай харьцуулахад бараг 2 дахин өндөр байгаа юм. Ховд аймгийн Булган сумын иргэдтэй хийсэн ФБЯ-ын дүнд ч мөн адил иргэдэд мэдээ мэдээлэл маш бага хүрдэг гэжээ. Ховд аймгийн Булган сум бусад хөдөөгийн сумтай харьцуулахад хүн ам ихээр төвлөрсөн том сумдын нэг юм.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Сумын ИТХ-ын төлөөлөгч нар суманд хийгдэж байгаа ажил арга хэмжээнээс хөдөөгийн ард иргэдэд хүргэх, мэдээлэх зэрэг хийж байгаа ажил нэг ч байхгүй. Ээлжит Хурлыг тэргүүлэгчдээс сонгоод хийдэг, гэвч тэр нь үр дүн муутай. Нэг нэгнийгээ шүүмжлэх талцах төдий болдог.

***Ховд аймаг, Булган сумын иргэн, эрэгтэй***

Эсрэгээрээ, манай сумын ИТХ үйл ажиллагаагаа иргэддээ тайлагнадаг гэж судалгаанд оролцсон иргэд хамгийн өндөр хувьтай хариулсан нь Дархан-Уул аймгийн Шарын гол сум (87%), Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум (84%), Ховд аймгийн Манхан сум (81%) байв. Эдгээр сумд нь хүн амын төвлөрөл харьцангуй бага сумд юм.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

Бид үйл ажиллагаагаа Багийн ИНХ дээр тайлагнадаг. Мөн багийн нээлттэй хаалганы өдөрлөг, Иргэдээ сонсъё уулзалт, улирал тутмын сонин хэвлэл, жилдээ нэг удаа жилийн ажлын тайлан, хөдөө орон нутгийн телевизээр тайлагнадаг.

***Дархан-Уул аймаг, Шарын гол сумын Засаг дарга***

Ард иргэдтэйгээ уулзаж байх нь гарах эрсдэлийг бууруулж чадна. Манай сумын ЗДТГ, Хурлын зүгээс нээлттэй хаалганы өдөр төсөв төлөвлөгөөгөө баталдаг. Жишээлбэл: танай баг энэ жил тэдэн баг дээр тэдэн удаа нээлттэй хаалганы өдөр зохион байгуулна гэх жишээ. Бид жил болгон манай сумын иргэд хэр хол байна хамаагүй, уулын мухарт оршин сууж байх нь хамаагүй очиж уулзаж яриа хийдэг. Манай сум төсвийн 7 байгууллагатай. Эдгээр байгууллагаас тус бүр төлөөлөгч гарч иргэдтэй очиж уулздаг. Бид ирээд иргэдээс ийм санал гарсан гэдгээ баталдаг.

***Ховд аймаг, Манхан сумын ИТХ-ын төлөөлөгч***

***Зураг 17. Хөвсгөл аймаг Эрдэнэбулган сумын ИТХ болон ЗДТГ иргэдтэй уулзалт зохион байгуулж, иргэдтэй биечлэн уулзаж санал бодлыг нь сонсож байгаа нь***




**Иргэдтэйгээ биечлэн уулзалт хийж, санаа бодлыг нь их сонсдог сум, орон нутгийн хувьд нутгийн удирдлагын байгууллагын талаарх иргэдийн мэдлэг, ойлголт харьцангуй өндөр байна. Ажлын шугамаар болон энгийн үед ч иргэдийн санал бодлыг сонсож, тэмдэглэж авч үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг давхар түгээх нь иргэдийн хувьд мэдээлэл авах чухал эх үүсвэр болж байгаа нь ажиглагдаж байна.** Сум бүрт Иргэний танхим байгуулж үр дүнтэй ажиллаж чадвал нутгийн удирдлагын байгууллагын талаарх иргэдийн ойлголт, идэвх оролцоо нэмэгдэх давуу талтай юм. Гэвч одоогоор ИТХ-ын талаарх мэдээллийг Иргэний танхимаар дамжуулан авч буй иргэдийн эзлэх хувь 0.4% буюу маш бага байна.

### *Иргэд сум/дүүргийн ИТХ-ын шийдвэрийг мэддэг байдал*

ИТХ-ын гаргасан шийдвэрийг мэдээлдэг эсэх талаар иргэдийн хариулт харилцан адилгүй байна. Налайх дүүргийн хувьд өмнөх сэдэвтэй адил шийдвэрээ ямар нэг хэмжээгээр мэдээлдэг гэж 71% нь үзсэн байна. Дараа нь Сонгинохайрхан дүүргийн иргэдийн 41% нь дүүргийн ИТХ нь ямар нэг байдлаар шийдвэрээ иргэдэд мэдээлдэг гэж үзжээ. *(Дараах хүснэгтээс харна уу)*

Шийдвэрээ огт мэдээлдэггүй гэж Хан-Уул дүүргийн иргэдийн 59% нь үзжээ. “Мэдэхгүй/санахгүй байна” гэсэн хариултыг Баянгол дүүргийн иргэдийн 51% буюу бусад дүүрэгтэй харьцуулахад хамгийн өндөр хувьтай хариулжээ.

*Хүснэгт 33. Дүүргийн ИТХ нь иргэддээ гаргасан шийдвэрүүдээ мэдээлдэг байдал, хувиар*

| | Бүгдийг нь мэдээлдэг | Дийлэн хийг мэдээлдэг | Тал хувийг мэдээлдэг | Цөөн хувийг мэдээлдэг | Огт мэдээлдэггүй | Мэдэхгүй санахгүй байна |
|---|---|---|---|---|---|---|
| **Улаанбаатар** | **4.6** | **8.4** | **13.0** | **10.0** | **26.0** | **38.0** |
| БГД | 3.9 | 11.8 | 5.9 | 9.8 | 17.6 | 51.0 |
| БЗД | 2.5 | 4.9 | 13.6 | 16.0 | 30.9 | 32.1 |
| ЧД | 3.9 | 10.5 | 10.5 | 5.3 | 27.6 | 42.1 |
| СХД | 4.4 | 10.6 | 12.4 | 13.3 | 19.5 | 39.8 |
| СБД | 5.9 | 5.9 | 14.9 | 4.0 | 26.7 | 42.6 |
| ХУД | 0.0 | 0.0 | 0.0 | 3.1 | 59.4 | 37.5 |
| НД | 10.9 | 13.0 | 30.4 | 17.4 | 15.2 | 13.0 |

Хөдөө орон нутгийн хувьд уг хариултыг сум тус бүрээр харахад Ховд аймгийн Булган сумын иргэдийн 36% нь сумын ИТХ нь гаргасан шийдвэрээ иргэддээ “огт мэдээлдэггүй” гэж үзжээ. Энэ нь бусад сумаас наад зах нь 10%-иар илүү байгаа юм.

“Мэдэхгүй, санахгүй байна” гэж хариулсан хүмүүсийн эзлэх жин Хэнтий аймгийн Хэрлэн сум, Ховд аймгийн Жаргалант сум, Хөвсгөл аймгийн Мөрөн сум хамгийн өндөр байв. Мөн аймгийн төвийн сумдын иргэдийн “Мэдэхгүй, санахгүй байна” гэж хариулсан хувь хөдөөгийн сумдаас илүү өндөр байна. Хөдөөгийн сумдын иргэдийн ИТХ-ын талаарх мэдээлэл аймгийн төв, нийслэл хотын дүүргүүдээс бага байв.

**Хүн амын тоо ихсэх тусам ИТХ-ын иргэддээ хүрч ажиллах, мэдээлэл өгөх байдал буурч байна.**

### *Хүснэгт 34. Сумын ИТХ иргэддээ гаргасан шийдвэрээ мэдээлдэг байдал, сумаар, хувиар*

| | Бүгдийг тайлагнадаг | Дийлэнхийг тайлагнадаг | Тал хувийг тайлагнадаг | Цөөн хувийг тайлагнадаг | Огт тайлагнадаггүй | Мэдэхгүй санахгүй байна |
|---|---|---|---|---|---|---|
| **Хөдөө орон нутаг** | **9.3** | **18.3** | **14.3** | **12.7** | **13.7** | **31.7** |
| **Дархан-Уул** | 6.3 | 26.6 | 13.3 | 18.2 | 11.9 | 23.8 |
| Дархан сум | 2.9 | 28.6 | 8.6 | 17.1 | 10.0 | 32.9 |
| Шарын гол сум | 18.4 | 42.1 | 10.5 | 10.5 | 2.6 | 15.8 |
| Хонгор сум | 0.0 | 5.7 | 25.7 | 28.6 | 25.7 | 14.3 |
| **Өвөрхангай** | 9.1 | 14.5 | 18.3 | 8.5 | 17.7 | 31.7 |
| Арвайхээр | 10.6 | 8.5 | 17.0 | 6.4 | 21.3 | 36.2 |
| Хархорин | 11.8 | 9.8 | 7.8 | 11.8 | 23.5 | 35.3 |
| Гучин-Ус | 6.1 | 22.7 | 27.3 | 7.6 | 10.6 | 25.8 |
| **Хөвсгөл** | 10.3 | 24.1 | 12.1 | 17.2 | 6.9 | 29.3 |
| Мөрөн | 2.3 | 14.0 | 4.7 | 23.3 | 14.0 | 41.9 |
| Эрдэнэбулган | 20.9 | 27.9 | 18.6 | 16.3 | 2.3 | 14.0 |
| Тариалан | 6.7 | 33.3 | 13.3 | 10.0 | 3.3 | 33.3 |
| **Хэнтий** | 9.4 | 17.5 | 11.7 | 9.4 | 11.7 | 40.4 |
| Хэрлэн | 0.0 | 10.0 | 16.0 | 10.0 | 10.0 | 54.0 |
| Батноров | 9.3 | 28.0 | 12.0 | 9.3 | 9.3 | 32.0 |
| Өмнөдэлгэр | 19.6 | 8.7 | 6.5 | 8.7 | 17.4 | 39.1 |
| **Ховд** | 12.3 | 7.5 | 16.0 | 12.3 | 20.8 | 31.1 |
| Жаргалант | 0.0 | 3.2 | 6.5 | 12.9 | 25.8 | 51.6 |
| Булган | 0.0 | 2.6 | 15.4 | 12.8 | 35.9 | 33.3 |
| Манхан | 36.1 | 16.7 | 25.0 | 11.1 | 0.0 | 11.1 |

Харин Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн 82%, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын иргэдийн 84%, Ховд аймгийн Манхан сумын иргэдийн 89% нь тухайн сумынхаа ИТХ-ыг шийдвэрээ ямар нэг байдлаар иргэддээ мэдээлдэг гэж үзжээ.

### *Иргэд сум/дүүргийн ИТХ-ын шийдвэрээс нэрлэсэн байдал*

Улаанбаатар хотын иргэдийн 81% нь дүүргийн ИТХ-аас гаргасан шийдвэрээс нэрлэж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын дүүргийн ИТХ нийт иргэдийнхээ 19%-д нь л гаргасан шийдвэрээ хүргэж чадаж байна. Нийслэлийн иргэдийн 1% нь хийсэн ажил огт байхгүй гэж хариулжээ.

Дүүргийн ИТХ-аас гарсан шийдвэр гэж иргэдийн нэрлэсэн шийдвэрүүдийг хамгийн их давтагдсан хариултын дараалаар дор жагсаав.

**Улаанбаатар хотын иргэд.**

- Сургууль, цэцэрлэг байгуулсан, байгуулах шийдвэр гаргасан;
- Хүүхдийн тоглоомын талбай байгуулсан;
- Ногоон байгууламж хийсэн (зүлэгжүүлэлт, цэцгийн мандал г.м);
- Гэрэлтүүлэг тавьсан;
- Авто зам болон явган хүний зам зассан;
- Бүх нийтийн хогны цэвэрлэгээ, хогны цэгийн тохижуулалт, хогтой холбоотой асуудал;
- Цэцэрлэгт хүрээлэн тохижуулсан;
- Газар өмчлөл;
- Мод тарих арга хэмжээ зохион байгуулсан;
- Автобусны буудлуудыг шинэчилсэн;
- Ахмадын хөгжлийн төв байгуулах шийдвэр гаргасан;
- Гүүр барьсан;
- Худаг шинээр байгуулсан, зассан;
- Байрнуудыг засвар, тохижилтын ажлыг хийсэн;
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сургалт явуулсан.

*Зураг 18. Иргэдийн нэрлэсэн шийдвэрүүд, жишээ зураг*




**Дархан-Уул аймаг.** Дархан-Уул аймгийн иргэдийн 54% нь сумын ИТХ-аас гарсан шийдвэрүүдээс "Огт хэлж мэдэхгүй" байсан бол нэрлэсэн иргэд дараах шийдвэрийг харьяа сумынхаа ИТХ гаргасан хэмээн нэрлэжээ.

- Авто зам болон явган хүний зам зассан;
- Суманд бүтээн байгуулалт, тохижилтын ажлууд хийгдэж байна;
- Гэрэлтүүлэг;
- Хог хаягдлын асуудлыг шийдсэн;
- Газар олголт;
- Цэцэрлэг байгуулсан;
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих ажлууд хийгдсэн;

- Түлээ нүүрсээр хангаж, үнийг хямдруулсан;
- Хувуурилагдсан төсвийн зарцуулалтыг батлах;
- Цэвэр усны инженерийн шугам.

**Өвөрхангай аймаг.** Өвөрхангай аймгийн иргэдийн хувьд сумын ИТХ-аас гарсан шийдвэрээс нийт иргэдийн 68% нь "Огт хэлж мэдэхгүй" байв. Харин шийдвэрээс нэрлэж чадаж байсан иргэд дараах шийдвэрийг сумын ИТХ гаргасан хэмээн нэрлэжээ.

- Авто зам, явган хүний зам засвар;
- Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх талаар ажил хийсэн, ядуу буурай амьдралтай хүмүүст хандив тусламж өгсөн;
- Гүний худаг байгуулсан;
- Ногоон байгууламж байгуулж, мод тарьсан;
- Сумын 90 жилийн ойн бүтээн байгуулалт;
- Иргэдийг малжуулах төсөл;
- Гэрэлтүүлэг;
- Газар өмчлөл;
- Шинээр ажлын байр бий болгох ажлууд хийгдсэн;
- Зарим хэсгийг камержуулсан;
- Эрүүл мэндийг дэмжих жил зарласан;

**Хөвсгөл аймаг.** Хөвсгөл аймгийн иргэдийн хувьд сумын ИТХ-аас гарсан шийдвэрүүдээс нийт иргэдийн 72% нь "Огт хэлж мэдэхгүй" байна. Харин шийдвэрээс нэрлэж чадаж байсан иргэд дараах шийдвэрийг сумын ИТХ гаргасан хэмээн нэрлэжээ.

- Авто зам, явган хүний зам засвар;
- Өрхийн амьжиргааг дээшлүүлэх, иргэдийг малжуулах төсөл;
- Гэр цэцэрлэг болон цэцэрлэг байгуулсан;
- "Архигүй сум", "Архигүй цагаан сар" аян;
- Баригддаггүй барилга баригдсан;
- Гэрэлтүүлэг;
- Соёлын төв барьсан;
- Төсөв баталсан;
- Сургууль барьсан;
- Худаг барьсан, рашаан усаа хамгаалсан.

**Хэнтий аймаг.** Хэнтий аймгийн иргэдийн хувьд сумын ИТХ-аас гарсан шийдвэрээс нийт иргэдийн 67% нь "Огт хэлж мэдэхгүй" байна. Харин шийдвэрүүдээс нэрлэж чадаж байсан иргэд дараах шийдвэрийг сумын ИТХ гаргасан хэмээн нэрлэжээ.

- Газар зохион байгуулалтын төлөвлөгөө баталсан
- "Архигүй сум" аян;
- Жонш баяжуулах үйлдвэрийн талаар иргэдээс санал авсан;
- "Хоггүй сум" аян;

- Сум хөгжүүлэх төлөвлөгөө баталсан;
- Авто зам, явган хүний зам засвар;
- Өвөлжөө хаваржааг гэрчилгээжүүлсэн;
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээл олгосон;
- Гэрэлтүүлэг;

**Ховд аймаг.** Ховд аймгийн иргэдийн хувьд сумын ИТХ-аас гарсан шийдвэрүүдээс нийт иргэдийн 76% нь "Огт хэлж мэдэхгүй" байна. Харин шийдвэрээс нэрлэж чадаж байсан иргэд дараах шийдвэрийг сумын ИТХ гаргасан хэмээн нэрлэжээ.

- Авто зам, явган хүний зам засвар;
- Сумын хөгжлийн төсөв баталсан;
- Гэрэлтүүлэг;
- Ногоон байгууламжтой холбоотой шийдвэрүүд гаргасан;
- Малжуулах төсөл хэрэгжүүлсэн;
- Хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж эхэлсэн;
- Худаг байгуулах шийдвэр гаргасан;
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төсөл хэрэгжүүлсэн;
- Гудамжны нохойны асуудлыг цэгцэлсэн;

*Зураг 19. Иргэдийн нэрлэсэн шийдвэрүүд, жишээ зураг*



### *Сум/дүүргийн ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн үнэлгээ*

***Улаанбаатар хотын иргэдийн үнэлгээ.*** Улаанбаатар хотын иргэдээс дүүргийнхээ ИТХ-д өгсөн үнэлгээг харвал *"Маш сайн"* болон *"Зарим талаараа сайн"* гэсэн үнэлгээг НД-ийн иргэдийн 21.7% , БГД-ийн иргэдийн 21.6%, СХД-ийн иргэдийн 21.2% нь өгсөн нь бусад дүүрэгтэй харьцуулахад өндөр байна. Харин муу үнэлгээг БЗД-ийн иргэдийн 27.1%, СБД-ийн иргэдийн 24.7% нь өгсөн нь бусад дүүрэгтэй харьцуулахад хамгийн муу үзүүлэлт юм.

*Хүснэгт 35. Дүүргийн ИТХ-ын үйл ажиллагаанд өгч буй иргэдийн үнэлгээ, дүүргээр, хувиар*

| | Маш сайн | Зарим талаар сайн | Дунд | Зарим талаар муу | Маш муу | Мэдэхгүй санахгүй байна | Хариулахаас татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Улаанбаатар** | **6.6** | **12.2** | **29.8** | **7.2** | **13.8** | **28.6** | **1.9** |
| | | | | | | | |
| БГД | 9.8 | 11.8 | 27.5 | 5.9 | 3.9 | 39.2 | 2.0 |
| БЗД | 3.7 | 11.1 | 30.9 | 14.8 | 12.3 | 27.2 | 0.0 |
| ЧД | 2.6 | 17.1 | 31.6 | 3.9 | 17.1 | 22.4 | 5.3 |
| СХД | 11.5 | 9.7 | 29.2 | 5.3 | 15.0 | 28.3 | 0.9 |
| СБД | 5.9 | 10.9 | 25.7 | 5.9 | 18.8 | 30.7 | 2.0 |
| ХУД | 6.3 | 9.4 | 15.6 | 6.3 | 9.4 | 50.0 | 3.1 |
| НД | 4.3 | 17.4 | 47.8 | 8.7 | 10.9 | 10.9 | 0.0 |

Үнэлгээний түвшинг дүүргээр харахад иргэд үйл ажиллагаагаа тайлагнадаг, шийдвэртэй холбоотой мэдээллээ ямар нэгэн байдлаар иргэддээ өгч чаддаг тохиолдолд “Маш сайн” болон “Зарим талаараа” сайн” гэсэн үнэлгээг авсан хувь өндөр байна.

Дүүргийн ИТХ-ын үйл ажиллагааг үнэлсэн шалтгааныг иргэдээс тодруулахад дараах зүйлсийг дурдсан байна.

*Хүснэгт 36. Дүүргийн ИТХ-ын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ, шалтгаан, дүүргээр*

| | ***“Маш сайн”* болон *“Зарим талаараа сайн”* гэсэн үнэлгээ өгсөн шалтгаан** | ***“Маш муу”* болон *“Зарим талаараа муу”* гэсэн үнэлгээ өгсөн шалтгаан** |
|---|---|---|
| **Баянгол дүүрэг** | *Сайн үнэлгээ өгсөн* – 21.6%<br>▪ Хот тохижилт, бүтээн байгуулалт сайн хийгдэж байгаа<br>▪ Иргэддээ мэдээлэл сайн өгдөг<br>▪ Амьдралд хэрэгцээтэй зүйл хийж байгаа | *Муу үнэлгээ өгсөн* – 9.8%<br>▪ Мэдээлэл огт байхгүй<br>▪ Ард түмэнтэйгээ ойр байдаггүй, иргэдтэйгээ уулздаггүй |
| **Баянзүрх дүүрэг** | *Сайн үнэлгээ өгсөн* – 14.8%<br>▪ Хийсэн ажил нь бодитой байдаг<br>▪ Иргэд рүүгээ хандаж ажилладаг | *Муу үнэлгээ өгсөн* – 27.1%<br>▪ Иргэдтэйгээ тулж ажилладаггүй, уулздаггүй<br>▪ Мэдээлэл огт байхгүй |
| **Чингэлтэй дүүрэг** | *Сайн үнэлгээ өгсөн* – 19.7%<br>▪ Мэдээлэл сайн өгдөг<br>▪ Тохижилт үйлчилгээ сайн байгаа<br>▪ Ажил хийдэг | *Муу үнэлгээ өгсөн* – 21%<br>▪ Мэдээлэл огт байхгүй<br>▪ Бодитой хийж байгаа ажил байхгүй |

| | | |
|---|---|---|
| **Сонгинохайрхан дүүрэг** | *Сайн үнэлгээ өгсөн* – 21.2%<br>▪ Хийж байгаа ажил нь мэдрэгдэж байгаа<br>▪ Иргэдтэй тулж харилцдаг | *Муу үнэлгээ өгсөн* – 20.3%<br>▪ Мэдээлэл огт байхгүй<br>▪ Тохижилтийн ажил муу хийгдэж байна |
| **Сүхбаатар дүүрэг** | *Сайн үнэлгээ өгсөн* – 16.8%<br>▪ Бүтээн байгуулалт дүүрэгт сайн хийгдаж байна<br>▪ Тоглоомын талбай хийсэн<br>▪ Үйл ажиллагаа нь ил нээлттэй байдаг | *Муу үнэлгээ өгсөн* – 24.7%<br>▪ Мэдээлэл огт байхгүй<br>▪ Бодитой хийж байгаа ажил байхгүй |
| **Хан-Уул дүүрэг** | *Сайн үнэлгээ өгсөн* – 15.7%<br>▪ Замын хашлага хийсэн<br>▪ Явган хүний зам зассан<br>▪ Цэцэрлэгт хүрээлэн хийсэн | *Муу үнэлгээ өгсөн* – 15.7%<br>▪ Мэдээлэл огт байхгүй<br>▪ Хүнд сурталтай<br>▪ Ард түмэнтэйгээ ойр ажилладаггүй |
| **Налайх дүүрэг** | *Сайн үнэлгээ өгсөн* – 21.7%<br>▪ Иргэддээ мэдээллээ шуурхай өгдөг<br>▪ Иргэдээ сонсож, санал хүсэлтийг нь тусгаж авдаг<br>▪ Одоогийн төлөөлөгчид урдны төлөөлөгчдөөсөө хамаагүй сайн ажиллаж байна | *Муу үнэлгээ өгсөн* – 19.6%<br>▪ Мэдээлэл өгдөггүй<br>▪ Суудлаа булаацалддаг, их солигддог<br>▪ Иргэдийн хүсэлд нийцсэн шийдвэр гаргаж чаддаггүй |

Улаанбаатар хотын иргэд дүүргийн ИТХ-даа сайн үнэлгээ өгсөн шалтгааны ихэнх нь иргэддээ мэдээлэл сайн өгдөг, нүдэнд харагдахуйц бодит ажил хийдэг, хийсэн ажил нь иргэдэд мэдрэгдэж байдаг гэсэн байна. Харин муу үнэлгээ өгсөн шалтгаан нь эсрэгээрээ иргэддээ мэдээлэл огт өгч чаддаггүй, ажил хийж байгаа нь мэдрэгддэггүй гэжээ.

**Хөдөө орон нутгийн иргэдийн үнэлгээ.** Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын иргэдийн 53.5%, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн 52.6% нь сумынхаа ИТХ-д “Маш сайн” болон “Зарим талаараа сайн” гэсэн үнэлгээг өгчээ. Мөн Ховд аймгийн Манхан сум, Дархан-Уул аймгийн Дархан сумын иргэдийн 47% нь сайн үнэлгээ өгчээ.

Хөдөө орон нутгийн нийт дундажийг харахад орон нутгийн иргэд сумын ИТХ-даа сайн үнэлгээ өгсөн хувь Улаанбаатар хотын иргэдийнхээс бараг 2 дахин өндөр байна. Тухайлбал, Улаанбаатар хотын иргэдийн 18.8% нь дүүргийнхээ ИТХ-д сайн үнэлгээ өгсөн бол орон нутгийн иргэдийн 34.2% нь сумынхаа ИТХ-д сайн үнэлгээ өгчээ.

*Хүснэгт 37. Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд өгч буй иргэдийн үнэлгээ, сумаар, хувиар*

| | Маш сайн | Зарим талаар сайн | Дунд | Зарим талаар муу | Маш муу | Мэдэхгүй санахгүй байна | Хариулахаас татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Хөдөө орон нутаг** | **6.6** | **27.6** | **32.0** | **3.9** | **8.7** | **20.1** | **1.1** |
| **Дархан-Уул** | 1.4 | 39.2 | 35.0 | 7.7 | 4.9 | 11.9 | 0.0 |
| Дархан сум | 1.4 | 44.3 | 30.0 | 7.1 | 1.4 | 15.7 | 0.0 |
| Шарын гол сум | 2.6 | 50.0 | 39.5 | 0.0 | 0.0 | 7.9 | 0.0 |
| Хонгор сум | 0.0 | 17.1 | 40.0 | 17.1 | 17.1 | 8.6 | 0.0 |
| **Өвөрхангай** | 6.7 | 25.0 | 28.7 | 3.0 | 7.3 | 28.7 | 0.6 |
| Арвайхээр | 8.5 | 17.0 | 27.7 | 6.4 | 8.5 | 31.9 | 0.0 |
| Хархорин | 9.8 | 23.5 | 19.6 | 2.0 | 15.7 | 27.5 | 2.0 |
| Гучин-Ус | 3.0 | 31.8 | 36.4 | 1.5 | 0.0 | 27.3 | 0.0 |
| **Хөвсгөл** | 9.5 | 29.3 | 34.5 | 3.4 | 6.0 | 13.8 | 3.4 |
| Мөрөн | 4.7 | 18.6 | 34.9 | 2.3 | 4.7 | 27.9 | 7.0 |
| Эрдэнэбулган | 9.3 | 44.2 | 32.6 | 4.7 | 7.0 | 2.3 | 0.0 |
| Тариалан | 16.7 | 23.3 | 36.7 | 3.3 | 6.7 | 10.0 | 3.3 |
| **Хэнтий** | 8.2 | 26.9 | 28.1 | 1.8 | 9.4 | 24.6 | 1.2 |
| Хэрлэн | 8.0 | 20.0 | 28.0 | 2.0 | 12.0 | 28.0 | 2.0 |
| Батноров | 5.3 | 40.0 | 29.3 | 2.7 | 2.7 | 18.7 | 1.3 |
| Өмнөдэлгэр | 13.0 | 13.0 | 26.1 | 0.0 | 17.4 | 30.4 | 0.0 |
| **Ховд** | 7.5 | 15.1 | 36.8 | 3.8 | 17.9 | 17.9 | 0.9 |
| Жаргалант | 3.2 | 3.2 | 54.8 | 0.0 | 12.9 | 25.8 | 0.0 |
| Булган | 0.0 | 12.8 | 17.9 | 10.3 | 35.9 | 23.1 | 0.0 |
| Манхан | 19.4 | 27.8 | 41.7 | 0.0 | 2.8 | 5.6 | 2.8 |

**ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн үнэлгээний шалтгаанаас харахад мэдээлэл авч чаддаггүй иргэд муу үнэлгээ өгчээ. Иймд нутгийн удирдлагын байгууллагуудын хувьд иргэдэд мэдээлэл түгээх арга замыг сайжруулах, тэдэнтэй биечлэн уулзах, идэвх оролцоог нь дэмжих нь чухал юм.**

## 3.4. ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ` ХАНДЛАГА, ҮНЭЛГЭЭ

Энэ бүлэгт иргэд тухайн тойргоос шат шатны ИТХ-д сонгогдон ажиллаж буй ИТХ-ын төлөөлөгчдөө хэр зэрэг мэддэг, сум/дүүргийнхээ ИТХ-ын төлөөлөгчтэй хэрхэн ямар асуудлаар ихэвчлэн холбогддог, холбогдоход хэр зэрэг хүндрэлтэй байдаг, мөн хандсан асуудал нь хэр зэрэг үр дүнтэй шийдэгдсэн эсэхийг тодруулахаас гадна иргэдийг хамгийн сайн төлөөлж чадах төлөөлөгч хүн ямар шалгуурыг хангасан байх ёстойг тодруулсан болно.

### 3.4.1. Аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийг мэддэг байдал

**Нийт судалгаанд оролцогчдын 1/3 нь өөрийн тойргоос аймаг/нийслэлийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчдийг ямар нэгэн байдлаар нэрлэсэн бол үүнээс 15.8% нь төлөөлөгчөө зөв нэрлэж байна. Төлөөөлөгчөө зөв нэрлэж буй хувь хөдөө орон нутагт нийслэлээс даруй 5 дахин өндөр байна.**

Үндсэндээ нэрлэсэн хүн нь өөрийнх нь тойргийг төлөөлөөгүй ч НИТХ-ын төлөөлөгч мөн буюу нийтдээ НИТХ-ын төлөөлөгчдийг мэдэж байгаа нь 9.8%, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг мэдэж байгаа нь 37.3% байна. **Харин 10 хүн тутмын 7 нь өөрийн тойргоос аймаг/нийслэлийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчөө огт мэдэхгүй байгаа бөгөөд энэ хувь нийслэл хотод хөдөө орон нутгаас 30%-иар өндөр байна.**

*Хүснэгт 38. Аймаг/нийслэлийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийг нэрлэсэн байдал, байршлаар, хувиар*

| Байршил | Зөв нэрлэсэн | Нэрлэсэн хүн нь өөрийнх нь тойргийг төлөөлөөгүй ч тухайн орон нутгийн төлөөлөгч мөн | Буруу нэрлэсэн | Төлөөлөгч мэдэхгүй | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **Нийт** | **15.8** | **10.0** | **6.7** | **67.5** | **100** |
| **Улаанбаатар** | 4.8 | 5.0 | 5.4 | 84.8 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | 23.7 | 13.6 | 7.6 | 55.1 | 100 |
| **Дүүргээр** | | | | | |
| **БГД** | 0 | 3.9 | 15.7 | 80.4 | 100 |
| **БЗД** | 3.7 | 4.9 | 2.5 | 88.9 | 100 |
| **ЧД** | 7.9 | 1.3 | 1.3 | 89.5 | 100 |
| **СХД** | 1.8 | 1.8 | 7.1 | 89.4 | 100 |
| **СБД** | 2.0 | 9.9 | 5.0 | 83.2 | 100 |
| **ХУД** | 0 | 15.6 | 3.1 | 81.3 | 100 |
| **НД** | 23.9 | 2.2 | 4.3 | 69.6 | 100 |
| **Аймгаар** | | | | | |
| **Дархан-Уул** | 33.6 | 4.9 | 6.3 | 55.2 | 100 |
| **Өвөрхангай** | 15.9 | 13.4 | 6.7 | 64.0 | 100 |
| **Хөвсгөл** | 25.9 | 12.9 | 11.2 | 50.0 | 100 |
| **Хэнтий** | 24.6 | 14.0 | 8.8 | 52.6 | 100 |
| **Ховд** | 18.9 | 25.5 | 4.7 | 50.9 | 100 |

Улаанбаатар хотын хувьд авч үзвэл Налайх дүүргээс НИТХ-д сонгогдсон төлөөлөгчөө мэдэж буй хувь бусад дүүргээс харьцангуй өндөр байна. Чанарын судаллгааны үр дүнгээс харахад Налайх дүүргийн иргэд өөрийн тойргоос нийслэлд сонгогдсон төлөөлөгч С.Амарсайханыг 2015 оны 1 дүгээр сард Налайх дүүрэгт зохион байгуулсан "Налайх дүүргийг хот болгох санал асуулга" уулзалтаас хойш илүү таньж мэддэг болжээ.

Улаанбаатар хотын иргэдийн хувьд НИТХ-д сонгогдон ажиллаж буй төлөөлөгчийг нэрлэхдээ НИТХ-ын Дарга Д.Баттулга, Төлөөлөгч бөгөөд Нийслэлийн захирагч Э.Бат-Үүл, Тэргүүлэгч Т.Гантөмөр нарыг өөрийн тойргоос (дүүрэг, хорооноос) сонгогдсон хэмээн андуурч нэрлэх тохиолдол цөөнгүй байв. Эдгээр төлөөлөгч нь НИТХ-ын төлөөлөгч мөн хэдий ч намын жагсаалтаар сонгогдсон, тодорхой дүүрэг, хорооноос сонгогдоогүй төлөөлөгчид юм.

Улаанбаатар хотын иргэдийн хувьд хорооны Засаг дарга, ороннутгийн хувьд багийн Засаг дарга нар иргэдэд илүү ойр байдаг бөгөөд аливаа асуудал тулгарахад тэдэнд хамгийн түрүүнд ханддаг учир шат шатны ИТХ-ын төлөөлөгчөө тэр бүр мэддэггүй байна. Хэдийгээр орон нутгийн сонгуулийн үеэр хэн нэгэн нэр дэвшигчийг дугуйлж байсан ч сонгуулийн дараа сонгосон төлөөлөгчөө мартсан гэдэг нь фокус бүлгийн ярилцлагаас харагдаж байлаа.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс*:

Сонгууль өгч байхдаа нэрийг нь дугуйлсан. Тэрнээс хойш хараагүй. Тэгээд хэн гэдэг хүнийг дугуйлснаа мартсан. Ямар ч байсан Ардчилсан намын хүнийг дугуйлснаа санаж байна.

***Дархан-Уул аймаг, Дархан сумын иргэн***

Бид нийгмийн идэвх муутайдаа биш, хувийн хэвшилд ажилладаг хүмүүс цаг наргүй ажилладаг учраас төлөөлөгчдийн талаар мэдээлэл авч чадахгүй байна. Нөгөө талаас, төлөөлөгчдийн зүгээс иргэдэд мэдээлэл өгөх ажил нь тааруу байна. Хүн ам ихтэй, нягтрал ихтэй болохоор мэдээлэл хүргэх нь муу байдаг юм болов уу гэж боддог.

***Улаанбаатар хот, БЗД-ийн иргэн***

Судалгаанд оролцсон нийслэлийн иргэдийн дийлэнх буюу 65.6% нь өөрийн тойргоос НИТХ-д сонгогдсон төлөөлөгчдөө огт хараагүй, 15 орчим хувь нь хаана харснаа санахгүй байгаа бол үлдсэн 20 орчим хувь нь 2012 оны орон нутгийн сонгуулийн кампанит ажлаас хойш ямар нэгэн байдлаар харжээ. Ингэхдээ ихэвчлэн орон даяар цацагддаг телевизийн сувгуудаар харсан ажээ. Нийслэлийн иргэдийн 15 орчим хувь нь тойргийнхоо НИТХ-ын төлөөлөгчийг харж байсан хэдий ч нэрийг нь мэдэхгүй гэжээ.

Харин хөдөө орон нутгийн иргэдийн 1/3 нь аймгийнхаа ИТХ-ын төлөөлөгчийг сарын өмнө харсан бөгөөд үүнээс дийлэнх хувь нь хурал уулзалтад оролцох үеэрээ харсан байна.

## *Хүснэгт 39. Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөвлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, хугацаа, хувиар*

| Хэзээ хамгийн сүүлд харсан | Нийт | Улаан-баатар | Хөдөө орон нутаг | | Дархан-Уул | Өвөрхангай | Хөвсгөл | Хэнтий | Ховд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Сарын өмнө** | **19.8** | 4.8 | 30.6 | Аймгаар | 30.1 | 22.0 | 35.3 | 35.7 | 31.1 |
| **2-5 сарын өмнө** | **7.1** | 4.4 | 9.0 | | 11.9 | 1.8 | 10.3 | 10.5 | 12.3 |
| **6 сарын өмнө** | **1.5** | 1.0 | 1.9 | | 3.5 | 0.6 | 2.6 | 1.2 | 1.9 |
| **1 жилийн өмнө** | **1.9** | 2.0 | 1.9 | | 2.8 | 1.2 | 2.6 | 1.8 | 0.9 |
| **2 жилийн өмнө** | **0.8** | 0.8 | 0.9 | | 2.1 | 0.6 | 0.9 | 0 | 0.9 |
| **Сонгуулийн кампанит ажлын үеэр /2012 онд/** | **5.3** | 6.6 | 4.4 | | 3.5 | 6.7 | 0.9 | 5.8 | 3.8 |
| **Огт хараагүй** | **52.7** | 65.6 | 43.4 | | 25.9 | 59.8 | 43.1 | 40.4 | 47.2 |
| **Мэдэхгүй/ санахгүй байна** | **10.8** | 14.8 | 8.0 | | 20.3 | 7.3 | 4.3 | 4.7 | 1.9 |
| **Нийт** | **100** | 100 | 100 | | 100 | 100 | 100 | 100 | 100 |

### *Хүснэгт 40. Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, байршлаар, хувиар*

| Хаана хамгийн сүүлд харсан | Нийт | Улаанбаатар | Хөдөө орон нутаг | | Дархан-Уул | Өвөрхангай | Хөвсгөл | Хэнтий | Ховд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Биечлэн/ ганцаарчлан уулзахдаа** | **4.6** | 0.6 | 6.3 | | 2.8 | 10.6 | 6.1 | 7.8 | 5.4 |
| **Хурал уулзалтанд оролцох үеэр** | **23.1** | 16.3 | 26.0 | | 28.3 | 18.2 | 33.3 | 26.5 | 21.4 |
| **ИТХ-ын ажлын албан дээр** | **5.3** | 1.2 | 7.1 | | 7.5 | 3.0 | 10.6 | 1.0 | 17.9 |
| **Цахим хуудсаар /веб хуудас/** | **0.2** | 0 | 0.3 | | 0 | 0 | 0 | 0 | 1.8 |
| **Иргэний танхимд** | **0.7** | 0 | 1.0 | | 0 | 1.5 | 0 | 2.0 | 1.8 |
| **Телевиз / орон даяар цацагддаг/** | **6.3** | 18.6 | 1.0 | **Аймгаар** | 0.9 | 3.0 | 0 | 1.0 | 0 |
| **Телевиз /орон нутгийн/** | **5.1** | 4.7 | 5.3 | | 6.6 | 1.5 | 7.6 | 4.9 | 5.4 |
| **Сонин/ сэтгүүлээс** | **0.7** | 0.6 | 0.8 | | 1.9 | 0 | 0 | 0 | 1.8 |
| **Хэвлэмэл материал дээрээс** | **0.2** | 0.6 | 0 | | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нээлттэй өдөрлөгийн** | **0.5** | 0.6 | 0.5 | | 0.0 | 0 | 0 | 1.0 | 1.8 |
| **Бусад** | **29.9** | 14.0 | 36.9 | | 27.4 | 45.5 | 36.4 | 44.1 | 32.1 |
| **Мэдэхгүй/ санахгүй байна** | **23.4** | 43.0 | 14.9 | | 24.5 | 16.7 | 6.1 | 11.8 | 10.7 |
| **Нийт** | **100** | 100 | 100 | | 100 | 100 | 100 | 100 | 100 |

## 3.4.2. Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийг мэддэг байдал

Сум/дүүргийнхээ ИТХ-ын төлөөлөгчийг зөв нэрлэж буй хувь нь аймаг/нийслэлийнхээс 3%-иар өндөр байна. Налайх дүүргийн иргэдийн хувьд дүүргийнхээ ИТХ-ын төлөөлөгчийг мэдэж буй байдал нь нийслэлийн төлөөлөгчийг мэдэж буй хувиас 2 дахин бага байна.

Аймгийн төвийн сумдын хувьд сумынхаа ИТХ-ын төлөөлөгчийг мэдэж буй байдал нь бусад сумдаасаа нэлээд бага байна. Энэ нь аймгийн төвийн сум нь бусад сумдаас харьцангуй олон багтай, хүн амын тоо их байдагтай холбоотой.

Хөдөө орон нутгийн иргэд төлөөлөгчөө нэрлэхдээ сумынхаа ИТХ-ын даргыг нэрлэх хандлага өндөр байсан юм.

Аймгийн төвийн сумдаас онцгойлон харахад Дархан-Уул аймгийн Дархан сумын хувьд төлөөлөгчөө зөв нэрлэж буй хувь бусад аймгийн төвийн сумдаас харьцангуй илүү байна. Фокус бүлгийн ярилцлагад оролцсон Дархан сумын иргэд өөрийн багийг төлөөлж буй төлөөлөгчөө сайн ажиллаж байгаа гэж дүгнэж байна.

> *Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*
>
> Хамгийн доод шат бол баг бөгөөд багийн маань удирдлага сайн ажиллаж байж улсын маань хөгжилд тодорхой хувь нэмэр ордог гэж би ойлгодог. Багийн Засаг дарга маань сайн ажилладаг бөгөөд сумын ИТХ-д төлөөлөгчөөр суудаг учраас янз бүрийн асуудал болохоор хурал цуглаан хийнэ. Та нар хурал цуглаанд оролцож бай, иргэддээ оролцоотой бай гэж байнга хэлдэг.
>
> ***Дархан-Уул аймаг, Дархан сумын иргэн***

Бусад сумтай харьцуулахад хүн амын тоо харьцангуй бага буюу 2200 – 4000 хүн амтай Гучин-Ус, Эрдэнэбулган, Манхан зэрэг сумдад ИТХ-ын төлөөлөгч нь иргэдтэйгээ илүү хүрч ажиллах боломжтой учир төлөөлөгчөө мэдэж буй хувь өндөр байна.

***Хүснэгт 41. Сум/дүүргийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийг нэрлэх байдал, байршлаар, хувиар***

| Байршил | Зөв нэрлэсэн | Нэрлэсэн хүн нь өөрийнх нь тойргийг төлөөлөөгүй ч тухайн орон нутгийн төлөөлөгч мөн | Буруу нэрлэсэн | Төлөөлөгч мэдэхгүй | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **Нийт** | **18.0** | **10.9** | **9.6** | **61.5** | **100** |
| **Улаанбаатар** | 6.4 | 3.2 | 7.8 | 82.6 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | <u>26.3</u> | 16.4 | 10.9 | 46.4 | 100 |
| **Дүүргээр** | | | | | |
| **БГД** | 2.0 | 7.8 | 15.7 | 74.5 | 100 |
| **БЗД** | 0.0 | 1.2 | 3.7 | <u>95.1</u> | 100 |
| **ЧД** | <u>13.2</u> | 0.0 | 3.9 | 82.9 | 100 |
| **СХД** | 8.8 | 5.3 | 5.3 | 80.5 | 100 |
| **СБД** | 4.0 | 2.0 | 9.9 | 84.2 | 100 |
| **ХУД** | 0.0 | 9.4 | 0.0 | <u>90.6</u> | 100 |
| **НД** | 15.2 | 0.0 | 19.6 | 65.2 | 100 |
| **Дархан уул** | | | | | |
| **Дархан** | 21.4 | 5.7 | 4.3 | 68.6 | 100 |
| **Шарын гол** | <u>55.3</u> | 15.8 | 5.3 | 23.7 | 100 |
| **Хонгор** | 40.0 | 8.6 | 5.7 | 45.7 | 100 |
| **Өвөрхангай** | | | | | |
| **Арвайхээр** | 12.8 | 0.0 | 10.6 | 76.6 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Хархорин** | 15.7 | 3.9 | 15.7 | 64.7 | 100 |
| **Гучин-Ус** | 28.8 | 28.8 | 16.7 | 25.8 | 100 |
| **Хөвсгөл** | | | | | |
| **Мөрөн** | 4.7 | 2.3 | 7.0 | 86.0 | 100 |
| **Эрдэнэбулган** | 39.5 | 25.6 | 7.0 | 27.9 | 100 |
| **Тариалан** | 26.7 | 30.0 | 16.7 | 26.7 | 100 |
| **Хэнтий** | | | | | |
| **Хэрлэн** | 0.0 | 8.0 | 14.0 | 78.0 | 100 |
| **Батноров** | 34.7 | 28.0 | 8.0 | 29.3 | 100 |
| **Өмнөдэлгэр** | 34.8 | 4.3 | 10.9 | 50.0 | 100 |
| **Ховд** | | | | | |
| **Жаргалант** | 6.5 | 9.7 | 19.4 | 64.5 | 100 |
| **Булган** | 23.1 | 59.0 | 15.4 | 2.6 | 100 |
| **Манхан** | 58.3 | 19.4 | 11.1 | 11.1 | 100 |

Хэдийгээр сумдын хүн амын тоо өөр ч сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгч нарын иргэддээ хүрч ажиллаж буй байдал нь харилцан адилгүй байгаагаас иргэд тэднийг хэр зэрэг мэдэж байгаа нь харагдаж байна. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хувьд сумынхаа захиргааны байрны гаднах самбарт хэн гэдэг төлөөлөгч аль багийг төлөөлж байгаа, мөн тэдэнтэй холбоо барих утас зэргийг маш тодорхой бичиж байрлуулсан байгаа нь төлөөлөгчөө сайн мэддэг болоход нөлөөлсөн байна.

*Зураг 20. Хөвсгөл аймаг, Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын гаднах самбар*




Мөн иргэдтэйгээ жилд хамгийн багадаа 4 удаагийн хурал, уулзалт зохион байгуулж, иргэдийнхээ санал бодлыг сонсдог, мөн нийтээр нь хурал зарлахаас гадна хэсэг бүлгээр нь эсвэл ганцаарчлан хүлээн авах, гэрээр нь зочлох зэргээр уулздаг хэмээн ганцаарчилсан ярилцлагад оролцсон бүх төлөөлөгч дурьдсан ч тухайн тойргийнх нь иргэд төлөөлөгчөө хангалттай түвшинд мэдэхгүй байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс*:

Миний хувьд давхардсан тоогоор 21 удаа бүх багт очиж уулзаж байсан. Нийт сумын хэмжээнд бүх багийн хуралд очдог. Нэг багт жилдээ албан ёсны хурал 4 удаа бусад арга хэмжээ нийлээд 6 удаа очдог.

***Хөвсгөл аймаг, Эрдэнэбулган сумын ИТХ-ын төлөөлөгч***

Иргэдийн санал бодлыг сонсох хамгийн зөв арга зам бол биечлэн ганцаарчлан уулзах явдал байдаг. Учир нь иргэд хурал уулзалтын үеэр өөрийн санал бодол, санал хүсэлтээ бүрэн илэрхийлж чаддаггүй.

***Өвөрхангай аймаг, Хархорин сумын ИТХ-ын төлөөлөгч***

Би иргэдийн хурал бүхэнд очиж уулздаг. Тэнд иргэдийн санал бодлыг асууна. Мөн хуралд ирж чаддаггүй өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдынхоо гэрээр нилээн явж уулзаж ярилцдаг. Өнгөрсөн жил 4 удаагийн хуралд оролцсон.

***Хэнтий аймаг, Хэрлэн сумын ИТХ-ын төлөөлөгч***

Дүүргийнхээ ИТХ-ын төлөөлөгчдийг мэдэж буй байдал нь хороо тус бүрээр багагүй ялгаатай байна.

***Хүснэгт 42. Дүүргийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийг нэрлэсэн байдал, хороогоор, хувиар***

| Байршил | Зөв нэрлэсэн | Нэрлэсэн хүн нь өөрийнх нь тойргийг төлөөлөөгүй ч тухайн орон нутгийн төлөөлөгч мөн | Буруу нэрлэсэн | Төлөөлөгч мэдэхгүй | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **Улаанбаатар** | | | | | |
| **Нийт** | **6.4** | **3.2** | **7.8** | **82.6** | **100** |
| **БГД** | | | | | |
| **6-р хороо** | 0 | 12.5 | 4.2 | 83.3 | 100 |
| **11-р хороо** | 3.7 | 3.7 | 25.9 | 66.7 | 100 |
| **БЗД** | | | | | |
| **7-р хороо** | 0 | 4.2 | 8.3 | 87.5 | 100 |
| **8-р хороо** | 0 | 0 | 0 | 100 | 100 |
| **27-р хороо** | 0 | 0 | 3.4 | 96.6 | 100 |
| **ЧД** | | | | | |
| **1-р хороо** | 28.6 | 0 | 0 | 71.4 | 100 |
| **4-р хороо** | 0 | 0 | 8.0 | 92.0 | 100 |
| **19-р хороо** | 13.3 | 0 | 3.3 | 83.3 | 100 |
| **СХД** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **14-р хороо** | 16.7 | 0 | 0 | 83.3 | 100 |
| **24-р хороо** | 0 | 16.7 | 13.3 | 70 | 100 |
| **25-р хороо** | 20.7 | 3.4 | 3.4 | 72.4 | 100 |
| **31-р хороо** | 0 | 0 | 3.3 | 96.7 | 100 |
| **СБД** | | | | | |
| **10-р хороо** | 6.7 | 3.3 | 16.7 | 73.3 | 100 |
| **14-р хороо** | 0 | 0 | 7.4 | 92.6 | 100 |
| **15-р хороо** | 3.7 | 3.7 | 11.1 | 81.5 | 100 |
| **20-р хороо** | 5.9 | 0 | 0 | 94.1 | 100 |
| **ХУД** | | | | | |
| **3-р хороо** | 0 | 9.4 | 0 | 90.6 | 100 |
| **НД** | | | | | |
| **1-р хороо** | 23.5 | 0 | 17.6 | 58.8 | 100 |
| **2-р хороо** | 6.7 | 0 | 20 | 73.3 | 100 |
| **5-р хороо** | 14.3 | 0 | 21.4 | 64.3 | 100 |

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс*:

Иргэд надтай уулзах, гар утсаар ярих, би иргэд нэг бүртэй тулж ажилладаг.

***Улаанбаатар хот, ХУД, хорооны Засаг дарга, төлөөлөгч***

Улаанбаатар хотын иргэдийн хувьд дүүргийнхээ төлөөлөгчийг *огт хараагүй* гэсэн хувь нь нийслэлийн төлөөлөгчийг *огт хараагүй* гэсэн хувиас тийм ч ялгаатай биш байна. Өөрөөр хэлбэл, нийслэлийн иргэд дүүргийн төлөөлөгчийг нийслэлийн төлөөлөгчтэй л адил мэдэхгүй байгаа бол эсрэгээрээ ороннутгийн иргэд сумынхаа төлөөлөгч аймгийнхаас сайн мэдэж байна. Аймгийн төвийн сумаас бусад сумдын хувьд сарын өмнө төлөөлөгчөө харсан гэсэн хувь өндөр байна.

Иргэд сум/дүүргийнхээ төлөөлөгчийг сарын өмнө харсан гэсэн хувь өндөр байгаа ч өөрийн баг/хороог төлөөлж буй төлөөлөгчөө зөв нэрлэж буй хувь нь тэр хэмжээгээр өндөр байж чадахгүй байна. Энэ нь тухайн төлөөлөгчийг сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгч мөн гэдгийг мэдэж байгаа ч хэн нь аль баг/хороог төлөөлж байгааг ялгаж мэдэхгүй болохыг харуулж байна.

*Хүснэгт 43. Сонгогдсон сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, байршлаар, хувиар*

| Байршил | Сарын өмнө | 2-5 сарын өмнө | 6 сарын өмнө | 1 жилийн өмнө | 2 жилийн өмнө | Сонгуулийн кампанит ажлын үеэр /2012 онд/ | Огт хараагүй | Мэдэхгүй /санахгүй байна | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт** | 31.3 | 7.6 | 1.8 | 2.0 | .8 | 4.0 | 42.8 | 9.8 | 100 |
| **Улаанбаатар** | 9.4 | 6.2 | 1.8 | 2.2 | 1.0 | 5.2 | <u>61.0</u> | 13.2 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | <u>46.9</u> | 8.6 | 1.7 | 1.9 | .7 | 3.1 | 29.7 | 7.4 | 100 |
| **Дүүргээр** | | | | | | | | | |
| **БГД** | <u>13.7</u> | 7.8 | 5.9 | 2.0 | 0 | 2.0 | 66.7 | 2.0 | 100 |
| **БЗД** | 4.9 | 1.2 | 1.2 | 2.5 | 2.5 | 6.2 | 65.4 | 16.0 | 100 |
| **ЧД** | <u>13.2</u> | 13.2 | 1.3 | 1.3 | 2.6 | 7.9 | 39.5 | 21.1 | 100 |
| **СХД** | 10.6 | 6.2 | .9 | .9 | 0 | 5.3 | 59.3 | 16.8 | 100 |
| **СБД** | 7.9 | 1.0 | 3.0 | 3.0 | 0 | 5.0 | 65.3 | 14.9 | 100 |
| **ХУД** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100 | 0 | 100 |
| **НД** | <u>13.0</u> | 17.4 | 0 | 6.5 | 2.2 | 6.5 | 50 | 4.3 | 100 |
| **Сумдаар** | | | | | | | | | |
| **Дархан-Уул** | | | | | | | | | |
| **Дархан** | 18.6 | 18.6 | 2.9 | 1.4 | 1.4 | 2.9 | 22.9 | 31.4 | 100 |
| **Шарын гол** | <u>86.8</u> | 2.6 | 0 | 0 | 0 | 0 | 2.6 | 7.9 | 100 |
| **Хонгор** | 51.4 | 2.9 | 2.9 | 2.9 | 0 | 5.7 | 31.4 | 2.9 | 100 |
| **Өвөрхангай** | | | | | | | | | |
| **Арвайхээр** | 23.4 | 4.3 | 4.3 | 2.1 | 0 | 8.5 | <u>57.4</u> | 0 | 100 |
| **Хархорин** | 23.5 | 5.9 | 2.0 | 3.9 | 0 | 7.8 | 51.0 | 5.9 | 100 |
| **Гучин-Ус** | <u>65.2</u> | 1.5 | 1.5 | 0 | 0 | 0 | 24.2 | 7.6 | 100 |
| **Хөвсгөл** | | | | | | | | | |
| **Мөрөн** | 14.0 | 14.0 | 2.3 | 2.3 | 0 | 0 | <u>55.8</u> | 11.6 | 100 |
| **Эрдэнэбулган** | 76.7 | 14.0 | 0 | 0 | 0 | 0 | 2.3 | 7.0 | 100 |
| **Тариалан** | <u>63.3</u> | 3.3 | 3.3 | 6.7 | 3.3 | 0 | 13.3 | 6.7 | 100 |
| **Хэнтий** | | | | | | | | | |
| **Хэрлэн** | 16.0 | 10 | 2.0 | 4.0 | 0 | 14.0 | <u>52.0</u> | 2.0 | 100 |
| **Батноров** | <u>58.7</u> | 12.0 | 2.7 | 0 | 0 | 1.3 | 20.0 | 5.3 | 100 |
| **Өмнөдэлгэр** | 43.5 | 6.5 | 0 | 4.3 | 2.2 | 0 | 39.1 | 4.3 | 100 |
| **Ховд** | | | | | | | | | |
| **Жаргалант** | 16.1 | 6.5 | 0 | 0 | 3.2 | 6.5 | <u>67.7</u> | 0 | 100 |
| **Булган** | <u>84.6</u> | 12.8 | 0 | 2.6 | 0 | 0 | 0 | 0 | 100 |
| **Манхан** | <u>83.3</u> | 5.6 | 0 | 0 | 2.8 | 0 | 5.6 | 2.8 | 100 |

### *Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон байдал*

**Судалгаанд оролцсон 10 хүн тутмын 1 нь 2012 оны орон нутгийн сонгуулиас хойш өөрийн тойргоос сум/дүүргийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчтэй ямар нэгэн зорилгоор холбогджээ. Энэ үзүүлэлт хөдөө орон нутагт нийслэлээс 4 дахин их байна.**

*Зураг 21. Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон байдал*




Сум/дүүргийн дунджаар **2.6** удаа холбогдсон байна.

Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн иргэдийн сум/дүүргийнхээ төлөөлөгчтэй холбогдсон зорилго ялгаатай байгаа бөгөөд нийслэлийн иргэд ихэвчлэн газар өмчлөл, дэд бүтцийн асуудлаар холбогдсон байхад орон нутгийн иргэд хувийн асуудлаар, зээлд хамрагдах хүсэлт гаргах, газар өмчлөлийн асуудлаар холбогдсон байна.

Харин ИТХ-ын төлөөлөгчдөөс иргэд ямар асуудлаар хамгийн их ханддаг болохыг тодруулахад орон нутгийн хувьд ажлын байрны дэмжлэг хүсч хамгийн их ханддаг аж. Нийслэлийн хувьд орон байрны дэмжлэг, эмчилгээний зардал, газар өмчлөлийн асуудлаар гол төлөв ханддаг байна.

Иргэд өмнө нь гудамж талбайд хаясан хог, хур хог хаягдал, хугацаанд нь хогоо ачихгүй байна гэх зэргээр ихээхэн ханддаг байсан бол одоо энэ асуудал харьцангуй цэгцэрч хандах нь бага болсон хэмээн дүүргийн төлөөлөгчид дурьдаж байлаа.

*Зураг 22. ИТХ-ын төлөөлөгчтэй уулздаг шалтгаан, байршлаар*




*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

100 хүн тутмын 70 хүн нь ажлын байрны дэмжлэг хүсч ханддаг гэж хэлж болно.

***Ховд аймаг, Манхан сумын ИТХ-ын төлөөлөгч***

Иргэдийн хувьд амьдрал нь болж бүтээд байгаа хүмүүс тэр бүр хандаад байдаггүй. Харин амьдрал тааруу хүмүүс л хувийн шинжтэй гуйлт, хүсэлт, тусламж хүсэн их орж ирдэг.

***Улаанбаатар хот, ЧД-ийн ИТХ-ын төлөөлөгч***

Иргэд өргөдөл бичээд орж ирж байгаа гол шалтгаан нь ажилтай болгож өгөөч гэсэн байдаг. Гэтэл өнөөдөр ИТХ иргэдэд олгох ажлын орон тоо байдаггүй учраас үүнийг холбогдох газар луу нь буюу Сумын Засаг даргад аль эсвэл Мөрөн сумын хот тохижилт үйлчилгээний газар ч юмуу ИТХ-ын Даргын гарын үсэгтэй албан бичиг хавсарган явуулж байна. Өөрөөр бидэнд шийдэх арга байхгүй байна.

***Хөвсгөл аймаг, Мөрөн сумын ИТХ-ын төлөөлөгч***

**Дээрх зорилгоор төлөөлөгчид хандаж байсан 10 хүн тутмын 4 нь хандсан асуудлыг нь бүрэн шийдэж өгсөн гэж үзэж байгаа бол 3 нь огт үр дүн гараагүй гэжээ. Харин энэ Улаанбаатар хотын иргэдийн 60 орчим хувь нь төлөөлөгчдөө хандсан асуудал нь огт шийдэгдээгүй буюу ямар ч үр дүн гараагүй гэж үзэж байгаа нь хөдөө орон нутгийхаас 2 дахин өндөр байна.**

Мөн төлөөлөгчдийн эрх мэдлийн хүрээнээс хэтэрсэн, шийдвэрлэж чадахааргүй асуудлаар хандах нь их байдаг бөгөөд тухайн асуудлыг нь дээд шатны байгууллагад уламжилж өгдөг гэж цөөнгүй төлөөлөгч дурьдаж байсан юм.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

Би дөнгөж төлөөлөгч болчихоод ИНХ дээр очиход надаас Оюу толгой, Таван толгой, эмнэлгийн талаар асууж байсан. Жишээ нь Оюу толгой тал дээр танай нам ямар байр суурьтай байна гэх зэргээр. Сонгогчийн боловсрол гэдэг зүйл нь бага байгаа учраас янз бүрийн УИХ-ын түвшний зүйлийг надаас асууж, нэхэж байсан. Гэтэл миний үүрэг бол орц, зогсоол, хог хаягдал гэдэг юм уу иргэдийн тав тухтай амьдрах тал дээр санал сэтгэгдлийг сонсож, тэрийг шийдвэрлэх үүрэгтэй ажилладаг.

***Улаанбаатар хот, ЧД-ийн ИТХ-ын төлөөлөгч***

***Хүснэгт 44. ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон асуудал хэрхэн шийдэгддэг байдал, байршлаар, хувиар***

| Байршил | 100% буюу бүрэн дүүрэн шийдэгдсэн | 75%-тай шийдэгдсэн | 50%-тай шийдэгдсэн | 25%-тай шийдэгдсэн | 0% буюу огт үр дүн гараагүй | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| **Нийт** | **43.1** | **15.4** | **6.5** | **4.1** | **30.9** | **100** |
| **Улаанбаатар** | 20.8 | 16.7 | 0 | 4.2 | 58.3 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | 48.5 | 15.2 | 8.1 | 4.0 | 24.2 | 100 |

Хурлын төлөөлөгчдөөс иргэдийн хандсан асуудлыг хэрхэн, хэдэн хувьтай шийдвэрлэдэг эсэхийг тодруулахад сум/дүүргийн ихэнх төлөөлөгч 60-80%-тай шийдвэрлэж чаддаг гэж байгаа ч иргэдийн өгч буй үнэлгээ нь үүнээс 2 дахин бага байна.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

Миний хувьд иргэдээс ирсэн санал гомдлын 80% орчмыг өөрөө шийдэж байгаа. Үлдсэн асуудлыг нь дээд шатны байгууллагад уламжиллаг.

***Улаанбаатар хот, ХУД, хорооны Засаг дарга бөгөөд төлөөлөгч***

Иргэдийн хандсан асуудлыг 50-60 хувийг шийдэж чадсан. Зарим асуудлыг шийдэх гэхээр хөрөнгө мөнгөний асуудал их дутмаг. Тэрнээс биш шийдвэрлээгүй асуудал гэж бараг огт байхгүй.

***Дархан-Уул аймаг, Хонгор сумын ИТХ-ын төлөөлөгч***

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

Надад хүн хүсэлт тавьсан л бол тэр хүсэлтийг би заавал биелүүдэг. Яагаад гэвэл тэр хүн надад итгэж хандаж байна. ИТХ-д тавьсан шаардлага хүсэлтийн 60 орчим хувийг бид шийдвэрлэж чаддаг. Эдгээр шийдвэрлэсэн санал хүсэлтэдс үндэслэн тогтоол шийдвэр гардаг учраас 60-аас дээш хувийг шийдвэрлэж байгаа гэж бардам хэлж чадна.

***Ховд аймаг, Жаргалант сумын ИТХ-ын төлөөлөгч***

***Зураг 23. Орон нутгийнхаа ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон байдал, байршлаар***




Иргэд сум/дүүргийнхээ төлөөлөгчтэй ихэвчлэн биеэр очиж уулздаг бөгөөд уулзахад ямар нэгэн хүндрэл учрах нь бага бөгөөд ороннутагт арай хялбар байдаг нь харагдаж байна. Харин төлөөлөгчтэй холбогдсон нийслэлийн иргэдийн 10 хүн тутмын 1-д нь төлөөлөгчтэйгөө холбогдоход нэлээд хүндрэл учирсан гэж үзэж байна.

***Зураг 24. Орон нутгийнхаа ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдоход хүндрэлтэй байдал, байршлаар***



*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс*:

Ганц хоёр оролдлогын дараа л уулзсан. Шууд уулзаад байхгүй нь ойлгомжтой тэр хүн чинь ажилтай. Тэгэхдээ ер нь уулзахад төвөгтэй.

***Улаанбаатар хот, СБД-ийн иргэн, эмэгтэй***

Нэг сумын улсууд ч зөндөө л таарч байдаг. Уулзахад бол хүндрэлтэй биш. Бид нараас илүү мэдлэг мэдээлэлтэй байгаа байх гэж бодоод зээл хөөцөлдөж байхдаа зөвлөгөө авч байсан.

***Хэнтий аймаг, Батноров сумын иргэн, эрэгтэй***

**Иргэдэд өөрсдөд нь болон гэр бүлийн хэн нэгэн гишүүнд, эсвэл орон нутгийн хөгжил, дэд бүтэц зэрэгтэй холбоотой аливаа асуудал тулгарвал хамгийн түрүүнд баг/хорооныхоо Засаг даргад ханддаг болохыг судалгааны үр дүн харуулж байна.**

***Зураг 25. Аливаа асуудал тулгарвал хамгийн түрүүнд хандах албан тушаалтан/байгууллага***



*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Хамгийн эхлээд багийн Засаг даргадаа хандана. Яагаад гэвэл сумын иргэдийг төлөөлж байгаа хүн гэж би ойлгодог. Хэрвээ багийн Засаг дарга шийдэж чадахгүй бол дараа нь аймгийн ИТХ-д хандана.

***Ховд аймаг, Булган сумын иргэн, эрэгтэй***

Би мэдлэг дутмаг байгаа болохоор яг хэнтэй яаж уулзахаа сайн мэдэхгүй байна. Зүгээр л хорооны Засаг дарга юмуу хэсгийн ахлагчтайгаа л уулзая гэж бодож байсан.

***Улаанбаатар хот, БЗД-ийн иргэн, эрэгтэй***

***Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд өгөх үнэлгээ***

**Сум/дүүргийнхээ төлөөлөгчийн үйл ажиллагаанд иргэдийн ¼ нь сайн гэсэн үнэлгээ өгч байгаа бол хөдөө орон нутгийн иргэдийн төлөөлөгчөө сайн ажилладаг гэж үнэлж байгаа бөгөөд хувь нийслэлээс өндөр байна.** Эдгээр сайн гэсэн үнэлгээ өгч байгаа иргэд төлөөлөгчдөө бусад багийн эсвэл өмнөх хурлын төлөөлөгчтэй харьцуулах байдлаар, мөн иргэд өөрсдийнхөө эргэн тойрон, амьдарч байгаа нөхцөл нь харьцангуй сайжирч байгаа учраас төлөөлөгчөө хэдий сайн мэдэхгүй ч тэднийг ажлаа хийж байгаа гэж дүгнэх хандлагатай байлаа.

Харин дараах шалтгааны улмаас төлөөлөгчдөө дунд гэсэн үнэлгээ өгөх, мөн мэдэхгүй гэсэн хариулт өгөх хандлага их байна. Үүнд:

- Сум/дүүргийнхээ төлөөлөгчдийг мэддэггүй учраас үнэлгээ өгч мэдэхгүй;
- Төлөөлөгчдийн үйл ажиллагааг хангалттай сайн мэддэггүй;
- Төлөөлөгчдийн хийж байгаа зүйлтэй танилцахыг хичээдэггүй;
- Хурал уулзалтад тэр бүр очоод байдаггүй;
- Төлөөлөгчид хандах ямар нэгэн асуудал тулгардаггүй;
- Төлөөлөгчид өөрсдийнхөө хэмжээнд ажлаа хийж байгаа байх гэдэг бодолтой байдаг.

***Хүснэгт 45. Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд өгөх үнэлгээ, байршлаар, хувиар***

| Байршил | Маш сайн | Зарим талаар сайн | Дунд | Зарим талаар муу | Маш муу | Мэдэх-гүй | Хариу-лахаас татгалзсан | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт** | 7.3 | 18.0 | 25.4 | 4.8 | 10.4 | 33.5 | 0.6 | 100 |
| **Улаанбаатар** | 5.8 | 9.2 | 23.2 | 6.0 | 14.8 | 40.0 | 1.0 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | 8.4 | 24.3 | 27.0 | 3.9 | 7.3 | 28.9 | 0.3 | 100 |
| **Аймгаар** | | | | | | | | |
| **Дархан-Уул** | 2.1 | 36.4 | 28.7 | 7.0 | 8.4 | 17.5 | 0 | 100 |
| **Өвөрхангай** | 6.7 | 17.7 | 19.5 | 3.0 | 6.1 | 47.0 | 0 | 100 |
| **Хөвсгөл** | 12.9 | 25.9 | 31.9 | 1.7 | 2.6 | 24.1 | 0.9 | 100 |
| **Хэнтий** | 11.7 | 21.1 | 26.9 | 3.5 | 7.0 | 29.8 | 0 | 100 |
| **Ховд** | 9.4 | 21.7 | 31.1 | 3.8 | 13.2 | 19.8 | 0.9 | 100 |

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Мэдээлэл авах гэж зорихгүй байгаа нь бас бид нарын буруу. Тэр хүний юу хийж байгааг мэдэхгүй болохоор тэр хүнд үнэлгээ өгч чадахгүй байна. Магадгүй бид мэдээлэл байхгүйгээсээ болж ажлаа хийж байгаа хүнийг юм хийхгүй байна гэж буруутгаж болохгүй. Ажилаа хийдэг л байх.

***Ховд аймаг, Жаргалант сумын иргэн, эмэгтэй***

ИТХ-д асуудал тавих шаардлага надад гараагүй. Тэгэхдээ миний орчин тойрон сайжраад байхыг харахаар 4 оноо/сайн үнэлгээ өгнө.

***Улаанбаатар хот, СБД-ийн иргэн, эрэгтэй***

Би дунд үнэлгээ өгнө. Өөрөө элдэв асуудал гарлаа гэж хөөцөлдөж уулзаж үзээгүй байж нэг их муу үнэлгээ өгөх нь дэмий болов уу гэж бодлоо. Мөн залуу хүмүүс байж нийгмийн идэвх муу байгаа нь бид нарын буруу.

***Хэнтий аймаг, Хэрлэн сумын иргэн, эмэгтэй***

Манайх хөдөө байхад Чойсүрэн гэдэг ИТХ-ын төлөөлөгч байсан юм. Тэр хүн мориор маш их явж хүмүүст мэдээлэл хүргэдэг байсан. Хурал болгоны дараа хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, та нарын санал хүсэлт юу байна гэж байнга харилцдаг байсан. Харин одоогийн төлөөлөгч нарт хүнтэй харилцах идэвхтэй харилцаа дутаж байна.

***Дархан-Уул аймаг, Дархан сумын иргэн, эмэгтэй***

Сум/дүүргийнхээ төлөөлөгчид муу болон маш муу гэсэн үнэлгээ өгч байгаа иргэдээс шалтгааныг тодруулахад:

- Төлөөлөгчид иргэдэд хүрч ажиллаж чадахгүй байна;
- Мэдээлэл өгдөггүй, тайлагнадаггүй;
- Давхар ажилтай байдаг учраас төлөөлөгчийнхөө ажлаа сайн хийхгүй байна;
- Өмнө нь хандаж байсан асуудлыг шийдвэрлэж өгөөгүй;
- Юу хийж байгаа нь мэдэгдэхгүй, эргэн тойронд өөрчлөлт гарахгүй байна гэж үзэж байна.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Иргэдийн санаа бодлыг төлөөлж чаддаг хүн байхгүй байна. Төлөөлөхөө мартчихсан хүмүүс байдаг. Иргэдийн төлөөлөгч, тэргүүлэгч нар ард иргэдтэй огт уулзаж ярилцдаггүй. ИТХ дээр очоод ярьж хэлдэг зүйл иргэдийн санаа бодлыг бус өөрдсийн ашиг сонирхлын хүрээнд л хурал хийдэг. Мэдээлэл түгээдэггүй.

***Ховд аймаг, Булган сумын иргэн, эрэгтэй***

Сумын ИТХ-ын төлөөлөгч нар суманд хийгдэж байгаа ажил арга хэмжээнээс хөдөөгийн ард иргэдэд хүргэх, мэдээлэх зэрэг хийж байгаа ажил нэг ч байхгүй.

***Өвөрхангай аймаг, Арвайхээр сумын иргэн, эмэгтэй***

**Иргэд** өөрсдийн бодлын дагуу одоогийн төлөөлөгчдөө үнэлсэн бөгөөд сум/дүүргийг төлөөлөх төлөөлөгч хүн ямар шалгуур хангасан байх хэрэгтэйг тодруулахад хамгийн чухал буюу нэгдүгээрт, **тухайн орон нутгийнхаа нөхцөл байдлыг сайн мэддэг хүн төлөөлөгч болох хэрэгтэй гэж үзэж байна. Нийт дүнгээр нь авч үзвэл, төлөөлөгч хүн иргэдийнхээ санал бодлыг сонсдог байх, орон нутгийнхаа нөхцөл байдлыг сайн мэддэг байх, шударга байх ёстой гэсэн шалгууруудыг иргэд хамгийн их чухалчилж байна.**

***Зураг 26. Иргэдийн төлөөлөгчид тавих шалгуур, чухалчилж үзэж буй хүчин зүйлс***



*Зураг 27. Төлөөлөгч хүн хүйсийн хувьд аль нь байвал зохимжтой талаарх хандлага*




**Төлөөлөгч хүн хүйсийн хувьд ямар байвал илүү дээр вэ гэдэг асуудалд иргэд тийм ч хатуу байр суурьтай биш, тэдний тал хувь нь эрэгтэй, эмэгтэй аль нь ч байсан хамаагүй гэж үзэж байна.**



## 3.5. БАГ, ХОРООНЫ ХУРЛЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ОРОЛЦОО

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд зааснаар “Иргэдийн Нийтийн Хурал” гэдэг нь иргэд орон нутгийн асуудлаа хамтран хэлэлцэж, өөрсдийн сонгосон төлөөллийн байгууллагад шийдвэрлүүлэхээр уламжлах эсвэл шууд бие даан шийдвэр гаргах эрх бүхий бүтцийг хэлнэ. Мөн хуульд асуудал шийдвэрлэх баг/хорооны хурлын ирцийн хувьд сонгуулийн насны иргэд 30%-иас доошгүй байна хэмээн заажээ.

Энэ бүлэгт иргэд баг/хорооны хурал буюу ИНХ-д хэр зэрэг идэвхтэй оролцдог, өнгөрсөн онд хэдэн удаа оролцсон, хурлын тухай мэдээллийг хэрхэн олж авсан, хэрэв оролцож байсан бол ямар асуудал хэлэлцсэн, мөн оролцоо муу байгаа нь ямар учир шалтгаантай болон цаашид хуралд оролцох төлөв байдлыг тодруулсан болно.

**Баг/хорооны Засаг даргыг сонгох ИНХ-д иргэд оролцож саналаа өгсөн байдал нь нийслэл хотод 30%-тай байхад ороннутагт нийслэлээс 2 дахин илүү буюу 70%-тай байна.**

*Хүснэгт 46. Иргэдийн баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд оролцсон байдал, байршлаар, хувиар*

| Байршил | Оролцсон | Оролцоогүй | Хариулахаас татгалзсан | Нийт |
|---|---|---|---|---|
| **Нийт** | 46.9 | 52.9 | 0.2 | 100 |
| **Улаанбаатар** | 29.8 | 69.8 | 0.4 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | 69.4 | 30.6 | | 100 |
| **Дүүргээр** | | | | |
| **БГД** | 23.5 | 76.5 | - | 100 |
| **БЗД** | 19.8 | 79.0 | 1.2 | 100 |
| **ЧД** | 47.4 | 52.6 | - | 100 |
| **СХД** | 31.9 | 68.1 | - | 100 |
| **СБД** | 22.8 | 76.1 | 1.0 | 100 |
| **ХУД** | 12.5 | 87.5 | - | 100 |
| **НД** | 47.8 | 52.2 | - | 100 |
| **Аймгаар** | | | | |
| **Дархан-Уул** | 68.5 | 31.5 | - | 100 |
| **Өвөрхангай** | 67.1 | 32.9 | - | 100 |
| **Хөвсгөл** | 70.7 | 29.3 | - | 100 |
| **Хэнтий** | 63.7 | 36.3 | - | 100 |
| **Ховд** | 82.1 | 17.9 | - | 100 |

Улаанбаатар хотын хувьд Баянзүрх, Хан-Уул дүүргийн иргэд хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд хамгийн идэвх султай оролцдог нь харагдаж байна. Гэтэл Хан-Уул дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас харвал иргэдтэйгээ хамтран ажиллах, иргэдийг хуралд оролцох идэвхийг сайжруулах ажлыг маш сайн хийдэг гэж дурьдаж байлаа. Тухайлбал, Хан-Уул дүүргийн 3-р хороо нь нийт 1000 орчим ахмадтай бөгөөд жил бүр Ахмадын өдрөөр ахмадуудаа хотоос гадагш агаарт гаргаж амраах, тэдний зургийн цомогтой ном хийж бэлэглэх, хагас болон бүтэн өнчин хүүхдүүдэд ном хичээлийн хэрэгсэл өгөх,

Эмэгтэйчүүдийн холбоо байгуулан ажиллаж, 75 орчим залуу нэгдэн Залуучын холбоо байгуулаад хороотойгоо ойр хамтарч ажилладаг гэх мэт олон зүйлийг хийдэг гэжээ. **Харамсалтай нь, зөвхөн хорооны Засаг дарга сонгох хурал гэлтгүй бусад ИНХ-д ч иргэдийн оролцоо маш бага хувьтай байна.**

Харин Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны иргэдийн төлөөллийг оролцуулсан фокус бүлгийн ярилцлагаас дүгнэхэд, хорооны зүгээс баяр ёслолоор иргэдийн төлөөлөгч нь иргэддээ үзвэр үзүүлэх эрх өгч, гарын бэлэг өгсөн, өрхөөр зочилж хорооны мэдээлэл тараасан гэх мэт иргэдийг идэвхжүүлэх ажил сайн хийдэг боловч иргэдийн өөрсдийн идэвх оролцоо муу байгаагаас хорооны хурлын ирц муу байна гэж дүгнэж болохоор байна. Мөн иргэдийн амьдарч байгаа орчин ямар байх нь тухайн иргэнээс шалтгаална гэдгийг иргэд мэдээд ирэхээр аяндаа тэдний оролцоо сайжрах хандлагатай хэмээн зарим ИТХ-ын төлөөлөгчид дурьдаж байсан юм.

Хөдөө орон нутгийн хувьд багийн Засаг дарга сонгох ИНХ-д оролцох аймгийн төвийн сумдын иргэдийн ирц хөдөөгийн сумдын иргэдийнхээс 10 орчим хувиар бага байна. Жишээ нь Хэнтий аймгийн төв Хэрлэн сумын иргэдийн оролцоог харахад 10 хүний 4 нь багийн Засаг дарга сонгох хуралд оролцсон нь бусад сумдаас хамгийн бага байна. Харин Хөвсгөл аймгийн Тариалан суманд 10 хүн тутмын 9 нь оролцсон нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Багийн ИНХ сонгуулийн үеэр маш олон хүнтэй болдог. Бусад хуралд 50 гаруй хүн л оролцдог. Голдуу ахмад настан, өрхийн тэргүүлэгчид, дундаж насны хүмүүс их оролцдог. Харин мал төллөх үеэр малчдын оролцоо бага байна.

***Хөвсгөл аймаг, Мөрөн сумын иргэн, эмэгтэй***

Хурлын талаар мэдээлэл байдаггүй. Хурал хаана хэзээ болох талаарх мэдээлэл байнга иргэдэд хүргэдэг байвал оролцож санал хүсэлтээ гаргамаар байдаг.

***Хэнтий аймаг, Хэрлэн сумын иргэн, эмэгтэй***

Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх нь ИНХ-ын талаар мэдээлэл байхгүй, тухайн үед завгүй байсан, орон нутгийн сонгуулийн үеэр оршин суугаа газраа байгаагүй гэсэн гол шалтгааны улмаас ИНХ-д оролцож, хорооны Засаг даргын сонгуульд саналаа өгч чадаагүй байна.

Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд сонгуулийн үеэр оршин суугаа газраа байгаагүй, завгүй байсан гэсэн хариулт өндөр байгаа нь малчид, тариаланчид мал төллөх цаг, тариалангийн улирал, оторт явах зэргээр эзгүй байх үе олон байдагтай холбоотой.

***Зураг 28. Баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд оролцоогүй шалтгаан, байршлаар, хувиар***




**Өнгөрсөн онд баг/хорооны ИНХ-д оролцсон байдал**

Өнгөрсөн жил буюу 2014 онд иргэдийн баг/хорооны ИНХ-д оролцсон байдлыг харахад баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуртай харьцуулахад идэвх бага байсан нь харагдаж байна. Баг/Хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд Улаанбаатар хотын иргэдийн 29.8%, ороннутгийн иргэдийн 69.4% нь оролцсон байсан. Харин өнгөрсөн жил баг/хорооны ИНХ-д Улаанбаатар хотын иргэдийн 38%, орон нутгийн иргэдийн 56.7% нь ямар нэгэн байдлаар оролцсон байна.

Өнгөрсөн онд ИНХ-д оролцоогүй нийслэлийн иргэдийн хувь орон нутгийн иргэдтэй харьцуулахад 1.7 дахин өндөр байна.

***Хүснэгт 47. Иргэдийн ИНХ-д 2014 онд оролцсон байдал, байршлаар, хувиар***

| Байршил | Огт оролцоогүй | Нэг удаа | Хоёр удаа | Гурван удаа | 4 болон түүнээс дээш удаа | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| **Нийт** | 55.3 | 14.4 | 14.8 | 7.7 | 7.9 | 100 |
| **Улаанбаатар** | 72.0 | 10.2 | 9.4 | 3.0 | 5.4 | 100 |
| **Хөдөө орон нутаг** | 43.3 | 17.4 | 18.6 | 11.0 | 9.7 | 100 |
| **Дүүргээр** | | | | | | |
| **БГД** | 70.6 | 7.8 | 9.8 | 3.9 | 7.9 | 100 |
| **БЗД** | 81.5 | 7.4 | 8.6 | 1.2 | 1.2 | 100 |
| **ЧД** | 64.5 | 14.5 | 7.9 | 5.3 | 7.9 | 100 |
| **СХД** | 71.7 | 12.4 | 9.7 | 0.9 | 5.4 | 100 |
| **СБД** | 70.3 | 10.9 | 6.9 | 5 | 7 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ХУД** | 96.9 | 3.1 | 0.0 | 0.0 | 0.0 | 100 |
| **НД** | 56.5 | 8.7 | 23.9 | 4.3 | 6.5 | 100 |
| **Аймгаар** | | | | | | |
| **Дархан-Уул** | 51.0 | 19.6 | 14.7 | 8.4 | 6.3 | 100 |
| **Өвөрхангай** | 42.1 | 21.3 | 23.2 | 8.5 | 4.9 | 100 |
| **Хөвсгөл** | 40.5 | 19.8 | 19 | 9.5 | 11.3 | 100 |
| **Хэнтий** | 39.2 | 11.7 | 17.5 | 17 | 13.4 | 100 |
| **Ховд** | 43.3 | 17.4 | 18.6 | 11 | 9.7 | 100 |

Иргэдийн оролцооны түвшинг байршил тус бүрээр нь харвал Хан-Уул дүүргийн иргэдийн оролцоо маш бага буюу 3.1% нь л хуралд оролцдог гэсэн байна. Улаанбаатар хотын дүүргүүдийн хувьд Налайх дүүргийн иргэдийн идэвх хамгийн өндөр байна. Харин төвийн 6 дүүргийн хувьд Чингэлтэй дүүргийн иргэдийн хуралд оролцох идэвх хамгийн өндөр буюу 35.5% нь оролцсон байна. Харин эдгээр хуралд оролцсон иргэдийн бараг тал хувь нь өнгөрсөн жил зөвхөн 1 удаа л хуралд оролцсон гэжээ.

Судалгаанд хамрагдсан орон нутгийн иргэдийн дундаас Хэнтий аймгийн иргэдийн идэвх хамгийн өндөр байна. Нийт иргэдийн 60.8% нь өнгөрсөн жил хуралд оролцсон байна. Мөн 4 удаагийн хуралд 4-үүлэнд нь суусан иргэдийн хувь ч Хэнтий аймагт өндөр байна.

ИТХ-ын төлөөлөгч, нутгийн удирдлагын төлөөллийг оролцуулсан ганцаарчилсан ярилцлага болон хоёрдогч мэдээллийн хуудсаас харахад Улаанбаатар хотын хувьд жилд дунджаар 6-7 удаа хорооны, оріннутагт жилд дунджаар 4 удаагийн багийн хурал, уулзалт зохион байгуулжээ.

Орон нутгийн иргэдийн багийн хуралд оролцох идэвх 2014 онд дунджаар 80%-тай байсан бөгөөд сүүлийн үед залуусын идэвх сайжирч байгаа гэсэн боловч иргэдээс авсан тоон судалгаагаар **18-35 насны залуусын 10 хүрэхгүй хувь нь жилд 1-2 удаагийн ИНХ-д оролцдог байна.** 18-35 насны залуусын хувьд оролцсон ч жилд хоёроос дээш удаа ИНХ-д оролцоогүй байна.

**Иргэдийн баг/хорооны хуралд оролцдоггүй шалтгаан**

ИНХ-д оролцдоггүй шалтгаан нь Улаанбаатар хот болон оріннутгийн иргэдийн хооронд ялгаатай байна.

Иргэдийн баг/хорооны хуралд оролцдоггүй гол шалтгаан нь хурлын талаарх мэдээлэл байгаагүй, завгүй байсан, хурал болж байхад гэртээ байгаагүй зэрэг байна. **Хурлын талаарх мэдээлэл аваагүй иргэд Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас 2 дахин өндөр байна.**

### *Зураг 29. ИНХ-д оролцдоггүй шалтгаан байршлаар, хувиар*




Үүнээс гадна иргэдийн сэтгэлгээнд суусан хэд хэдэн нийтлэг ойлголт, шалтгаан иргэдийг, ялангуяа залуучуудын ИНХ-д оролцох оролцоог хязгаарладаг байна:

- Олон нийтийн хуралд оролцсон, оролцоогүй шийдвэр гаргах түвшинд хүрч чадахгүй;
- ИНХ-д өндөр настай, тэтгэвэрт суусан завтай хүмүүс суудаг;
- ИНХ-д оролцож байгаа иргэд шийдэлд хүрч чадахгүй хэлэлцүүлэг мэтгэлцээн болсноор хурал дуусгавар болдог нь иргэдийн сонирхлыг татахгүй байна;
- ИНХ болон ИТХ-ын үйл ажиллагаа иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд нөлөөлж чадахгүй, зөвхөн УИХ-ын гишүүд болон Ерөнхийлөгчийн шийдвэр аж амьдралд нөлөөлж чадна;
- Нийт иргэдийн нийгмийн ерөнхий идэвх буурсан;
- Зөвхөн амьдарч буй орчинд нь ямар нэгэн асуудал тулгарах үед л ИНХ-д оролцож шүүмжлэл хэлэх хандлагатай байна.
- ИНХ-аас залуучуудыг оролцуулсан мэргэшүүлэх сургалт хөтөлбөрт хамруулах, сургалтанд хамрагдсан хүмүүсийг нэгтгээд нэг ажил хийе гэхэд баг/хороонд төсөв мөнгө хүрэлцдэггүй байна.

Хотод хэсгийн ахлагчийн хувьд ороннутгийн хэсгийн ахлагчтай харьцуулахад ажиллах газар нутгийн хамрах хүрээ багатай учраас өрхүүдэд хүрч ажиллах нь арай илүү байхад орон нутагт ажиллаж байгаа Засаг даргын бие төлөөлөгч нарын иргэдтэй ойр ажиллаж мэдээлэл түгээх байдал нь хотыхоос 15%-иар бага байна. Энэ нь зарим сумын багуудад байрлах өрх хоорондын зай хол байрладаг, багийн Засаг дарга болон хэсгийн ахлагч нар иргэддээ хүрч ажиллаж мэдээлэл хүргэх арга зам олж чадаагүй байгааг харуулж байна.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Манай багийн ахлагч өмнө нь гэрээр ороод хурлын зар тараадаг, мөн өрхүүдээр зочилж аж амьдрал ямар байна гээд явдаг байсан, одоо бүр тийм зүйл байхгүй болсон. ИНХ-ын зарыг Цагаан худагны хананд жижигхэн цаасан дээр бичиж наасан байхыг дээхэн нэг харсан.

***Хэнтий аймаг, Хэрлэн сумын иргэд***

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

Бид хуралд ороод сууж байхад "өө баахан настай хүмүүс байна. Гаръя, явъя" гээд залуучууд гараад явдаг.

***Дархан-Уул аймаг, Дархан сумын иргэн, эрэгтэй***

Хуралд оролцож байгаа иргэд ямар нэгэн асуудлаа шийдүүлэх гэж оролцдог. Зарим хэсэг нь өөрсдийн хэргийг бүтээсэн бол дараа дараагийн хурал хэнд ч хамаагүй гэсэн бодолтой байгаа харагддаг.

***Ховд аймаг, Жаргалант сумын ИТХ-ын төлөөлөгч***

**Хуралд оролцдоггүй иргэд ямар сувгаар ИНХ-ын талаарх мэдээлэл авахыг хүсч байна вэ?**

Судалгаанд хамрагдсан иргэдээс ИНХ-ын товын талаарх мэдээллийг ямар сувгаар авбал зохимжтойг тодруулбал:

- Утсаар *(Ихэнх хүмүүс утсаар хурлын мэдээллийг авах нь цаг хугацаа төсөв мөнгөнд хэмнэлттэй гэжээ);*
- Мессэжээр (*Мессэжээр хурлын мэдээлэл явуулвал утас холбогдохгүй байсан ч нээх үед унших боломжтой);*
- Урилгаар;
- Том хэмжээний самбарын зараар *(Хүний нүдэнд харагдахуйц газар том хэмжээний самбарт хурлын товыг тавих);*
- Гудамжны өнцөг буланд наасан зараар;
- Орон нутгийн ТВ-үүдийн урсдаг зараар;
- Цагаан хоолойгоор;
- 20 айлыг 1 хүн хариуцаж аваад айл болгоноор ороод яригдах асуудалтай нь зар тараах;
- Фэйсбүүкээр (Сүүлийн үед онлайн ертөнц хөгжиж байгаатай холбоотойгоор залуусыг оролцуулахын тулд тэдний идэвхтэй байдаг орчноор дамжуулж зар тараах /Facebook, twitter гэх мэт/).

**Эндээс дүгнэхэд, иргэд баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хурал хаана хэзээ болох талаарх мэдээлэл хангалттай авч чаддаггүй, хорооноос иргэдийн сонирхлыг татахуйц ач холбогдолтой ажлыг зохион байгуулдаггүй болох нь тоон судалгааны үр дүнгээс гарч байна. Иймд иргэдээс санал болгож байгаа мэдээлэл түгээх сувгуудийг ашиглаж хурлын ирцийг нэмэгдүүлэх боломж байна.**

Хэвлэмэл материалаар мэдээлэл тараах нь хуучинсаг болохоор иргэд сонгуультай холбоотой материал гээд уншилгүй хаях тохиолдол байна.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

ИНХ-ын зар нь ирдэггүй, би ер нь нийгмийн идэвх муу, ээжийг байхад ээжээс мэдээлэл авчдаг байсан. Сүүлийн үед мэдэхгүй байгаа.

***Улаанбаатар хот, СБД-ийн иргэн, эрэгтэй***

Хурлын зарыг худаг дээр, алга дарам жижиг цаасан дээр бичсэн байдаг болохоор тэрийг хүмүүс олж харахгүй. Харин томхон самбар дээр тавих хэрэгтэй.

***Улаанбаатар хот, БЗД-ийн иргэн, эмэгтэй***

**Хуралд оролцдог иргэдийн талаар**

Хуралд оролцож байгаа иргэдийг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл Улаанбаатар хотод тэтгэвэрт гарсан хүмүүс 23%, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс 20%-ийг эзэлж байна. Ороннутагт тогтсон ажил эрхэлдэггүй хүмүүс 18.4%, төрийн болон төсвийн байгууллагын ажилчид 17.9%-ийг эзэлж байна. Үүнээс харахад ороннутагт төрийн болон төсвийн байгууллагад ажилладаг иргэд оролцох хандлага Улаанбаатар хотоос өндөр байна.

Харин хуралд оролцдог иргэд хурлын товын талаарх мэдээллийг ямар сувгаар олж авдаг талаар тодруулахад биет төлөөлөгчийн хүргэсэн зарын дагуу хуралд оролцсон хандлага өндөр байна. Мөн олны нүдэнд (дэлгүүр, худаг, хорооны байр, гудамжны өнцөг гэх мэт) байрлуулсан зар, захиргааны байгууллагын мэдээллийн самбараас зарыг хүлээж авч очих байдал өндөр хув, эзэлж байна.

***Зураг 30. Баг/хорооны хурал хэзээ хаана болох талаарх мэдээллийг олж авдаг сувгууд байршлаар, хувиар***



Улаанбаатар хотын хувьд ИНХ-ын талаарх мэдээллийг сүүлийн үед интернет буюу онлайнаар ихэнх хувийг мэдээлдэг, мөн хурлын товын талаарх мэдээллийг зар самбар дээр наах, хэсгийн ахлагчаар урилга тараалгах зэргээр иргэдэд хүргэдэг гэж баг/хорооны Засаг дарга нар ярьж байхад бодит байдал дээр иргэд интернетээс мэдээлэл аваад ИНХ-д оролцсон гэсэн дүн байхгүй байна.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

Манай хороо цахим Зохион байгуулагч гэсэн хөтөлбөр зохион байгуулж байгаа. Хан-Уул дүүргийн хэдэн өрх нь интернеттэй тэдний хэд нь мэдээлэл авч чаддаг вэ гэсэн судалгаа явуулаад 60 гаруй хувь нь интернет мэдээллийн сувгаар мэдээлэл авдаг гэсэн нийгмийн ажилтны гаргасан судалгаа байгаа.

***Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хорооны ЗД,***
***ИТХ-ын төлөөлөгч***

Улаанбаатар хот болон хөдөө орон нутаг ялгаагүй ихэнх иргэд баг/хорооны Засаг дарга, түүний бие төлөөлөгч болох хэсгийн ахлагч, нийгмийн ажилтнаас хурлын зар мэдээлэл авдаг байна. Хэсгийн ахлагч нар өрхөөр зочилж урилга тараах, амаар болон бичгээр хурлын цаг өдрийн талаарх мэдээллийг дамжуулдаг. Харин онлайн буюу интернет орчноос мэдээлэл иргэдэд төдийлөн сайн хүрдэггүй нь судалгаанаас харагдаж байна. Маш цөөхөн хувь л утсаар, ойр орчны иргэдээс мэдээлэл авдаг гэжээ.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Багийн Засаг дарга сонгох үеэр урилга өгөөд хуралд оролцож байсан. Хэсгийн ахлагч нараас сонсч байсан.

***Хөвсгөл аймаг, Мөрөн сумын иргэд***

Манай хэсгийн ахлагч нар утсанд мессэж явуулдаг, мөн зарын самбараас харсан. Манай хорооноос хашааны өнцөгт зарлал наасан байдаг, бас утсаар ярьж хэлдэг.

***Улаанбаатар хот, Налайх дүүргийн иргэд***

**Иргэдийн оролцсон ИНХ-аар хэлэлцсэн асуудлууд**

ИНХ-д хэлэлцдэг асуудлуудын талаарх судалгаанд оролцсон Засаг дарга, иргэдийн саналыг тодруулбал:

*Зураг 31. ИНХ-аар хэлэлцсэн асуудлууд, Улаанбаатар хот, хувиар*




Улаанбаатар хотын 70 гаруй хувийг гэр хорооллын өрх эзэлдэгтэй холбоотойгоор ИНХ-д яригддаг асуудлууд дотроос амьдрах орчныг сайжруулах талаар ихэнхдээ хэлэлцдэг байна. Үүнээс гудамжны гэрэлтүүлэг, хог ачилт, золбин нохой устгал, орчны цэвэрлэгээ, гудамж талбайн тохижилтыг дурьдсан байна. Ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс, хорооны Засаг дарга нар үйл ажиллагааны тайлангаа жилд дунджаар 3 удаа тайлагнадаг байна. Харин иргэдээс авсан тоон судалгаанаас хорооны тайланг дунджаар 10 хүний 3 нь мэдэж байгаа доогуур үзүүлэлт гарсан байна. Дараагийн хэлэлцдэг асуудал нь, дэд бүтэц зам, харилцааны талаар 8%-тай дурьдсан байна. Хэдийгээр хотын төвөөр сүүлийн жилүүдэд авто зам шинээр тавьж байгаа боловч захын дүүргийн шинэ үүссэн хорооллууд авто замгүй, төвийн цахилгаан шугамд холбогдоогүй байна. ИНХ-д хамгийн чухал тооцогдох Орон нутгийн хөгжлийн сангийн талаар иргэд мэдээлэл муу байдаг нь хурал дээр энэ талаар яригдахгүй байгаатай холбоотой байна. ИНХ-д нийт оролцогчдын 7 хүрэхгүй хувь нь хорооны Засаг дарга томилох, чөлөөлөх, огцруулах, нэр дэвшүүлэх зэрэгт хэлэлцдэг гэж хариулсан нь С*1 асуултын үр дүнг бататгаж байна. Сүүлийн үед иргэн бүрт ноогдох 0.07 га газар өмчлөл болон дахин төлөвлөлтийн талаар асуудлууд хэлэлцжээ. ИТХ-ын төлөөлөгч, Засаг дарга нарын хэлснээр, ИНХ-ын үеэр иргэдээс баг/хороонд ямар ажил хийвэл зохих талаар санал хүсэлтийг эрэмбэлж жагсаасны дараа олон санал авсан хүсэлтийг шийдвэрлэх шатны ажил болгон хийдэг байна.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын жагсаалт гээд нэг санал авах хуудас явчихсан байдаг. Би маш олон удаа шүүмжлээд үр дүнд хүрээгүй. Гэхдээ ганц нэг үр дүнд хүрэх нь хүрсэн. Хүн харахад иргэдээсээ санал аваад байгаа хэрнээ агуулгын хувьд авахгүй байгаа. Хэсгийн ахлагч нь залхуурахаараа өөрсдөө бөглөөд өгдөг. Хэрэгжүүлэх шатан дээрээ алдаа гараад байгаа. Хяналтын систем сайжруулах иргэдийн оролцоог хангах үүднээс яг иргэнд юу тулгараад байгаа гэдгийг ялгаж заагалахгүй бол одоо жишээ нь гэр хорооллоос авч байсан асуулгаа байшин хорооллоос авсан болгож байна. Асар том гажуудал гараад байна.

***Чингэлтэй дүүрэг, 4-р хорооны ИТХ-ын төлөөлөгч***

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

Амьдарч байгаа орчинд асуудал байна. Манай гудманд тавьсан зам нарийхан, 2 жижиг машин зөрж болдоггүй. Мөн гэрэлтүүлэг байхгүй. гээд л асуудал их байдаг. Энэ асуудлыг хорооны иргэдийн хурлаар дамжуулаад дүүргийн ИТХ-д очих байх.

***Улаанбаатар хор, Налайх дүүргийн иргэн, эрэгтэй***

*Зураг 32. ИНХ-аар хэлэлцсэн асуудлууд, орон нутаг, хувиар*



Харин хөдөө орон нутагт иргэд жилийн болон улирлын тайлангийн хуралд идэвхтэй оролцдог болохыг тоон судалгааны үр дүнгээс харж болно. Харин хөдөө орон нутгийн иргэд Улаанбаатар хотын иргэдээс ОНХС-гийн талаар мэдээлэл цахимай байна. Хотын хурлаас онцлог нь гэвэл илүү малчид руу хандсан асуудлаар ярилцдаг байна. Хөдөө орон нутагт тариалан болон бэлчээрийн газар нутаг дээр маргаантай асуудал их гардаг байна. Мөн өвлийн бэлтгэл ажил өвөлжөө, хаваржаа, отрын бүс нутаг төлөвлөж гаргах гээд олон шийдвэрлэх асуудал байдаг. Хот, орон нутаг хоорондын авто замын харилцаа сүүлийн жилүүдэд сайжирч байгаа ч сумд хоорондын авто замын асуудлууд байсаар байна. Хөдөө орон нутагт ажлын байр дутагдалтай байгаа нь ард иргэдийн амьжиргаанд маш хүндээр нөлөөлж байна.

> *Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*
>
> Багийн ИНХ–аар хэлэлцээд шийдсэн багц ажлуудыг ОНХС-гаар батлагдсан мөнгөнд багтаагаад л хийдэг. Жишээ нь: Манай баг дээр 2 худаг гаргасан. Тэр чинь бүгд л багийн ИНХ–аар хэлэлцээд, иргэдээс гарч ирсэн саналын дагуу хийсэн ажил. Мөн улсын төсвийн 850 сая төгрөгөөр шинээр газар авсан тог, цахилгаангүй хэсгийг цахилгаанд холбосон. Иймэрхүү ажлуудыг өнгөрсөн 2 жилийн хугацаанд манай баг дээр хийж гүйцэтгэсэн байгаа.
>
> ***Дархан-Уул сум, Дархан сум Малчин багын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч***

**ИНХ-ын урилга, мэдээлэл ирвэл оролцох хандлага**

ИНХ-д оролцдоггүй нийслэлийн иргэдийн 48%, ороннутгийн иргэдийн 22% нь ямар ч мэдээлэл ирдэггүйн улмаас оролдоггүй гэж хариулсан байсан. Тэгвэл тэдэнд урилга мэдээлэл ирвэл хуралд оролцох хандлагыг харахад нийслэлийн иргэдийн 52% , ороннутгийн иргэдийн 70% нь ИНХ-д заавал оролцоно гэж хариулсан байна. Харин “цаг зав гарвал оролцохыг хичээнэ” гэж нийслэлийн иргэдийн 30% нь, орон нутгийн иргэдийн 18% нь хариулжээ. Мэдээлэл цуглуулах явцад мэдээлэл ирсэн ч оролцохгүй гэж хариулсан хүмүүсийн шалтгааныг тодруулахад оролцсон, оролцоогүй ялгаагүй, төрд итгэх итгэл алдарсан гэж хариулж байсан юм.

***Хүснэгт 48. Иргэдийн ИНХ-д оролцох цаашдын хандлага байршлаар, хувиар***

| Байршил | Заавал оролцоно | Цаг зав гарвал оролцохыг хичээнэ | Яаж ч магадгүй/ тухайн үеийн байдлаас болно | Оролцохгүй л болов уу | Огт оролцохгүй | Мэдэхгүй байна |
|---|---|---|---|---|---|---|
| **Улаанбаатар** | 51.8 | 29.8 | 12.0 | 4.0 | 1.8 | 0.6 |
| **Хөдөө орон нутаг** | 70.0 | 18.3 | 7.9 | 1.7 | 0.9 | 1.3 |

Чанарын судалгааны дүнгээс харахад иргэдэд тохиромжтой, завтай үед хурал зарлавал оролцоно гэжээ.

*Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс:*

*Хорооны тохижилт гэх мэт ойр зуурын асуудал байвал хуралд очно.*

***Улаанбаатар хот, БЗД-ийн иргэн, эмэгтэй***

*Амралтын өдрөөр эрт хийвэл хүмүүс бас очихгүй байх. Хурлыг хаана, хэзээ хийхээ зөв төлөвлөсөн байх хэрэгтэй. Хорооноос бид нарын төлөө ажиллаж байгааг мэдэж байгаа болохоор бас тэд нарын төлөө хуралд очно.*

***Улаанбаатар хот, СБ-ийн иргэд***

*4-р багийн иргэдийн хувьд ажилгүйдэл, ядуурал хамгийн их байгаа энэ талаар санал бодлоо илэрхийлэх хэрэгтэй. Миний хувьд ИНХ-д оролцоно.*

***Хөвсгөл аймгийн мөрөн сумын иргэн, эмэгтэй***

*ИНХ-ыг нээлттэй хийнэ гэвэл би заавал очно. Тэгээд надад үг хэлэх эрх өг гэж хэлнэ. Үг хэлнэ. Багийн хуралд байнга суудаг. Хурлын идэвх 1990 оноос хойш огцом буурч байна. Хоорондоо талцдаг үзэл бодол нь таарахгүй хүмүүс хурлын утга учрыг алдагдуулж байна. Ямарч хөгжилд ард иргэдийн оролцоо л хамгийн чухал. Жишээ нь: Герман улсаас тоног төхөөрөмж авч ирсэн. Гэтэл тэр тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хүчин байгаагүй. Тэгэхээр тоног төхөөрөмжөөс илүү хүний үнэмлэмжийг дээшлүүлэх хэрэгтэй.*

***Ховд аймгийн Булган сумын иргэд***

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

*Энэ жил иргэдийн оролцоог дэмжих жил болгож зарласан. Энэ жил дүүргийн хэмжээнд төвлөрсөн арга хэмжээний зардал гэж нэг тэрбум төгрөг төсөвлөж байна. Эндээс нилээд хувь нь иргэдийн оролцоог дэмжих хөтөлбөрт явах байх.*

***Улаанбаатар хот, ЧД-ийн ИТХ-ын төлөөлөгч, эрэгтэй***

***Хүснэгт 49. Иргэдийн ИНХ-д оролцох цаашдын хандлага, иргэдийн 2014 онд хуралд оролцож байсан хандлага, байршлаар, хувиар***

| Байршил | Оролцоно | Оролцохгүй | Нийт |
|---|---|---|---|
| **Улаанбаатар** | | | |
| Оролцож байсан | 29.7 | 0.2 | 100 |
| Оролцож байгаагүй | 63.6 | 6.4 | |
| **Хөдөө орон нутагт** | | | |
| Оролцож байсан | 58.2 | 0.9 | 100 |
| Оролцож байгаагүй | 38.9 | 1.9 | |

2014 онд ИНХ-д оролцсон иргэдийн цаашид хуралд оролцох хандлагыг тодруулбал, Улаанбаатар хотын хувьд 30%-тай бол, оронnутгийн иргэд 2 дахин илүү оролцох төлөвтэй байна. Харин хуралд оролцож байгаагүй Улаанбаатар хотын иргэд хөдөө орон нутгийн иргэдээс 25%-иар илүү оролцох хандлагатай байна.

## 3.6. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА



Иргэний оролцоо бол нутгийн өөрөө удирдах ёсны суурь юм. Хүний амьд байх, аюулгүй орчинд амьдрах хийгээд ажиллаж, хөдөлмөрлөх нийгэм соёлын үндсэн эрх орон нутагт хэрэгждэг. Орон нутаг бол хүн бүхний амьдралын анхдагч эх үүсвэрийг бүрдүүлэгч орчин юм. Орон нутгийнхаа асуудалд иргэд нь оролцож хамтын шийдвэр гаргах нь хүний жам ёсны эрхийг хангаж байгаа хэрэг юм. Үүнийг нутгийн өөрөө удирдах ёс гэж нэрлэдэг. Өөрөө удирдах ёс нь иргэдийн оролцоотой шийдвэрээр хэрэгждэг. Орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад иргэд, оршин суугчид, хэрэглэгчид, сонгогчид, сонирхлоороо нэгдсэн бүлэг болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн хэн гээд бүгд оролцох ёстой байдаг.

Энэхүү судалгааны явцад нутгийн өөрөө удирдлагын байгууллагын түвшин дэх иргэдийн оролцоо түүнтэй холбоотой асуудлуудын талаар иргэд, ИТХ-ын төлөөлөгчид, нутгийн удирдах албан тушаалтнуудын төлвийг тодруулан асуусан юм.

### *Орон нутгийн удирдлагаас иргэдийн оролцоог хангаж байгаа байдал*

Иргэдийн оролцооны түвшин сүүлийн жилүүдэд өсөх хандлага ажиглагдаж байна гэж ярилцлагад оролцсон ихэнх ИТХ-ын төлөөлөгч нутгийн удирдлагууд үзэж байна. Үүний шалтгааныг асуухад:

- Орон нутгийн төсвийг иргэд өөрсдөө захиран зарцуулах болсонтой холбоотойгоор хариуцлагатай хандах болсон;
- ИНХ тогтмол улирал тутам явагддаг болсон;
- “Иргэний танхим” нээгдсэн;
- Иргэд нэгдээд хоршоо бүлэг болоод төсөл бичээд хандсан тохиолдолд амьжиргаагаа дээшлүүлэх боломж урдныхаас илүү нэмэгдсэн;
- Иргэдийн сонирхлын бүлгээр нь нэгтгэж санал бодлыг нь сонсож байна гэх мэт шалтгааныг дурджээ.

Харин ИТХ-ын төлөөлөгчид болон нутгийн удирдлагууд шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог дараах аргаар хангаж байгаа ажээ. Үүнд:

- ИНХ-аас гарсан иргэдийн саналыг нэгтгэж эрэмбэлэх, нэгтгэсэн саналыг дээд шатны байгууллагад уламжлах;
- Иргэний танхимын хэлэлцүүлгийн үед гарсан иргэдийн саналыг нэгтгэж, эрэмбэлэх, нэгтгэсэн саналыг төлөөлөгчид болон удирдлагад уламжлах;
- Иргэдээс санал асуулга маягаар саналыг авах (*энэ нь хэсгийн ахлагчид болон хорооны идэвхтэн иргэдээр дамжигдан хийгддэг байна.);*
- Иргэдийн санал бодлыг авч холбогдох мэргэжилтэнд уламжилж ажилладаг нийгмийн бодлогыг хариуцсан хүнээр дамжуулан санал бодлыг нэгтгэх.

Дээрх төлөөлөгчдийн ярилцлагаас “Иргэний танхим” байгуулагдсан нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдтэйгээ тулж ажиллахад маш чухал нөлөө үзүүлж байгаа нь харагдаж байв.

***Иргэдийн оролцоог нэмэгдүүлсний давуу болон сул тал***

Иргэний оролцоог нэмэгдүүлэхийн давуу болон сул талыг оролцогчид дараах байдлаар тодорхойлсон байна.

***Хүснэгт 50. Иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр гарах үр нөлөө,ИТХ-ын төлөөлөгчид болон нутгийн удирдлагын хандлага***

| Эерэг хандлага | Сөрөг хандлага |
|---|---|
| • Гарсан шийдвэрүүд үр дүнтэй байна<br>• Иргэдэд хэрэгцээтэй шийдвэрийг гаргана<br>• Төлөөлөгчид илүү бодитой, иргэдтэйгээ ойр ажилладаг болно<br>• Иргэдийн амьдрах орчин нөхцөл, амьжиргаа сайжирна<br>• Иргэд өөрсдийн дэмжсэн ажлуудыг харах боломжтой<br>• Иргэдийн идэвх санаачлага, нутгийн удирдлагын байгууллагын талаарх ойлголт нэмэгдэнэ<br>• Төрийн үйлчилгээ зөв чиглэл рүүгээ явна | ▪ Дэндүү сул задгай болчихвол шийдвэр гаргахад хүндрэл үүсдэг<br>▪ Хэт жижиг ахуйн чанартай асуудлыг төр захиргаагаар шийдүүлэх тал нэмэгдэнэ<br>▪ Хүн болгон өөр өөр өнцгөөс хараад шийдвэр гаргах процесс удааширна<br>▪ Хүмүүс хэт улс төржөөд эхлэхээр хагарал үүснэ<br>▪ Төрийн бодлогод хүндрэл учирна |

Ганцаарчилсан ярилцлагын ихэнх оролцогчдын хувьд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй, иргэдийн оролцоо нэмэгдсэний сул тал байхгүй гэж үзжээ. Иргэдийн хувьд идэвхтэй өөрсдөө мэдээллээ хайгаад олж авдаг хэсэг байдаг боловч тэр нь маш бага хувийг эзэлдэг. Иргэдийн үлдсэн дийлэнх хувь нь хэнэггүй, хайнга хүмүүс байдаг. Тиймээс ИТХ-ын төлөөлөгчид, нутгийн удирдлагын байгууллагын хувьд олонхийн эрх ашгийг хамгаалах, түүнд нийцсэн шийдвэр гаргах үүднээс оролцоог дэмжсэн арга хэмжээг явуулах хэрэгтэй гэж үзэж байна.

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:*

Иргэдийн оролцоогүйгээр төр засгийн үйл ажиллагаа буруу тийшээ хандана гэдгийг бүх төлөөлөгч, төрийн албан хаагч ойлгох хэрэгтэй. Иргэдийн хандлагыг ч өөрчлөх хэрэгтэй. Иргэдээ соён гэгээрүүлэх, мэдээллийг олгох хэрэгтэй.

***Хөвсгөл аймаг, Тариалан сумын ИТХ-ын дарга***

Иргэдийн оролцоог заавал нэмэгдүүлж, дэмжиж байх ёстой. Иргэд гудамжаараа, багаараа, хамт олноороо тулгамдаж байгаа асуудлынхаа талаар хуралдаж асуудлаа шийдэх ёстой.

***Өвөрхангай аймаг, Арвайхээр сумын ИТХ-ын төлөөлөгч***

Иргэдийн оролцоо харьцангуй өсөх хандлагатай байна. Учир нь орон нутгийн төсвийг иргэд өөрсдөө захиран зарцуулах болсонтой холбоотой хариуцлагатай хандаж байна. Мөн нэг шалтгаан нь ИТХ-д тавьсан санал хүсэлтүүдийг шийдвэрлэж өгч байна. Тиймээс иргэдийн оролцоо, итгэл сайжирч байна. Иргэдийн оролцоог хангах үүднээс жишээ нь мод тарих аян, олон мод тарьсан хүнд тодорхой хэмжээний урамшуулал олгох, иргэдээс ирсэн саналын хүрээнд хэрвээ бодитой дэмжигдэх ажил байвал тодорхой хэмжээний урамшуулал өгч, саналыг ажил хэрэг болгох гэх мэт.

***Ховд аймаг, Жаргалант сумын ИТХ-ын төлөөлөгч***

Иргэдийн оролцоог нэмэгдүүлсний сул тал гэж байхгүй. Зөв чиглэлээр хөгжүүлэх хэрэгтэй. Жишээ нь залуучуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд сонирхлын бүлгүүдээр нь дамжуулан ажиллах ч юмуу, сонирхол нэгтэй хүмүүсийг нэгтгэж санал хүсэлтийг нь сонсох гэх мэт байдлаар

***Улаанбаатар хот, БЗД-ийн Засаг дарга***

Харин иргэдийн хувьд нутгийн удирдлагын байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцох иргэдийн оролцоо нь дараах давуу болон сул талтай хэмээн үзжээ.

*Хүснэгт 51. Иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр гарах үр нөлөө, иргэдийн хандлага*

| Эерэг хандлага | Сөрөг хандлага |
|---|---|
| • Авилга хээл хахуулийн асуудал багасна<br>• Хууль дүрмийн хэрэгжилт сайжирна<br>• Иргэд амьдрал ахуйгаа дээшлүүлэх боломжтой болно<br>• Нутаг орны хөгжил сайжирна<br>• Шийдвэрүүд бодит амьдралтай илүү ойр болно | • Хүн бүр хувийн ашиг сонирхлыг шийдүүлэх гэж зүтгэнэ<br>• Сэтгэл хөөрлөөр хандах хандлага ихсэнэ |

Иргэдийн нэгэн адил нутгийн удирдлагын зүгээс ч шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог дэмжих шаардлагатай гэж үзэж байна. Гэвч тэд жил ирэх тутам иргэдийн оролцооны түвшин буурч, ялангуяа залуучуудын оролцоо маш муу байгааг дурдаж байна. Үүнийг одоогийн зах зээлийн нийгмээс гадна иргэдийн төрд итгэх итгэл алдарсантай холбон тайлбарлаж байна.

ИТХ-ын төлөөлөгчдийн хувьд иргэдийн оролцоог бүх талаар хангахын тулд дэмжин ажиллаж байгаа гэсэн боловч иргэдийн хувьд тэднийг шийдвэр гаргахад оролцуулах хувь маш муу байгаа гэжээ. ИНХ-д оролцдог хэдэн хүмүүсээс л санал авдаг, гэвч тэр санал нь цаанаа очоод хэрэгждэг эсэх нь тодорхой бус, эргээд иргэдэд хариу өгдөггүй гэх мэтээр шүүмжлэлтэй байр суурийг илэрхийлж байсан юм.

## 3.7. ДҮГНЭЛТ

Үндсэн хуулийн институци болох аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн орон нутгийн Засаг даргыг сонгоход чухал үүрэг гүйцэтгэж, орон нутгийн гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа буюу орон нутгийн төсвийн гүйцэтгэл, төрийн үйлчилгээнд *хяналт тавих,* нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэдээс гарсан саналыг орон нутгийн бодлого, төсөв, төлөвлөлтөд шударгаар тусгах, үйлчилгээний талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлэх, төр засаг болон нутгийн удирдлагын үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх зэргээр *иргэдийг төлөөлөх* үүрэгтэй, иргэдийн хувьд хамгийн ойр дөт байх учиртай байгууллага юм.

Харин нутгийн өөрөө удирдах ёсны эдгээр байгууллагыг иргэд хэрхэн ойлгож, итгэл үзүүлж, үйл ажиллагаанд нь хэр идэвхтэй оролцдог болохыг тодруулах зорилгоор "Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох" судалгааг хийж гүйцэтгэлээ. Уг судалгаа нь энэ чиглэлээр үндэсний хэмжээнд хийгдсэн анхны судалгаа байснаараа онцлогтой юм.

Судалгааны гол дүнг тоймлон харуулбал:

**Иргэдийн сонгуулийн идэвх болон сонгуулийн тогтолцооны талаарх санаа бодол**

Сонгуулийн хууль болон сонгуулийн тогтолцоо нь орон нутгийн **төлөөллийн чанарт** ихээхэн нөлөөтэй байдаг. Сонгуулийн тухайн тогтолцоо том намуудад давуу байдал олгох эсвэл тодорхой бүлгүүдийг гадна үлдээх эсвэл намуудын эрх мэдлийн шатлалыг дэмжсэн хэлбэртэй байж болдог. Иймд сонгуулийн тогтолцооны талаар иргэд тодорхой ойлголттой байх нь чухал ач холбогдолтой.

- Одоогийн сонгуулийн тогтолцооны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, мэдээлэл маш тааруу байгаа нь судалгаанд оролцсон 5 хүн тутмын 1 нь орон нутгийн сонгуулийн холимог тогтолцоо оновчтой эсэх талаар ямар нэгэн санал бодол хэлж мэдэхгүй байгаагаас харагдаж байна.
- Иргэдийн тал хувь нь сонгуулийн холимог толтолцоог оновчтой бус гэж үзэж байна.
- Иргэдийн 57% нь тойргоос сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчид тэднийг төлөөлж чадна гэж үзэж байгаа бол 27% нь жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид тэднийг төлөөлж чадна гэж үзэж байна. Энэ дүнг хот, хөдөөгөөр ялган авч үзвэл УБ хотын иргэдийн 48.8%, хөдөөгийн иргэдийн 62.6% тойргоос сонгогдсон төлөөлөгчдөд итгэл үзүүлж байна.

Сонгуулийн ирц нь тухайн институцэд иргэдээс үзүүлж буй итгэлийг илэрхийлэх нэг үзүүлэлт юм.

- Иргэд, ялангуяа Улаанбаатар хотын иргэд орон нутгийн сонгуульд УИХ-ын сонгуулиас бага ач холбогдол өгч байна.
- Орон нутгийн сонгуулийн ирц муу байгаа шалтгааныг УИХ-ын Ерөнхийлөгчийн сонгуультай харьцуулахад төсөв хөрөнгө бага байдгийн улмаас мэдээлэл муу хүрдэг, хүйтний улиралд өвлийн бэлтгэл гэх мэт их ажлын үеэр явагддаг, өмнө нь сонгууль болсон учраас залхсан байдаг, ерөнхийдөө иргэдийн төрд итгэх итгэл буурсан зэрэгтэй холбон тайлбарлаж байлаа.
- Иргэдийн 90 гаруй хувь нь 2016 оны сонгуульд оролцоно хэмээн хариулжээ.

- ИТХ иргэдийн хувьд ямар ач холбогдолтой байгууллага болох, төлөөлөгч ямар үүрэгтэй байдаг, өдөр тутмын амьдралтай холбоотой асуудал тулгарвал хэнд хандаж шийдвэрлүүлэх талаар иргэдийн мэдлэг ерөнхийдөө хомс байна.
- Иргэд сонгосон төлөөлөгчөөр дамжуулан шийдвэр гаргахад оролцох, үзэл бодлоо илэрхийлэх гэхээсээ илүү 4 жилд 1 удаа сонгуульд оролцоно гэсэн байдлаар хандах нь элбэг байна.

**ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, үнэлгээ**

Нийт иргэдийн нутгийн өөрөө удирдах байгууллага, төлөөллийн ардчиллын талаарх ойлголт, мэдлэг, мэдээлэл маш муу байна.

- Нийт иргэдийн талаас илүү хувь нь ИТХ-ын талаар огт ойлголтгүй, Улаанбаатар хотын иргэдийн 30 гаруй хувь, хөдөөгийн иргэдийн 70 гаруй хувь нь ийм байгууллага байдаг эсэхийг ч мэдэхгүй байна. Тэр тусмаа ИТХ нь нийслэл ба дүүрэг, аймаг ба сум гэсэн шатлалтай талаар ойлголт бүр ч дутмаг байв.
- ИТХ-ын талаар тодорхой мэдлэгтэй иргэдийн хувьд ард иргэдийн төлөөлөл болж сонгогдсон төлөөллийн байгууллага, тэдний санал хүсэлтийг авч холбогдох газруудад уламжлан шийдвэрлэж өгдөг байгууллага, төр ба иргэдийг холбох гүүр гэсэн ерөнхий ойлголтыг нийтлэг дурдсан боловч иргэдийн дунд хууль баталдаг, үйлчилгээ үзүүлдэг, улс төрийн оролцоог нэмэгдүүлдэг байгууллага гэх мэт УИХ, гүйцэтгэх засаглал, улс төрийн намуудын үүрэгтэй андуурсан ташаа ойлголтыг нэрлэх нь цөөнгүй байна.
- Иргэдийн тал хувь нь иргэдтэй тогтмол холбоотой ажиллаж, тэдний өргөдөл, санал гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх эрх бүхий байгууллага хэмээн ИТХ-ын үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийг нэрлэж байна.
- ИТХ-ын гаргасан шийдвэрийг нэрлүүлэхэд нүдэн дээр хийгдэж буй бүтээн байгуулалт, амьдралд нь нөлөөлж буй тогтоол, шийдвэрүүдийг нэрлэж байв.
- Тухайн шатны ИТХ нь орон нутагт хуваарилагдсан төсвийг хуваарилж, зарцуулалтад хяналт тавьдаг болохыг иргэдийн маш цөөн хувь нь мэдэж байна. Харин ИТХ-ын төлөөлөгчид орон нутгийн төсвийг батлах, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуваарилах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, бодлогын баримт бичиг батлах гэх мэт шийдвэрүүдийг нийтлэг дурдаж байв.
- Иргэдийн цөөн хувь нь ИТХ-ыг ажил хийдэггүй цалин авдаг хүмүүс байдаг, мөнгө иддэг байгууллага гэх мэт сөрөг ойлголттой байлаа. Нийслэлийн иргэдэд ийм сөрөг ойлголт орон нутгийн иргэдийх өндөр байна.
- ИТХ-ын үйл ажиллагаанд “маш сайн” хэмээн үнэлгээ өгсөн иргэд ил тод, нээлттэй болсон, хийсэн ажил нь нүдэнд харагдаж, амьдралд нөлөөлж байгаа, олон нийтэд мэдээлэл сайн өгдөг гэсэн шалтгааныг дурдсан бол “маш муу” хэмээн үнэлгээ өгсөн иргэд иргэдтэйгээ уулздаггүй, мэдээлэл өгдөггүй, иргэдийн амьдралыг бодитой сайжруулах зүйл хийдэггүй гэсэн шалтгааныг дурдсан байна.

**ИТХ-ын талаар мэдээлэл авдаг суваг**

- Иргэд ИТХ-ын талаарх мэдээллийг орон даяар цацагддаг болон тухайн орон нутгийнхаа телевизээс хамгийн их авч байна.

- ИТХ-ын талаарх мэдээллийг нийслэлийн иргэд орон даяар цацагддаг телевиз, хорооноос хамгийн их авч байхад орон нутгийн иргэд орон нутагтаа гардаг телевизийн сувгууд болон хурал уулзалтын үеэр хамгийн их авдаг байна.
- Иргэдийн 4 хүн тутмын 1-д нь нутгийн удирдлагын байгууллагуудаас ямар нэгэн мэдээлэл өгөх, өөрсдийн үйл ажиллагааг тайлагнах зорилготой хэвлэмэл материал ирж байсан байна.
- Иргэдийн хувьд гэрт нь ямар нэгэн хэвлэмэл материал ирэхэд 4 хүн тутмын 3 нь уг мэдээллийг уншиж, танилцаж байгаа бол үлдсэн 1 нь ирсэн ч уншиж танилцдаггүй бөгөөд энэ төрлийн мэдээ, материалаас залхсан, итгэл алдарсан учраас уншихгүй гэж үзэж байна.
- Залуучууд хэвлэмэл материалыг уншиж танилцах сонирхол маш бага байна.

Иргэдэд ИТХ-ын талаарх мэдлэг, мэдээллийг олгох зорилготойгоор ажиллуулж байгаа www.khural.mn цахим хуудсын талаар 4 хүн тутмын 1 нь сонссон ч тэдний өчүүхэн хувь нь уг цахим хуудсаар зочилжээ.

**ИТХ-ын төлөөлөгчдийн талаарх иргэдийн санаа бодол**

- Судалгаанд оролцогчдын 1/3 нь өөрийн тойргоос аймаг/ нийслэлийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгч хэмээн нэрлэснээс 15.8% төлөөлөгчдөө зөв нэрлэжээ. Төлөөлөгчөө зөв нэрлэж буй хувь ороннутагт нийслэлээс даруй 5 дахин өндөр байлаа.
- Сум/дүүргийн төлөөлөгчдөө зөв нэрлэсэн хувь аймаг/ нийслэлийнхээс арай өндөр байв.
- Ийнхүү төлөөлөгчдөө сайн мэдэхгүй байгаа нь нэгдүгээрт тухайн аймаг, сум, дүүргийн хүн амын тоо, нягтралаас ихээхэн хамаарч байна. Нийслэл хотын сонгуулийн тойргийн хэмжээ ороннутагтай харьцангуй маш том байдаг учраас нэг төлөөлөгч төрөл бүрийн бүлгийн санаа бодлыг төлөөлөх боломжгүй, түүнд иргэдтэй харьцахад захиргааны анхан шатны байгууллагын тусламж шаардлагатай болдог. Энэ байдал судалгааны дүнгээр батлагдсан бөгөөд иргэд асуудал тулгарах, санал гомдол гарсан тохиолдолд ИТХ-ын төлөөлөгч гэхээсээ баг/хорооны Засаг даргад илүүтэй байна.
- 2012 оны орон нутгийн сонгуулиас хойш 2 жил гаруй хугацаа өнгөрч байхад иргэдийн 10% нь л өөрийн тойргоос сонгогдсон төлөөлөгчтэй ямар нэгэн асуудал, санал, хүсэлт тавьж холбогджээ. Харин төлөөлөгчтэйгөө холбогдоход, биечлэн уулзахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл учирдаггүй хэмээн иргэдийн дийлэнх нь үзжээ.
- Жирийн иргэд гэлтгүй судалгааны багийнхан нийслэлийн болон ороннутгийн төлөөлөгчдийг аль баг/хороог төлөөлж буй талаарх мэдээллийг олж авахад тун хүндрэлтэй байсан юм.

**Баг/хорооны Хурлын талаарх ойлголт, мэдлэг, оролцоо**

Иргэд баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хурал болон баг/хорооны ИНХ-д оролцох оролцоо, идэвх муу байна.

- Баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх ИНХ-д оролцох иргэдийн оролцооны хувьд нийслэл хотын иргэд ороннутгийн иргэдээс 40 орчим хувиар бага байгаа нь хурлын талаар мэдээлэл авч чаддаггүйтэй холбоотой байна. Харин иргэдийн дийлэнх нь баг/хорооны Засаг дарга болон түүний бие төлөөлөгчөөс хурлын товын мэдээлэл авдаг байна.

- Баг/хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд оролцсон иргэдийн дийлэнх нь 2014 онд ИНХ-д ядаж 1 удаа оролцсон байна.
- Оронnутгийн иргэд нийслэлийн иргэдтэй харьцуулахад ИНХ-д оролцох давтамж өндөр байна.
- Иргэд ИНХ-д оролцох оролцоо муу байгаа учраас хурлаар хэлэлцдэг асуудлын талаарх ойлголт, мэдлэг мөн тааруу байна.
- ИНХ-аар хамгийн их давтамжтай хэлэлцдэг асуудалд Улаанбаатар хотын хувьд тохижилт, тэр дундаа хог хаягдал, золбин нохой, худаг усны асуудал хэмээн нэрлэсэн бол Орон нутгийн хөгжлийн сангийн талаар иргэдийн ойлголт тааруу байна.
- Харин орон нутгийн иргэд ИТХ-ын үйл ажиллагааны тайлан, орон нутгийн хөгжлийн сангийн талаарх хэлэлцдэг хуралд ихэвчлэн оролцдог байна.
- Залуучууд баг/хорооны ИНХ-д оролцдоггүй байдал энэ талаарх мэдээллээс улам хоцорч, мэдлэггүй болоход хүргэж байна.
- Цаашид ИНХ-д оролцох төлөвийг харахад өмнө нь хуралд оролцож байгаагүй иргэдийн тал хувь нь цаашид ИНХ-д оролцоно байгаа нь энэхүү судалгааны явцад ИНХ-ын талаар багагүй мэдээлэл өгсний үр дүн гэж үзэж болохоор байна.
- Иргэдэд ИНХ-ын талаарх мэдээллийг хэвлэмэл материалаар тараахаас илүү утас, мессэж, гудамжинд байрлуулсан зараар хүргэх нь хүртээмжтэй байх ч насны онцлогт тохирох сувгаар хурлын товыг хүргэвэл бүх насныхныг хамруулах боломжтой хэмээн иргэд үзэж байна.

**Нутгийн өөрөө удирдах байгууллага дахь иргэдийн оролцоо, цаашдын чиг хандлага**

- Орон нутгийн төсвийг өөрсдөө захиран зарцуулдаг болсон, Иргэний танхимтай болсон, иргэд төсөл бичээд жижиг дунд үйлдвэрийн зээлд хамрагдах болсон зэрэг олон зүйлээс хамаарч сүүлийн жилүүдэд иргэдийн оролцоо өсөх хандлагатай болсон. Гэхдээ нутгийн удирдлагын шийдвэр гаргах ажиллагаанд залуучуудын оролцоо маш муу байгааг иргэд, ИТХ-ын төлөөлөгчдын аль аль нь тэмдэглэх байна.
- НӨУБ-ын шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр төлөөлөгч, Засаг дарга нар иргэдтэй ойр дотно ажиллах боломж нэмэгдэх, гарсан шийдвэрүүд бодитой, үр дүнтэй байх, иргэдийн идэвх нэмэгдэх, иргэдийн аж амьдрал сайжрах эерэг нөлөөтэй бол хэт жижиг асуудлаар шийдвэр гаргах, шийдвэр гаргах явц удаашрах, хэт улс төржсөнөөс болж хагарал үүсэх сул талтай хэмээн иргэд үзжээ.

# ХАВСРАЛТ

## СУДАЛГААНД ХАМРАГДСАН ОРОН НУТГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Энэ бүлэгт судалгааны түүвэрт хамрагдсан бүс нутгийн төлөөлөл болох 5 аймгийн 15 сумын хүн ам зүй, нийгэм эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлыг нэгтгэн харуулсан болно.

### Дархан-Уул аймаг

Монгол орны аж үйлдвэрийн томоохон төв болох Дархан хотыг УИХ-ын 1994 оны 32 дугаар тогтоолоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Дархан-Уул аймаг болгон өөрчилсөн бөгөөд тус аймаг 4 сумтай.

***Хүн ам зүйн мэдээлэл***

Дархан-Уул аймгийн хүн амын тоо 2013 оны эцсийн байдлаар 99.0 мянга болж, өмнөх оныхоос 1.1%-иар, 1989 оныхоос 15.5%-иар өсчээ. Аймгийн хүн амын 20.5% нь хөдөөд, 79.5% нь хотод амьдарч байна.

*Хүснэгт 52. Дархан-Уул аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн*

| Байршил | 1989 | 2000 | 2010 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 85.7 | 83.3 | 94.9 | 97.9 | 99.0 | 99.4 |
| Үүнээс: Аймгийн төв | 85.7 | 65.8 | 78.5 | 77.2 | 78.7 | - |
| Хөдөөгийн | 0 | 17.5 | 16.4 | 20.7 | 20.3 | - |
| Сонгогдсон сумын хүн амын тоо | | | | | | |
| Дархан | 63.2 | 65.8 | 74.9 | 71.8 | 76.4 | - |
| Хонгор | 5.2 | 5.5 | 4.9 | 5.7 | 5.7 | - |
| Шарын гол | 9.3 | 8.7 | 7.8 | 8.1 | 8.1 | - |

2013 онд аймгийн нийт өрхийн тоо 27.9 мянга болж, өмнөх оныхоос 6.4 хувиар өссөн байна. Нэг өрхийн ам бүлийн тоо Улсын дундаж 3.8 байхад, аймгийн дунджаар 3.4 буюу 0.4 пунктээр бага үзүүлэлттэй байна. Хүн амын нягтаршилаар нь авч үзвэл, улсын дунджаар 1км$^2$ нутаг дэвсгэрт ноогдох хүн ам 1.9 байхад, Дархан суманд 748.3 хүн, Шарын гол суманд 84.8, Хонгор суманд 2.2 хүн ногдож байна.

Улсын хэмжээнд сонгуулийн насны хүн ам нийт хүн амын 67.6%-ийг эзэлж байхад энэ үзүүлэлт Дархан суманд 69.3%, Хонгор суманд 66.0%, Шарын гол суманд 66.9%-тай байна.

***Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал***

Дархан-Уул аймаг нь Монгол Улсын томоохон аж үйлдвэрийн төв юм. Дэд бүтэц сайн хөгжсөн, Улаанбаатар-Алтанбулагийн чиглэлийн олон улсын авто зам, Улаанбаатар-Сүхбаатарын олон улсын төмөр замын зангилаан дээр оршдог, төвийн эрчим хүчний системд холбогдсон, өндөр хурдны шилэн кабель, тоон системийн радио релейны шугам, хөдөлгөөнт холбооны үйлчилгээтэй, бусад аймагтай харьцуулбал нийтийн найдвартай, тогтмол хямд тээврийн хэрэгсэлтэй зэрэг давуу талтай.

Дархан-Уул аймгийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдал 2013 онд өмнөх онуудтай харьцуулахад сайжирсан байна. Тухайлбал, аймгийн 2013 онд нийт үйлдвэрлэл 580.1 тэрбум төгрөг, үүнээс дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 303.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 17.6%-иар өссөн байна. Аймгийн ДНБ-ий 13.3%-ийг хөдөө аж ахуй, 39.7%-ийг аж үйлдвэр, барилга, 16.7%-ийг бусад үйлчилгээний салбар эзэлж байна. Мөн Дархан-Уул аймаг улсын ДНБ-ий 1.6%-ийг бүрдүүлж байна.

***Улс төрийн нөхцөл байдал***

Дархан-Уул аймгийн Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 1993 онд 91.3% буюу хамгийн сайн байсан бол, 2009 онд 80.3% болж 11%-иар, 2013 онд 63.7% болж 16.6%-иар тус тус буурсан байна. 2013 онд АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж 50.0%-ийн санал авсан буюу МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнээс 7.9%-иар илүү саналаар ялалт байгуулжээ.

УИХ-ын сонгуульд оролцох сонгогчдын ирц 1992 онд 92.4% буюу хамгийн өндөр байсан бол 2008 онд 80.6% болж 11.9%-иар, 2012 онд 66.6% болж, 14.0%-иар тус тус буурсан байна. 2012 онд С.Ганбаатар бие даан нэр дэвшиж 53.8%-иар, Д.Хаянхярваа МАН-аас нэр дэвшиж 29.6%-иар сонгогдсон байна.

2012 онд Дархан-Уул аймгийн ИТХ-д нийт 33 төлөөлөгч ажиллаж байгаагаас 21 нь буюу 60 гаруй хувь АН-аас, үлдсэн хувь нь МАН-аас сонгогдсон байна. Дархан-Уул аймгийн ИТХ-ын 10 тэргүүлэгчийн 5 нь тойргоос, 5 нь жагсаалтаар сонгогдсон бол, үлдсэн 23 төлөөлөгчдийн 16 нь тойргоос, 7 нь намын жагсаалтаар сонгогдон ажиллаж байна. Дээр дурьдсанчлан УИХ-ын сонгуулиар бие даан нэр дэвшигч болон МАН-ын нэр дэвшигч ялалт байгуулсан бол орон нутгийн сонгуулиар АН дийлэнх суудлыг авсан байна.

***Дархан сум***

Дархан сум нь аймгийн төвийн сум бөгөөд 16 багт хуваагддаг. ИТХ-д нийт 31 хүн төлөөлөгч сонгогдон ажиллаж байгаагаас 21 нь тойргоос сонгогдож, үлдсэн 10 нь намын жагсаалтаар гарч ирсэн. Нийт төлөөлөгчдөөс 18 нь МАН-аас, 11 нь АН-аас, 2 нь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс сонгогдсон байна.

***Шарын гол сум***

Шарын гол сум нь аймгийн төвөөс 70 км, Улаанбаатар хотоос 210 км-т оршдог, нийт 3 багтай. ИТХ-д нийт 27 төлөөлөгч сонгогдсоноос МАН-аас 18, Ардчилсан намаас 8, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс 1 төлөөлөгч тус тус сонгогдон ажиллаж байна.

***Хонгор сум***

Хонгор сум нь аймгийн төвөөс 13 км зайд оршдог, нийт 3 багтай. ИТХ-д нийт 27 төлөөлөгч сонгогдон ажиллаж байгаагаас МАН-аас 17, Ардчилсан намаас 9, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс 1 төлөөлөгч тус тус ажиллаж байна.

### Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймгийн төвийг 1934 онд одоогийн Арвайхээр хотод төвлөрүүлж, 1942 оноос одоогийн Баянхонгор аймгийн зарим сумдыг Архангай, Завхан аймгуудад шилжүүлэн, Архангай аймгаас одоогийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Бүрд, Баян-Өндөр, Төв аймгийн Эрдэнэсант сумдыг нэгтгэн шинэчлэн зохион байгуулжээ. Тус аймаг нь 19 сум, 108 багтай. Нутаг дэвсгэрээрээ төдийгүй хүн ам, малын тоогоор

улсдаа томоохон аймгийн тоонд ордог.

### *Хүн ам зүйн мэдээлэл*

Өвөрхангай аймгийн хүн амын тоо 2013 оны эцсийн байдлаар 101.6 мянга болж өмнөх оныхоос 0.5 мянган хүнээр буурсан боловч 1989 оноос хойш 5.1 мянган хүнээр өсчээ. 2010 оны тооллогоос харахад хүн амын 74.5% нь хөдөөд, 25.5% нь хотод амьдарч байна.

*Хүснэгт 53. Өвөрхангай аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн*

| Байршил | 1989 | 2000 | 2010 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 96.5 | 111.4 | 101.4 | 102.1 | 101.6 | 111.9 |
| Үүнээс: Аймгийн төв | 30.0 | 19.1 | 38.4 | 24.6 | 25.9 | - |
| Хөдөөгийн | 66.5 | 92.4 | 63.0 | 77.5 | 75.7 | - |
| Сонгогдсон сумдын хүн амын тоо | | | | | | |
| Арвайхээр | 17.5 | 19.0 | 27.2 | 28.7 | 29.9 | - |
| Хархорин | 11.3 | 13.9 | 10.8 | 12.6 | 12.6 | - |
| Гучин-Ус | 2.4 | 2.3 | 1.7 | 2.2 | 2.1 | - |

Тус аймгийн хүн амын тоо 2014 онд 2013 оныхоос 10.3 мянган хүнээр өссөн байгаа бол хамгийн олон хүн амтай сум нь 12.6 мянган хүнтэй Хархорин, хамгийн цөөн хүнтэй сум нь 2.1 мянган хүнтэй Гучин-Ус сум юм.

2013 онд аймгийн нийт өрхийн тоо 32.4 мянга болж, өмнөх оныхоос 1.09 хувиар өссөн байна. Нэг өрхийн ам бүлийн тоо аймгийн дунджаар 3.4 буюу улсын дунджаас 0.4%-иар бага байна. Өрхийн хүн амын тоо жил бүр буурч байгаа боловч Гучин-Ус суманд аймгийн дунджаас их буюу 3.5-3.8 байна.

Хүн амын нягтаршилаар нь авч үзвэл, 1 $км^2$ нутаг дэвсгэрт ноогдох хүн ам Арвайхээр суманд 611.05 хүн, Хархорин суманд 5.46, Гучин-Ус суманд 0.46 байна. Сонгуулийн насны хүн ам Арвайхээр суманд нийт хүн амын 67.2%, Хархорин суманд 67.0%, Гучин-Ус суманд 64.1%-ийг тус тус эзэлж байна.

### Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал

Аймгийн хөгжилд хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдэж сүүлийн 2 жилд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 22 тэрбум төгрөг, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 8 гаруй тэрбум төгрөгт хүрч, их бүтээн байгуулалтын ажлууд нь иргэдийн орон нутагтаа тав тухтай ажиллаж амьдрах орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

2013 оны байдлаар нийт үйлдвэрлэл 451.5 тэрбум төгрөг, үүнээс ДНБ 291.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 41.1% буюу 85.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн ДНБ-ны 52.9%-ийг хөдөө аж ахуй, 13.9%-ийн аж үйлдвэр, барилга, 16.3%-ийг бусад үйлчилгээний салбар эзэлж байна. 2013 онд Улсын ДНБ-ий 1.5%-ийг тус аймаг бүрдүүлж байсан бөгөөд энэ тоо өмнөх оныхоос 0.3% өссөн байна.

### Улс төрийн нөхцөл байдал

Өвөрхангай аймгийн Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 1993 онд 95.0% байсан бол, 2009 онд 66.1%, 2013 онд 63.7% болж буурсан байна. 2013 оны сонгуулиар АН-

аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж 46.1%-ийн санал авч МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнээс 0.45%-иар илүү санал авч ялалт байгуулжээ.

УИХ-ын сонгуульд оролцсон сонгогчдын ирц 1992 онд 96.9% буюу хамгийн өндөр байсан бол 2008 онд 78.0% болж, 2012 онд 70.4% болж буурчээ. 2012 оны УИХ-ын сонгуулиар АН-аас нэр дэвшсэн Г.Батхүү, Д.Зоригт нар тус бүр 40.4%, 34.0%-ийн саналаар сонгогдсон байна.

Өвөрхангай аймгийн ИТХ-д 2012 онд нийт 33 төлөөлөгч сонгогдон ажиллаж байгаагийн 10 нь тэргүүлэгч, үлдсэн 23 төлөөлөгчдийн 16 нь тойргоос 7 нь намын жагсаалтаар гарч ирсэн байна. Нийт төлөөлөгчдийн 16 нь АН-аас, 24 нь МАН-аас, 1 төлөөлөгч МАХН-МҮАН-ын Шудрага ёс эвслээс сонгогдсон. УИХ-ын сонгуулиар АН ялалт байгуулсан бол орон нутгийн сонгуулиар дийлэнх суудлыг МАН авсан байна.

***Арвайхээр сум***

Арвайхээр нь аймгийн төвийн сум бөгөөд Улаанбаатар хотоос 430 км зайд оршдог, нийт 9 багтай. ИТХ-д нийт 31 хүн төлөөлөгч сонгогдсоноос 21 нь тойргоос, 10 нь намын жагсаалтаар сонгогдон ажилладаг. Үүнээс МАН-аас 22, Ардчилсан намаас 8, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс 1 төлөөлөгч гарч ирсэн байна.

***Хархорин сум***

Хархорин сум нь аймгийн төвөөс 138 км, Улаанбаатар хотоос 343 км зайд оршдог, нийт 8 багтай. ИТХ-д нийт 31 хүн төлөөлөгч сонгогдсоноос, 21 нь тойргоос, 10 нь намын жагсаалтаар сонгогдсон. Үүнээс МАН-аас 7, АН-аас 23, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс 1 төлөөлөгч сонгогдсон байна.

***Гучин-Ус сум***

Гучин-Ус нь Улаанбаатар хотоос 516 км, аймгийн төвөөс 104 км-ын зайд оршдог, нийт 4 багтай сум юм. ИТХ-д нийт 21 төлөөлөгч сонгогдоноос 14 нь тойргоос, үлдсэн 7 нь намын жагсаалтаар сонгогдсон бөгөөд нийт төлөөлөгчдийн 12 нь МАН-аас, 9 нь АН-аас тус тус сонгогдсон байна.

## Хөвсгөл аймаг

Хөвсгөл аймаг 1931 онд Улсын Бага Хурлын шийдвэрээр 107.2 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрт 24 сум, 17431 өрхийн 69206 хүн амтай, 1.2 сая гаруй толгой малтай байгуулагдсан Монгол улсын ууган аймгуудын нэг юм. Одоо уг аймаг 24 сум, 126 багтай.

**Хүн ам зүйн мэдээлэл**

Хөвсгөл аймгийн хүн амын тоо 2013 оны эцсийн байдлаар 118.8 мянга болж өмнөх оныхоос 1.0% буюу 1.2 мянган хүнээр, 1989 оныхоос 17.0 мянган хүнээр өсчээ. 2013 оны жилийн эцсийн байдлаар хүн амын 67.3% нь хөдөөд, 32.7% нь хотод амьдарч байна.

*Хүснэгт 54. Хөвсгөл аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн*

| Байршил | 1989 | 2000 | 2010 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 101.8 | 119.1 | 114.9 | 117.6 | 118.8 | 126.0 |
| Үүнээс: Аймгийн төв | 30.0 | 31.5 | 38.6 | 36.8 | 38.8 | - |
| Хөдөөгийн | 71.8 | 87.6 | 76.3 | 80.8 | 80.0 | - |
| **Сонгогдсон сумын хүн амын тоо** | | | | | | |
| Мөрөн | 22.4 | 28.9 | 35.8 | 36.0 | 38.2 | 36.9 |
| Эрдэнэбулган | 2.5 | 2.7 | 2.4 | 2.7 | 2.7 | 2.8 |
| Тариалан | 5.4 | 6.1 | 5.1 | 5.9 | 5.8 | 5.7 |

Тус аймгийн хүн амын тоо 2014 онд 2013 оныхоос 7.2 мянган хүнээр өссөн байна. Улсын дунджаар нэг сум 3.0 мянган хүн амтай, 4.7 мянган км$^2$ нутаг дэвсгэртэй байгаа бол Хөвсгөл аймгийн нэг сум дунджаар 3.8 мянган хүнтэй, 4.4 мянган км$^2$ нутаг дэвсгэртэй байна.

2013 онд аймгийн нийт өрхийн тоо 36.7 мянга болж өмнөх оныхоос 3.6%-иар өссөн байна. Нэг өрхийн ам бүлийн тоо аймгийн дунджаар 3.89 буюу улсын дунджаас 0.09 пунктээр өндөр байна. Манхан суманд нэг өрхөд ногдох ам бүлийн тоо 3.9-4.45 хүн байгаа бол, Жаргалант суманд аймгийн дунджаас бага буюу 3.63-3.87 байна.

Хүн амын нягтаршилаар нь авч үзвэл Мөрөн суманд 1 км$^2$ нутаг дэвсгэрт 372.0 хүн, Эрдэнэбулган суманд 0.554 хүн, Тариалан суманд 1.69 хүн ногдож байна. Мөрөн сумын нийт хүн амын 70.1%, Эрдэнэбулган сумын нийт хүн амын 67.1%, Тариалан сумын хувьд 67.5%-ийг тус тус сонгуулийн насны хүн ам эзэлж байна.

**Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал**

2013 оны байдлаар тус аймгийн нийт үйлдвэрлэл 572.1 тэрбум төгрөг, үүнээс ДНБ 367.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 27.0% буюу 78.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн ДНБ-ий 50.9%-ийг хөдөө аж ахуй, 17.5%-ийн аж үйлдвэр, барилга, 13.8%-ийг бусад үйлчилгээний салбар эзэлж байна. Улсын ДНБ-ий 1.5%-ийг Хөвсгөл аймаг бүрдүүлж байна.

**Улс төрийн нөхцөл байдал**

Өвөрхангай аймгийн Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 1993 онд 93.8% байсан бол, 2009 онд 67.9%, 2013 онд 64.2% болж буурсан байна. 2013 оны сонгуулиар АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж 62.3%-ийн санал авч ялалт байгуулсан бөгөөд энэ нь МАН -аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнээс 12.0%-ийн саналаар илүү байжээ.

УИХ-ын сонгуулийн ирц 1996 онд 93.4% байсан бол 2008 онд 76.9%, 2012 онд 68.7% болж өмнөх сонгуулиас 8.2%-иар буурсан байна. 2012 оны УИХ-ын сонгуулиар МАН-аас нэр дэвшсэн Л.Энх-Амгалан 43.1%-ийн саналаар, бие даан нэр дэвшигч Ц.Даваасүрэн 34.6%-иар тус тус сонгогдсон байна.

2012 онд Хөвсгөл аймгийн ИТХ-д нийт 41 төлөөлөгч ажиллаж байгаагаас 13 нь АН-аас, 26 нь МАН-аас, 2 төлөөлөгч МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс сонгогджээ. Аймгийн ИТХ-ын 9 тэргүүлэгчийн 7 нь тойргоос, 2 нь намын жагсаалтаар сонгогдсон бол үлдсэн 32 төлөөлөгчдийн 21 нь тойргоос, 11 нь намын жагсаалтаар гарч ирсэн байна.

***Мөрөн сум***

Мөрөн сум нь аймгийн төвийн сум бөгөөд Улаанбаатар хороос 313 км зайд оршдог, 13 багтай. Аймгийн ИТХ-д нийт 31 хүн ажиллаж байгаагаас 21 нь тойргоос сонгогдож, 10 нь намын жагсаалтаар гарч иржээ. Нийт төлөөлөгчдийн 20 нь МАН-аас, 11 нь АН-аас сонгогдсон байна.

***Эрдэнэбулган сум***

Эрдэнэбулган сум нь Улаанбаатар хотоос 700 км, аймгийн төвөөс 260 км зайтай оршдог, хүн амын тоогоороо Хөвсгөл аймгийн нийт 24 сумаас 22-т ордог, нийт 5 нь багтай. ИТХ-ын нийт 21 төлөөлөгчдийн 3 нь МАН, 18 нь АН-ынх байна.

***Тариалан сум***

Тариалан сум нь Улаанбаатар хотоос 521 км, аймгийн төвөөс 160 км зайд оршдог, Хөвсгөл аймагтаа Мөрөн сумын дараа орох томоохон сумдын нэг бөгөөд нийт 6 багтай. ИТХ-д нийт 27 төлөөлөгчөөс 18 нь тойргоос, 9 нь намын жагсаалтаар сонгогдсон. Үүнээс МАН-аас 15, АН-аас 12 төлөөлөгч сонгогдсон байна.

## Хэнтий аймаг

Хэнтий аймаг нь 18 сум, 4 тосгон, 88 багтай.

**Хүн ам зүйн мэдээлэл**

Хэнтий аймгийн хүн амын тоо 2013 оны эцсийн байдлаар 67.6 мянга болж өмнөх оныхоос 0.1 хувиар өссөн ч 1989 оныхоос 8.4%-иар буурчээ. 2013 оны байдлаар хүн амын 66.5% нь хөдөөд, 33.5% нь хотод амьдарч байна.

*Хүснэгт 55. Хэнтий аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн*

| Байршил | 1989 | 2000 | 2010 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 73.8 | 71.0 | 65.9 | 67.5 | 67.6 | 71.2 |
| Үүнээс: Аймгийн төв | 27.3 | 27.9 | 30.6 | 20.5 | 22.6 | - |
| Хөдөөгийн | 46.5 | 43.1 | 35.3 | 47.0 | 45.0 | - |
| Сонгогдсон сумын хүн амын тоо | | | | | | |
| Хэрлэн | 18.3 | 18.0 | 19.0 | 19.3 | 19.2 | 20.6 |
| Батноров | 8.5 | 6.6 | 5.1 | 5.9 | 5.4 | 5.4 |
| Өмнөдэлгэр | 3.7 | 5.7 | 5.1 | 5.2 | 5.2 | 5.3 |

Тус аймгийн хүн амын тоо 2014 онд 2013 оныхоос 3.6 мянган хүнээр өссөн байна. Хэрлэн, Батноров, Өмнөдэлгэр сумдын хүн амын тоо 5.3-20.6 мянгад хүрч аймгийнхаа томоохон сумдын тоонд орж байна. Батноров сумын Бэрх баг 866 өрх, 2444 хүн амтай бөгөөд аймгийнхаа хамгийн том баг болно.

2013 онд аймгийн нийт өрхийн тоо 21.9 мянга болж, өмнөх оныхоос 0.4 хувиар өссөн байна. Нэг өрхийн ам бүлийн тоо аймгийн дунджаар 3.17 буюу улсын дунджаас 0.63 пунктээр бага байна.

Хүн амын нягтаршилаар нь авч үзвэл, Хэрлэн суманд 1 км$^2$ нутаг дэвсгэрт 5.08 хүн, Батноров суманд 1.09, Өмнөдэлгэр суманд 0.48 хүн ам ноогдож байна. Сонгуулийн насны хүн ам Хэрлэн сумын нийт хүн амын 66.1%, Батноров сумын хувьд 63.6% , Өмнөдэлгэр суманд 64.1%-ийг тус тус эзэлж байна.

**Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал**

Аймгийн хөгжилд 2013 онд улсын төсвөөс 7.7 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оныхоос 75.5% өмнөх оныхоос 3.4 дахин нэмэгдсэн байна.

2013 оны байдлаар аймгийн нийт үйлдвэрлэл 396.1 тэрбум төгрөг, үүнээс аймгийн ДНБ 274.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 33.1% буюу 68.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн ДНБ-ий 61.3%-ийг хөдөө аж ахуй, 13.6%-ийг аж үйлдвэр, барилга, 13.6%-ийг бусад үйлчилгээний салбар эзэлж байна. Улсын ДНБ-ий 1.4%-ийг Хэнтий аймаг бүрдүүлж байна.

**Улс төрийн нөхцөл байдал**

Ерөнхийлөгчийн сонгуулийн Хэнтий аймаг дахь ирц 1993 онд 94.8% буюу хамгийн сайн ирцтэй байсан бол 2009 онд 67.7%, 2013 онд 66.5% болж буурсан байна. 2013 оны сонгуулиар МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэ 62.5%-ийн санал авсан ялалт байгуулсан нь АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдоржоос 29.1%-ийн саналаар илүү байжээ.

УИХ-ын сонгуулийн ирц 1992 онд 97.9% буюу хамгийн өндөр байсан бол 2008 онд 77.2%, 2012 онд 69.0% болж өмнөх сонуулиас 8.2%-иар буурсан байна. 2012 оны УИХ-ын сонгуулиар Б.Бат-эрдэнэ 37.9% (МАН), Б.Гарамгайбаатар АН-аас нэр дэвшиж 34.3%-ийн саналаар тус тус сонгогдсон байна.

Орон нутгийн сонгуулийн үр дүнгээр 2012 онд Хэнтий аймгийн ИТХ-д нийт 39 төлөөлөгч байгаагаас 10 нь тэргүүлэгч, 29 нь төлөөлөгч байна. Нийт төлөөлөгчдийн 19 нь тойргоос, 10 нь намын жагсаалтаар гарч ирсэн бөгөөд төлөөлөгчдийн 15 нь АН-аас, 14 нь МАН-аас сонгогджээ. УИХ болон орон нутгийн сонгуулийн аль алинд нь 2 том нам ойролцоо суудал авчээ.

***Хэрлэн сум***

Хэрлэн сум нь Хэнтий аймгийн төвийн сум бөгөөд Улаанбаатар хотоос 330 км-т оршдог, нийт 8 багтай. ИТХ-ын нийт 28 төлөөлөгчийн 7 нь МАН-аас, 20 нь АН-аас, 1 нь ИЗНН-аас сонгогдон ажиллаж байна.

***Батноров сум***

Батноров сум нь Улаанбаатар хотоос 430 км зайд орших 7 багтай сум юм. ИТХ-д нийт 27 төлөөлөгч сонгогдон ажиллаж байгаагийн 18 нь тойргоос, 9 нь намын жагсаалтаар сонгогдсон. Нийт төлөөлөгчдийн 9 нь МАН-аас, 18 нь АН-аас сонгогджээ.

***Өмнөдэлгэр сум***

Өмнөдэлгэр сум нь Улаанбаатар хотоос 300 км зайд оршдог, 7 багтай сум юм. ИТХ-ын нийт 27 төлөөлөгчийн 18 нь тойргоос, 9 нь намын жагсаалтаар сонгогдсон байна. Үүнээс 10 нь МАН-аас, 17 нь бие даан нэр дэвшсэн төлөөлөгчид байгаа нь бусад сумдаас сонирхолтой үр дүнг харуулж байна.

## Ховд аймаг

Ховд аймаг нь Монгол орны баруун бүсийн төв бөгөөд нийт 17 сум, 91 багтай аймаг юм.

**Хүн ам зүйн мэдээлэл**

Ховд аймгийн хүн амын тоо 2013 оны эцсийн байдлаар 79.0 мянга болж өмнөх оныхоос 0.9 хувиар буюу 0.7 мянган хүнээр, 1989 оныхоос 2.4 хувиар өсчээ.

***Хүснэгт 56. Ховд аймгийн хүн ам, хот хөдөөгөөр, мянган хүн***

| Байршил | 1989 | 2000 | 2010 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 76.6 | 86.8 | 76.8 | 78.3 | 79.0 | 81.5 |
| Үүнээс: Аймгийн төв | 25.2 | 26.0 | 29.3 | 25.2 | 25.9 | - |
| Хөдөөгийн | 51.4 | 60.8 | 47.5 | 53.1 | 53.1 | - |
| Сонгогдсон сумын хүн амын тоо | | | | | | |
| Жаргалант | 24.9 | 25.7 | 29.0 | 25.3 | 26.3 | 26.7 |
| Булган | 8.8 | 9.0 | 8.4 | 9.0 | 9.2 | 9.5 |
| Манхан | 3.7 | 5.0 | 3.4 | 4.0 | 4.0 | 4.0 |

Тус аймгийн хүн амын тоо 2014 онд 2013 оныхоос 2.5 мянган хүнээр өссөн бол 1989 оныхоос 4.9 хувиар өсчээ. Булган, Манхан сумдын хүн амын тоо 4.0-9.5 мянгад хүрч аймгийнхаа томоохон сумдын тоонд орж байна. Хөдөөгийн хүн амын хүрээгээр авч үзвэл тус аймгийн хамгийн олон хүн амтай сум нь 9.5 мянган хүн амтай Булган сум юм.

2013 онд аймгийн нийт өрхийн тоо 20.6 мянга болж, өмнөх оныхоос 2.9%-иар өссөн байна. Нэг өрхийн ам бүлийн тоо аймгийн дунджаар 3.89 байна. Ховд, Мандал зэрэг сумдад аймгийн дунджаас олон буюу 3.90-4.45 хүн, Жаргалантад аймгийн дунджаас цөөн буюу 3.63-3.87 хүнтэй байна.

Хүн амын нягтаршилаар нь авч үзвэл, 1 $км^2$ нутаг дэвсгэрт ноогдох хүн ам Жаргалант суманд 360.7 хүн, Булган суманд 1.1, Манхан суманд 0.91 байна. Сонгуулийн насны хүн ам Жаргалант сумын нийт хүн амын 67.1%, Булган сумын нийт хүн амын 61.9%, Манхан сумын нийт хүн амын 60.3%-ийг тус тус эзэлж байна.

**Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал**

Аймгийн хөгжилд 2013 онд улсын төсвөөс 39.6 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оныхоос 44.0%-иар бага байна. Орон нутгийн төсвөөс 72.5%-ийг хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оныхоос 4.7 дахин нэмэгдсэн байна.

2013 оны байдлаар нийт үйлдвэрлэл 465.5 тэрбум төгрөг, үүнээс аймгийн ДНБ 254.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 41.6% буюу 74.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн ДНБ-ий 49.5%-ийг хөдөө аж ахуй, 15.1%-ийн аж үйлдвэр, барилга, 19.6%-ийг бусад үйлчилгээний салбар эзэлж байна. Улсын ДНБ-ий 1.3%-ийг Ховд аймаг үйлдвэрлэж байна.

**Улс төрийн нөхцөл байдал**

Ховд аймгийн Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 1993 онд 95.7% буюу хамгийн сайн байсан бол, 2009 онд 74.4%, 2013 онд 63.4% болж өмнөх сонгуулиас 11.0%-иар буурсан байна. 2013 оны сонгуулиар АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж 61.2%-ийн санал авч МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэээс 32.1%-иар илүү байсгаар ялалт байгуулжээ.

УИХ-ын сонгуулийн ирц 1992 онд 97.9% байсан бол 2008 онд 79.5%, 2012 онд 72.4% болж өмнөх сонгуулиас 7.1%-иар буурчээ. 2012 оны сонгуулиар С.Бямбацогт 42.0% (МАН), МАХН-МҮАН-ын "Шударга ёс" эвслээс нэр дэвшсэн Д.Батцогт 32.6%-ийн санал авч тус тус сонгогдсон байна.

Ховд аймгийн ИТХ-д нийт 41 төлөөлөгч ажиллаж байна. Нийт 11 тэргүүлэгчийн 8 нь АН-аас, 3 нь МАН-аас сонгогдсон. Үлдсэн 30 төлөөлөгчийн 12 нь тойргоос, 7 нь намын жагсаалтаар сонгогдсоноос 19 нь АН-аас, 10 нь МАН-аас, 1 нь МАХН-МҮАН-ын "Шударга ёс" эвслээс сонгогдсон байна. УИХ-ын сонгуульд МАН, МАХН-МҮАН-ын "Шударга ёс" эвсэл илүү санал авсан бол орон нутгийн сонгуульд АН илүү саналтай байсан байна.

***Жаргалант сум***

Жаргалант нь Ховд аймгийн төвийн сум ба Улаанбаатар хотоос 1487 км-т оршдог, нийт 12 багтай. Сумын ИТХ-д нийт 31 төлөөлөгчөөс 21 нь тойргоос, 10 нь намын жагсаалтаар сонгогдсон байна. Үүнээс 15 нь МАН-аас, 14 нь АН-аас, 1 нь МАХН-МҮАН-ын Шудрага ёс эвслээс, 1 нь бие даан нэр дэвшиж сонгогдон ажиллаж байна.

***Булган сум***

Булган сум нь Улаанбаатар хотоос 1855 км, аймгийн төвөөс 385 км-т оршдог аймгийн төвийн сумын дараа орох том сум юм. Тус сум нийт 6 нь багтай. Сумын ИТХ-д нийт 31 төлөөлөгчийн 21 нь тойргоос, 10 нь намын жагсаалтаар сонгогдсон байна. Нийт төлөөлөгчдийн 22 нь МАН-аас, 8 нь АН-аас, 1 нь МАХН-МҮАН-ын "Шударга ёс" эвслээс нэр дэвшиж сонгогдон ажиллаж байна.

***Манхан сум***

Манхан сум нь Улаанбаатар хотоос 1336 км, аймгийн төвөөс 87 км-т оршдог бөгөөд нийт 6 багтай. ИТХ-д нийт 21 төлөөлөгчөөс 14 нь тойргоос, 7 нь намын жагсаалтаар сонгогдсон. Нийт төлөөлөгчдийн 14 нь МАН-аас, 6 нь АН-аас, 1 нь МАХН-МҮАН-ын "Шударга ёс" эвслээс нэр дэвшиж сонгогдон ажиллаж байна.

# СУДАЛГААНЫ АСУУЛГА, УДИРДАМЖ

## Тоон судалгааны асуулга

| № | АСУУЛТ | ХАРИУЛТ |
|---|---|---|
| | **1. ШҮҮЛТҮҮР** | |
| **S*1** | Танай ө рх уг байршилд 6 болон тү ү нээс дээш сар амьдарч байгаа юу? | Тийм – 1<br>Ү гү й – 2 – Судалгаа дуусгах |
| **S*2** | Та болон танай гэр бү лийн хэн нэгэн гишү ү н орон нутгийнхаа захиргаа, эсвэл ИТХ-д ажилладаг уу? | Тийм – 1 – Судалгаа дуусгах<br>Ү гү й – 2 |
| | **2. ИТХ-ЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА, ҮНЭЛГЭЭ** | |
| | **ИТХ-ын талаарх нийтлэг ойлголт**<br>Одоо тантай Иргэдийн Тө лө ө лө гчдийн Хурлын талаар ярилцах болно. | |
